



ЖОНФУ КОНСТРАКШН ИНЖЕНЕРИНГ ХХК

Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл (УБХТАЗТТ):
“Сэлбэ гол”-ын авто замын барилгын ажил
ГҮЙЦЭТГЭГЧИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
- Эцсийн батлагдсан тайлан

Засварын түүх:

Хувилбар	Огноо	Боловсруулсан	Баталсан/ Санал өгсөн
Г-БОНМТ-ний төслийн анхны хувилбар	2025.07.09	ЖОНФУ КОНСТРАКШН ИНЖЕНЕРИНГ	
Г-БОНМТ-ний төслийн сүүлийн хувилбарын төсөл	2025.08.06	ЖОНФУ КОНСТРАКШН ИНЖЕНЕРИНГ	ТХН, СТП (2025.07.29)
Г-БОНМТ-ний төслийн сүүлийн хувилбар	2025.09.01	ЖОНФУ КОНСТРАКШН ИНЖЕНЕРИНГ	ТХН, СТП (2025.08.27)

Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл (УБХТАЗТТ): “Сэлбэ гол”-ын авто замын барилгын ажил	0
1. Төслийн танилцуулга.....	9
1.1. Оршил	9
1.2. Гүйцэтгэгчийн мэдээлэл.....	9
1.3. Барилгын ажлын үргэлжлэх хугацаа ба цар хүрээ.....	9
1.4. Тоног төхөөрөмж, машин механизм, ажиллах хүчний төлөвлөлтийн тойм.....	11
1.5. Тоног төхөөрөмж, машин механизмын төлөвлөлт	13
1.6. Ажиллах хүчний төлөвлөлт	14
1.7. Г-БОНМТ-ний бүтэц ба дэд төлөвлөгөөнүүдийн уялдаа холбоо	14
2. Байгаль орчин, нийгмийн төлөв байдлын тойм	17
2.1. Одоогийн байгаль орчны нөхцөл байдал ба гүйцэтгэгчийн арга хэмжээ	17
2.2. Нийгмийн төлөв байдлын тойм	27
2.2.1. Нөлөөллийн бүсийн эмзэг хүлээн авагчдыг тодорхойлох	31
3. Хууль эрх зүй, байгууллагын тогтолцоо	35
3.1. Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн шаардлагыг хангах тухай	35
3.2. Монгол Улсын холбогдох хууль журам.....	36
4. Үүрэг, хариуцлага	41
5. Байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	45
5.1. Барилгын ажлын өмнөх шат	45
5.2. Барилгын ажлын шат	55
5.3. Ашиглалтын үе.....	63
6. Хяналтын төлөвлөгөө	69
7. Байгаль орчин, нийгмийн асуудлаар тайлагнах үйл явц, баримт бичгийн хадгалалт	76
7.1. Тайлагнах үүрэг ба хуваарь.....	76
7.2. Баримт бичиг хөтлөлт, архив	78
8. Сургалт хийх ба чадавхыг бэхжүүлэх төлөвлөгөө.....	79
8.1 Сургалтын хөтөлбөрийн зорилго.....	79
8.2 Цар хүрээ, үүрэг хариуцлага.....	79
8.3 Сургалтын Хөтөлбөрийн Хураангуй.....	80
8.4 Хяналт-шинжилгээ, бүртгэл хөтлөлт	82
9. Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ)	82

9.1. Төслийн үндэслэл	82
9.2. Талуудын оролцоог хангах төлөвлөгөөний зорилго	83
9.3. Хууль эрхзүй, бодлогын цар хүрээ	83
9.4. Нийгмийн нөхцөл байдал, мэдрэмтгий хүлээн авагч	83
9.5. Оролцогч талуудын бүлэг	84
9.6. Оролцооны арга зүй, үйл ажиллагаа	84
9.7. Оролцогч талуудын зураглалыг дараах байдлаар ангилж байна:	85
9.8. Мэдээллийг цаг тухайд нь, хүртээмжтэй хүргэх боломжоор хангах оролцооны стратеги, харилцааны хэрэгсэл:	85
9.9. Талуудын оролцооны хуваарь	85
9.10. Санал, гомдол барагдуулах механизм (СГБМ)	86
9.11. Гүйцэтгэгчийн хүлээх хариуцлага	87
9.12. ТОХТ-нд хяналт-шинжилгээ хийх	87
10. Санал, гомдол барагдуулах механизм (Олон нийтийн ба Ажилчдын)	88
11. Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө (ОБҮАХАХТ)	92
11.1. Оршил	92
11.2. Онцгой байдлын бэлэн байдал	92
11.3. Үүрэг, хариуцлага	93
11.4. Үүсэж болох онцгой байдлын нөхцөл	95
11.5. Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний явц	95
11.6. Ослын шалгалт, баримтжуулалт	96
11.7. Сургалт	96
11.8. Хяналт тавих, Тайлагнах	97
11.9. ОБҮАХАХТ-ний хэрэгжилт, хяналтын хуваарь	97
11.10. СГБМ-ийн үйл явц, шийдвэрлэх хуваарь	99
11.11. КОВИД-19-ийн хариу арга хэмжээний төлөвлөгөө	100
12. Замын хөдөлгөөн, явган хүний аюулгүй байдлын менежмент	101
13. Хог хаягдал, Аюултай материалын менежмент	106
13.1. Оршил	106
13.2. Хууль эрх зүй, бодлогын хүрээ	106
13.3. Байгууллагын бүтэц ба үүрэг, хариуцлага	107
13.4. Хог хаягдлын менежментийн зарчим, шатлал	107
13.5. Хог хаягдлын төрөл, ангилал, хадгалалт, устгал	108
13.6. Хог хаягдалтай харьцах, хадгалах, тээвэрлэх журам	110

13.7. Хориотой үйлдлүүд.....	110
13.8. Сургалт явуулах ба Мэдээлэл олгох	111
13.9. Хянах, тайлагнах.....	111
14. Г-БОНМТ-г хэрэгжүүлэх төсөв	112
15. Г-БОНМТ-ний шинэчлэлт, өөрчлөлт	114
16. Хавсралт.....	116
Хавсралт 1: Гэнэтийн олдворын үед ажиллах журам.....	116
Хавсралт 2: Хөдөлмөрийн менежментийн журам (ХМЖ)	116
Хавсралт 2.1: Байгууллагын дотоод ХМЖ (ХАБЭА журам).....	116
Хавсралт 3: Хөдөлгөөн зохион байгуулалтын төлөвлөгөө (ХЗБТ).....	116
Хавсралт 4: Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэм (БОНҮАД).....	116
Хавсралт 5: Кэмпиин зохион байгуулалтын төлөвлөгөө	116
Хавсралт 6: Гомдол гаргах маягт (Олон нийт ба ажилчдын).....	116
Хавсралт 7: Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө.....	116
Хавсралт 7.1: Анхны тусламжийн төлөвлөгөө.....	116
Хавсралт 7.2: Онцгой нөхцөлд ажиллах журам.....	116
Хавсралт 8: Хог хаягдал зайлуулах ба бүртгэл хөтлөх маягтууд.....	116
Хавсралт 9: Нөлөөлөлд өртсөн моддын фото зургууд	116
Хавсралт 10: Төслийн трассын дагуух барилга байгууламж, аж ахуй нэгжүүд, үйлчилгээний байгууллагуудын фото зургууд	116
Хавсралт 11: Байгууллагын бүтэц	116
Хавсралт 12: Өнгөн хөрс хуулах, хадгалах, дахин ашиглах төлөвлөгөө	116
Хавсралт 12.1: Гүйцэтгэгчийн Өнгөн хөрстэй ажиллах журам	116
Хавсралт 12.2: Гүйцэтгэгчийн Газар хөндөх журам	116
Хавсралт 13: Ундны усны чанарын хяналтын төлөвлөгөө	116
Хавсралт 14: Барилгын ажлын үеийн тоосжилт, дуу чимээ, чичиргээний хяналтын төлөвлөгөө	116
Хавсралт 15: Гүйцэтгэгчийн сургалтын төлөвлөгөө	116
Хавсралт 16: Байгаль орчны хяналт-шинжилгээний өдөр тутмын хяналтын хуудас	116
Хавсралт 17: Ногоон байгууламж, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	116
Хавсралт 18: 2025, 2026 оны ажлын төлөвлөгөө ба хуваарь	117

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төсөллөсөн авто замын зураг төслийн 3D дүрслэл.....	9
Зураг 2. Төслийн зам (“Сэлбэ гол”-ын зам).....	11
Зураг 3. Дуу чимээний хэмжилт хийх байршлуудын газрын зураг	19
Зураг 4 Газрын гадаргын ус дээж авах цэгүүд	20
Зураг 5. Газрын гүний усны дээж авах цэгүүд	22
Зураг 6. Одоо байгаа усны худгууд	23
Зураг 7. Одоо байгаа мод, бут сөөг.....	25
Зураг 8. Хяналтын цэгүүд ба эмзэг хүлээн авагчид.....	33
Зураг 9. Кемпийн зохион байгуулалтын зураг	68
Зураг 10. СГБМ	90
Зураг 11. Барилгын ажлын хэсгүүд – ТХЗБТ-ний хэсгүүд	102
Зураг 12. ТХЗБТ-ний жишээ зураг	105

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Ажлын төлөвлөгөө, хуваарийн тойм	12
Хүснэгт 2. 2025 оны сар тутмын тоног төхөөрөмжийн төлөвлөлт	14
Хүснэгт 3. 2025 оны сар тутмын ажиллах хүчний төлөвлөлт	14
Хүснэгт 4. Үндсэн хэсэг – Бүлгүүдийн уялдаа холбоо	14
Хүснэгт 5: Хавсралтууд – Дэд төлөвлөгөөнүүдийн уялдаа холбоо	15
Хүснэгт 6. Нүүлгэн шилжүүлэх моддын жагсаалт	25
Хүснэгт 7. Тодорхойлсон эмзэг нөлөөллийг хүлээн авагчид	31
Хүснэгт 8. Төслийн трассын дагуух бизнесийн болон үйлчилгээний байгууллагууд	33
Хүснэгт 9. Дэлхийн банкны БОНС-аас хамаарах, хэрэгжүүлэх арга хэмжээ	35
Хүснэгт 10. Байгаль орчны хяналтын төлөвлөгөө – Барилгын ажлын шат	69
Хүснэгт 11 Нийгэм, эдийн засаг, замын хөдөлгөөн, эрүүл мэнд, аюулгүй байдлын хяналтад зориулсан нэмэлт ГШҮ	73
Хүснэгт 12. Тайлагнах үүрэг, хариуцлага ба Тайлагнах хуваарь	76
Хүснэгт 13. Баримт бичиг хадгалах үүрэг, хариуцлага	78
Хүснэгт 14. Ерөнхий гүйцэтгэгчийн Сургалтын Хуваарь: Байгаль орчин, Нийгэм, Эрүүл мэнд, Аюулгүй байдал, Хүний нөөцөд тавигдах шаардлага	80
Хүснэгт 15. Оролцооны хуваарь	85
Хүснэгт 16. Шийдвэрлэх хугацаа	86
Хүснэгт 17. Гол зарчим	88
Хүснэгт 18. Гомдол гаргах сувгууд	89
Хүснэгт 19. Гомдлыг шийдвэрлэх үйл явц	89
Хүснэгт 20. Үүрэг, хариуцлага	90
Хүснэгт 21. Ажилчдын гомдол шийдвэрлэх механизм	91
Хүснэгт 22. ОБУАХАХТ-ний хэрэгжилт, хяналтын хуваарь	97
Хүснэгт 23. Сэлбэ голын авто замын төслийн зам хаах хураангуй төлөвлөгөө	102
Хүснэгт 24. Гол үүрэг, хариуцлага	107
Хүснэгт 25. Хог хаягдлын ангилал	108
Хүснэгт 26. Барилгын хог хаягдлын төрөл, зайлуулах арга	108
Хүснэгт 27. Үзүүлэлт ба амжилтын шалгуур	111
Хүснэгт 28. БОНМТ-г хэрэгжүүлэх төсөв	112

ТОВЧИЛСОН ҮГС

АТХ – Ажлын тоо хэмжээ

Г-БОНМТ – Гүйцэтгэгчийн Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө

Са – Кальци

ОНХА – Олон нийттэй харилцах ажилтан

СО – Нүүрстөрөгчийн дутуу исэл

Cr – Хром

Cu – Зэс

dB(A) – А жингийн дБ (децибел)

БОН – Байгаль орчин ба нийгэм

БОЭМАБ – Байгаль орчин, Эрүүл мэнд, Аюулгүй байдал

БОНБУ – Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

БОМТ – Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

ОБҮАХАТ – Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө

ЯХАХҮАТ – Яаралтай хариу арга хэмжээний үйл ажиллагааны төлөвлөгөө

БОНҮАД – Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэм

БОНТБУ – Байгаль орчин, нийгмийн төлөв байдлын үнэлгээ

БОНХ – Байгаль орчин, нийгмийн хүрээ

БОНС – Байгаль орчин, нийгмийн стандарт

ЖСХ – Жендэрт суурилсан хүчирхийлэл

Гео-индекс – Гео-хуримтлалын индекс

ГБМ – Гомдол барагдуулах механизм

ХДХВ/ДОХ – Хүний дархлал хомсдолын вирус халдвар ба Дархлалын олдмол

хомсдол

ОУБХХ – Олон улсын байгаль хамгаалах холбоо

K₂O – Калижуулсан исэл

ГАА – Газар ашиглалтын алба

ХНМТ – Хүний нөөцийн менежментийн төлөвлөгөө

Mg – Магни

MNS – Монгол Улсын үндэсний стандарт(ууд)

УБХЗАА – Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба

ОБЕГ – Онцгой байдлын ерөнхий газар

Ni – Никель

NO₂ – Азотын давхар исэл

ТББ – Төрийн бус байгууллага

ХАБЭА – Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

P₂O₅ – Фосфорын пентаоксид

НӨХ – Төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүс

Pb – Хар тугалга

PM₁₀ – Тоосонцор (≤10 микрон)

ТХН – Төсөл хэрэгжүүлэх нэгж

XXX – Хувийн хамгаалах хэрэгсэл

ГС – Гүйцэтгэлийн стандарт

НШТ – Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө

НЗХГ – Нийслэлийн замын хөгжлийн газар

АЗЗТ – Авто замын зурвас талбай

БМХД – Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, дарамт

ОТОТ – Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө

ТБООБА – Талбайн байгаль орчин, аюулгүй байдлын ажилтан

БД – Бэлгийн дарамт

SO₂ – Хүхрийн давхар исэл

ХЗБТ – Хөдөлгөөн зохион байгуулалтын төлөвлөгөө

НХТ – Нийт хөвмөл тоосонцор

НБОГ – Нийслэлийн байгаль орчны газар

УБХТАЗТТ – Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл

ДБ – Дэлхийн банк

ХХМТ – Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

УЧИ – Усны чанарын индекс

Zn – Цайр

°C – Цельсийн хэм

ХЭМЖИХ НЭГЖ

см – сантиметр

дм² – дециметр квадрат

dS/m – дециСиенс/метр

ГЖ – гегажоуль

hp – морины хүч

км – километр

кВ.ц – киловатт цаг

м – метр

м/сек – метр секунд

м² – метр квадрат

м³/цаг – метр куб/цаг

м³/сек – метр куб/секунд

мг-экв/100г – миллиграмм эквивалент/100 грамм

мг/кг – Килограммд миллиграмм

мг/м³ – микрограмм/метр куб

мЖ/см² – милиЖоуль/сантиметр квадрат

мЖ/м² – милиЖоуль/метр квадрат

мм – миллиметр

МВт цаг – мегаватт/цаг

Ш – ширхэг

μg/м³ – микрограмм/ метр куб

1. Төслийн танилцуулга

1.1. Оршил

“Сэлбэ гол”-ын авто замын дэд төсөл нь Дэлхийн банкны санхүүжилттэйгээр Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл” (УБХТАЗТТ)-ийн нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Төслийн зорилго нь Улаанбаатар хотод нэгдсэн, тогтвортой тээврийн коридоруудыг хөгжүүлснээр замын хөдөлгөөний урсгалыг сайжруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхэд оршино.



Зураг 1. Төсөллөсөн авто замын зураг төслийн 3D дүрслэл

УБХТАЗТТ-ийн Бүрэлдэхүүн 1 (Нэгдсэн коридор)-ийн хүрээнд Сэлбэ голын авто зам нь Нарны замын зүүн өргөтгөлийн хамтаар Төрөл 2-ийн гудамжаар сонгогдсон. Төрөл 2-т хотын түгжрэлийг шийдвэрлэх, гэр хорооллын оршин суугчдын хүртээмжийг сайжруулах зорилгоор шинээр авто замын коридор байгуулах ажлууд хамаарна.

Сэлбэ голын авто замын дэд төсөл нь Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 7, 11, 12, 13-р хороодын нутаг дэвсгэрт шинээр 2.7 км авто зам бүтээн байгуулна. **Зураг 2**-т зураг төслийн шатны БОНМТ-аас авсан дэд төслийн газрын зургийг үзүүлэв. Уг авто зам нь Улаанбаатар хотын төвийн бүсийн ачааллыг бууруулж, авто замын холболтыг сайжруулах хойноос урагш чиглэсэн коридорын үүргийг гүйцэтгэнэ.

1.2. Гүйцэтгэгчийн мэдээлэл

Сэлбэ голын замын дэд төслийн барилгын ажлыг БНХАУ-д бүртгэлтэй Жонфу Констракшн Инженеринг ХХК олон улсын зам барилгын компани хэрэгжүүлнэ. Гүйцэтгэгч нь бүхий л ажлыг гэрээний зураг, төслийн техник, байгаль орчин, нийгмийн шаардлагын дагуу гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

1.3. Барилгын ажлын үргэлжлэх хугацаа ба цар хүрээ

Барилгын ажлыг 2025 оны 7-р сард эхлүүлж, 2026 оны 10-р сард дуусгахаар төлөвлөсөн. Нийт барилгын ажлын хугацаа нь 480 хоног байна. Сэлбэ голын авто замын дэд төслийн

Гүйцэтгэгчийн хувьд бидний ажил нь ногоон талбайд иж бүрэн зам барилгын ажлыг эхлүүлж, гүйцэтгэх юм. Барилгын ажлын цар хүрээнд дараах үндсэн ажлууд багтана (зөвхөн доорх ажлуудаар хязгаарлагдахгүй):

- Талбайн бэлтгэл, газар шорооны ажил, тухайлбал талбайн цэвэрлэгээ, ухмалын ажил, далан байгуулах, тэгшилгээ
- Хучилтын бат бэх, тогтвортой байдлыг хангах замын суурийн ажил, тухайлбал суурийн доод үе, суурийн үеүүд
- Хөдөлгөөний ачааллыг тэсвэрлэх бат бэх, бүх улиралд тохирсон хучилтын гадаргууг бий болгохын тулд асфальтбетон хучилт хийх
- Борооны усыг зайлуулах, үерийн эрсдэлийг бууруулахын тулд хоолой, замын хажуугийн ус зайлуулах шугам зэрэг борооны ус зайлуулах систем барих
- Явган хүний зам, гарц, эмзэг зам ашиглагчдад зориулсан шийдэл зэргийг багтаасан явган хүний дэд бүтцийг суурилуулах
- Уулзвар барих, замын хөдөлгөөний зохицуулах дохио, шаардлагатай бол эргэх эгнээгээр хангах
- Цахилгааны шугам, холбооны кабель, усан хангамжийн дэд бүтэц гэх мэт Инженерийн шугам сүлжээний нүүлгэн шилжүүлэлт, хамгаалалт
- Аюулгүй байдал, үзэгдэх орчныг нэмэгдүүлэх үүднээс гудамжны гэрэлтүүлэг, замын тэмдэг, тэмдэглэгээ суурилуулах
- Төслийн уур амьсгалын тэсвэртэй байдал, иргэдийн амьдралын тав тухыг нэмэгдүүлэхийн тулд ногоон байгууламж барих, тохижилт хийх.

Тус авто замыг явган зорчигч, унадаг дугуйчин, нийтийн тээврээр зорчигч, хувийн автомашины жолооч гэх мэт бүх төрлийн зам хэрэглэгчийн аюулгүй байдлыг нэмэгдүүлж, хүртээмжтэй байлгахын тулд Иж бүрэн гудамжны үзэл баримтлал, Аюулгүй системийн арга барилд тулгуурлан төсөллөж, бүтээн байгуулна.

Энэхүү Гүйцэтгэгчийн Байгаль орчин, Нийгмийн менежментийн төлөвлөгөө (Г-БОНМТ) нь барилгын ажлын үе шатанд болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, сөрөг нөлөөллийг бууруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, Монгол улсын хууль журам болон Дэлхийн банкны Байгаль орчин, Нийгмийн хүрээг (БОНХ) дагаж мөрдөхийн тулд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлж өгнө.

Г-БОНМТ, дагалдах хавсралтууд нь нөхцөл байдал, холбогдох эрсдэлүүд, талбайн нөхцөл, бүртгэгдсэн аливаа ослоос хамааран тогтмол шинэчлэгдэх баримт бичиг юм. Энэхүү төлөвлөгөөний Бүлэг 15-д шинэчлэлт, өөрчлөлтийн дэлгэрэнгүй мэдээллийг оруулав.



Зураг 2. Төслийн зам (“Сэлбэ гол”-ын зам)

1.4. Тоног төхөөрөмж, машин механизм, ажиллах хүчний төлөвлөлтийн тойм

Зам барилын ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, машин механизм, ажиллах хүчний урьдчилсан төлөвлөгөөг анхан шатны барилгын ажлын хуваарьт нийцүүлэн боловсруулсан. 2025–2026 оны нарийвчилсан ажлын төлөвлөгөө, хуваарийн төслийг **Хавсралт 18**-д оруулав.

Материалын үйлдвэрлэл:

Оршин суугчдын амгалан тайван байдал алдагдахаас сэргийлэхийн тулд суурьшлын бүсээс алслагдмал байршилд хоёр үйлдвэр байгуулахаар төлөвлөсөн:

- **Асфальтбетон хольцын үйлдвэр** – 1 нэгж (цагт 200 тоннын хүчин чадалтай)
- **Цемент-буталсан чулуун хольцын үйлдвэр** – 1 нэгж (цагт 800 тоннын хүчин чадалтай)

Үйлдвэрийг ашиглаж эхлэхээс өмнө тохиргоог хийнэ.

Тоног төхөөрөмж, машин механизм:

2025 оны барилгын улиралд сард дунджаар **10–25 нэгж** тоног төхөөрөмж, машин механизм ашиглах төлөвтэй байна. Энэ тооцоо нь урьдчилсан төлөвлөгөөнд тулгуурласан бөгөөд барилгын эцсийн хөтөлбөр, ажилбарын тооноос хамааран өөрчлөгдөж болно.

Ажиллах хүчний төлөвлөлт:

2025 оны 7-11 дүгээр сард сард **30-75 хүн** ажиллах шаардлагатай гэж тооцоолсон. Энэ тоог талбайн бодит гүйцэтгэл, шинэчилсэн ажлын хуваарьт үндэслэн илүү нарийвчилна.

Тайлбар:

Тоног төхөөрөмж, машин механизм болон ажиллах хүчнийг дайчлах төлөвлөгөөг эцсийн ажлын хөтөлбөр, талбайн бодит нөхцөлтэй уялдуулан **шинэчилж болно**. Аливаа ноцтой өөрчлөлт гарсан тохиолдолд Зөвлөх, Захиалагч, ТХН-д мэдэгдэж, хянуулж, батлуулсны дараа Г-БОНМТ-г шинэчилнэ.

Хүснэгт 1. Ажлын төлөвлөгөө, хуваарийн тойм

No.	Ажилбар	Үргэлжлэх хугацаа	Эхлэг огноо	Дуусах огноо
2025				
1	Ерөнхий ажил (тоног төхөөрөмж, машин механизм, ажиллах хүчнийг байршуулах, талбайн оффис, кемп, замын чиг сэргээх)	7 хоног	Пүрэв, 2025 оны 7-р сарын 17 – 8:00	Баасан, 2025 оны 7-р сарын 25 – 17:00
2	Цэвэрлэгээ ба Газар шорооны ажил	74 хоног	Бямба, 2025 оны 7-р сарын 26 - 8:00	Лхагва, 2025 оны 11-р сарын 08 – 17:00
3	Механикаар тогтворжуулсан шороон хана (MSE Wall)	72 хоног	Ням, 2025 оны 8-р сарын 10 - 8:00	Бямба, 2025 оны 11-р сарын 15 – 17:00
4	Тулц хана	42 хоног	Даваа, 2025 оны 8-р сарын 04 - 8:00	Мягмар, 2025 оны 9-р сарын 30 – 17:00
5	Налуугийн хамгаалалт	59 хоног	Баасан, 2025 оны 8-р сарын 22 - 8:00	Бямба, 2025 оны 11-р сарын 15 – 17:00
6	Голын налуугийн хамгаалалт	61 хоног	Баасан, 2025 оны 8-р сарын 08 - 8:00	Баасан, 2025 оны 10-р сарын 31 – 17:00
7	Ус зайлуулах байгууламж	28 хоног	Пүрэв, 2025 оны 7-р сарын 24 - 8:00	Бямба, 2025 оны 8-р сарын 30 – 17:00
8	Дөрвөлжин хоолой	29 хоног	Лхагва, 2025 оны 7-р сарын 23 - 8:00	Даваа, 2025 оны 9-р сарын 01 – 17:00
9	Инженерийн шугам сүлжээг шилжүүлэх	56 хоног	Лхагва, 2025 оны 7-р сарын 23 - 8:00	Лхагва, 2025 оны 10-р сарын 08 – 17:00
2026				
10	Газар шорооны ажил	11 хоног	Мягмар, 2026 оны 7-р сарын 07 – 8:00	Мягмар, 2026 оны 7-р сарын 21 – 17:00

11	Механикаар тогтворжуулсан шороон хана (MSE Wall)	31 хоног	Даваа, 2026 оны 4-р сарын 20 – 8:00	Даваа, 2026 оны 6-р сарын 01 – 17:00
12	Хучилтын ажил	104 хоног	Ням, 2026 оны 5-р сарын 10 – 8:00	Лхагва, 2026 оны 9-р сарын 30 – 17:00
13	Дугуйн зам барих	34 хоног	Лхагва, 2026 оны 8-р сарын 05 – 8:00	Ням, 2026 оны 9-р сарын 20 – 17:00
14	Явган хүний зам барих	36 хоног	Даваа, 2026 оны 6-р сарын 29 – 8:00	Бямба, 2026 оны 8-р сарын 15 – 17:00
15	Үйлчилгээний болон холбогч зам барих	30 хоног	Даваа, 2026 оны 7-р сарын 20 – 8:00	Баасан, 2026 оны 8-р сарын 28 – 17:00
16	Ус зайлуулах байгууламж болон замын хашлага суурилуулах	34 хоног	Лхагва, 2026 оны 4-р сарын 15 – 8:00	Даваа, 2026 оны 6-р сарын 01 – 17:00
17	Нөхөн сэргээлтийн ажил	35 хоног	Мягмар, 2026 оны 9-р сарын 01 – 8:00	Даваа, 2026 оны 10-р сарын 19 – 17:00
18	Ногоон байгууламжийн ажил (явган хүний зам, ногоон бүс)	41 хоног	Бямба, 2026 оны 9-р сарын 05 – 8:00	Баасан, 2026 оны 10-р сарын 30 – 17:00
19	Шат суурилуулах (явган хүний зам ба голын эрэг), замын тоноглол ажил	22 хоног	Бямба, 2026 оны 8-р сарын 15 – 8:00	Баасан, 2026 оны 10-р сарын 30 – 17:00
20	Гэрэлтүүлэг суурилуулах	38 хоног	Лхагва, 2026 оны 6-р сарын 03 – 8:00	Баасан, 2026 оны 7-р сарын 27 – 17:00
21	Замын хөдөлгөөний зохицуулах дохио суурилуулах (кабель, тоног төхөөрөмж)	22 хоног	Бямба, 2026 оны 8-р сарын 15 – 8:00	Даваа, 2026 оны 9-р сарын 14 – 17:00

1.5. Тоног төхөөрөмж, машин механизмын ТӨЛӨВЛӨЛТ

Үйлдвэр:

Материалын үйлдвэрлэлд зориулан нийт 2 үйлдвэрийг суурилуулна. Эдгээр нь суурьшлын бүсээс хол байрлах бөгөөд ашиглаж эхлэхээс өмнө үйлдвэрийн тохиргоог хийнэ.

- **Асфальтбетон холигч үйлдвэр:** 1 нэгж (хүчин чадал: 200 тонн/цаг)
- **Цемент-буталсан чулуу холигч үйлдвэр:** 1 нэгж (хүчин чадал: 800 тонн/цаг)

Тоног төхөөрөмж, машин механизм:

Зам барилгын ажилд ашиглагдах үндсэн хүчин чадлыг тоног төхөөрөмж, машин механизм бүрдүүлнэ. Шаардлагатай тоо хэмжээг барилгын ажлын хуваарь, ажлын тоо хэмжээний дагуу сар сараар төлөвлөсөн.

2025 оны барилгын улиралд сард 10-25 нэгж машин механизм ашиглана.

Хүснэгт 2. 2025 оны сар тутмын тоног төхөөрөмжийн төлөвлөлт

Сар	VII	VIII	IX	X	XI
Тоног төхөөрөмж	10 нэгж	20 нэгж	25 нэгж	20 нэгж	10 нэгж

1.6. Ажиллах хүчний төлөвлөлт

Ажиллах хүчний төлөвлөлт нь төслийн барилгын ажлын хуваарьтай уялдан сар сараар өөрчлөгдөнө. Дараах хүснэгтэд **2025 оны 7-11 дүгээр сард** төлөвлөсөн ажиллах хүчний тоог харуулав.

Хүснэгт 3. 2025 оны сар тутмын ажиллах хүчний төлөвлөлт

Сар	VII	VIII	IX	X	XI
Хүн хүч	50 нэгж	60 нэгж	75 нэгж	65 нэгж	30 нэгж

1.7. Г-БОНМТ-ний бүтэц ба дэд төлөвлөгөөнүүдийн уялдаа холбоо

Гүйцэтгэгчийн Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (Г-БОНМТ) нь төслийн хэрэгжилтийн явцад байгаль орчин, нийгмийн (БОН) эрсдэл, үүрэг хариуцлагыг зохицуулах иж бүрэн хэрэгсэл юм. Г-БОНМТ нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ), мөн Байгаль орчин, нийгмийн стандартад (БОНС) нийцсэн болно.

Энэхүү төлөвлөгөө нь хоёр нэгтгэсэн хэсгээс бүрдэнэ:

- **Үндсэн хэсэг (Бүлэг 1-15):** Эдгээр бүлэг нь төслийн нөхцөл, хууль эрх зүйн нийцэл, үүрэг хариуцлага, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, хяналт-шинжилгээ, тайлаг, онцгой байдлын төлөвлөлт, гомдлын менежмент, өөрчлөлт шинэчлэлтийн журам зэрэг асуудлыг хөндөнө.
- **Хавсралтууд:** Эдгээр нь үндсэн төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн техникийн дэд төлөвлөгөө, журмыг багтаасан.

Хүснэгт 4. Үндсэн хэсэг – Бүлгүүдийн уялдаа холбоо

Бүлэг	Зорилго	Хавсралт дах гол дэд төлөвлөгөөнүүд
Бүлэг 1–3: Суурь мэдээлэл ба хууль эрх зүйн орчин	Төслийн танилцуулга, байгаль орчин, нийгмийн төлөв байдал, ерөнхий	Хавсралт 9, 10, 18

	хэрэгжилтийн хуваарь болон Монгол Улс, Дэлхийн банкны шаардлагууд.	
Бүлэг 4–5: Үүрэг хариуцлага ба сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Байгууллагын үүрэг хариуцлага, барилгын ажлын өмнөх үеэс барилгын ажил ба ашиглалтын үеийн сөрөг нөлөөллийг бууруулах үе шаттай арга хэмжээг тодорхойлох.	Хавсралт 1–5, 12, 12.1, 12.2
Бүлэг 6–7: Хяналт тавих, тайлагнах	Хяналт-шинжилгээний үзүүлэлт, давтамж, арга зүй, тайлангийн маягт.	Хавсралт 13, 14, 16
Бүлэг 8: Сургалт, чадавх бэхжүүлэх	Байгаль орчны болон ХАБЭА-ын сургалт, танилцуулга, мэдлэг олгох хөтөлбөрүүд.	Хавсралт 2.1, 7.1, 15
Бүлэг 9–10: Талуудын оролцоо, СГШМ	Талуудын оролцооны стратеги, ажилчид ба олон нийтийн санал, гомдлыг шийдвэрлэх механизм.	Хавсралт 6, 10
Бүлэг 11–12: Онцгой байдал, Замын хөдөлгөөний зохицуулалт	Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө (ОБҮАХАТ), COVID-19-ийн хариу арга хэмжээ, анхны тусламж, замын хөдөлгөөн болон явган зорчигчдын аюулгүй байдал	Хавсралт 3, 7, 7.1, 7.2
Бүлэг 13: Хог хаягдал болон аюултай материалын менежмент	Хог хаягдлын менежментийн шатлал, хог хаягдлыг зайлуулах журам, баримтжуулалт.	Хавсралт 4, 5, 8
Бүлэг 14: Төсөв	Сөрөг нөлөөллийг бууруулах болон хяналт-шинжилгээний арга хэмжээг хэрэгжүүлэх зардлын тойм	Бүх хавсралтаар мэдээлэв
Бүлэг 15: Г-БОНМТ-ний шинэчлэлт, нэмэлт өөрчлөлт	Хэрэгжилтийн явцад Г-БОНМТ-г шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах нөхцөл, журам, баримтжуулалт.	Засварын түүхийн хүснэгт

Хүснэгт 5: Хавсралтууд – Дэд төлөвлөгөөнүүдийн уялдаа холбоо

Хавсралт	Гарчиг	Холбогдох бүлэг	Зорилго
Хавсралт 1	Гэнэтийн олдворын үед ажиллах журам	Бүлэг 5.1, 11	Газар шорооны ажлын үеийн соёлын өвийн хамгаалалт
Хавсралт 2	Хөдөлмөрийн менежментийн журам	Бүлэг 3.2, 5.1, 10	Ажилчдын эрх, нөхцөл болон ГБМ
Хавсралт 2.1	Байгууллагын дотоод ХМЖ (ХАБЭА журам)	Бүлэг 4, 8, 11	ХАБЭА-н сургалт, стандарт ажиллагааны журам
Хавсралт 3	Хөдөлгөөн зохион байгуулалтын төлөвлөгөө (ХЗБТ)	Бүлэг 5.2, 9, 12	Замын хөдөлгөөн, явган зорчигчдын аюулгүй байдал
Хавсралт 4	Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэм (БОНҮАД)	Бүлэг 5, 7, 13	БОН-ийн сайн туршлага

Хавсралт 5	Кэмпийн зохион байгуулалтын төлөвлөгөө	Бүлэг 5.1, 13	Ажилчдын байр, ариун цэвэр
Хавсралт 6	Гомдол гаргах маягт	Бүлэг 9–10	ГБМ-ын стандарт маягт
Хавсралт 7	Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө	Бүлэг 11	Онцгой байдлын үеийн холбоо барих утас, хариу арга хэмжээний маягтууд
Хавсралт 7.1	Анхны тусламжийн төлөвлөгөө	Бүлэг 4, 11	Анхны тусламжийн тоног төхөөрөмж, тусламжийн баг.
Хавсралт 7.2	Гүйцэтгэгчийн Онцгой нөхцөлд ажиллах журам	Бүлэг 1	Гүйцэтгэгчийн ОНАЖ, стандарт ажиллагааны журам
Хавсралт 8	Хог хаягдал зайлуулах ба бүртгэл хөтлөх маягтууд	Бүлэг 13	Хог хаягдлын менежментийн бүртгэл
Хавсралт 9	Нөлөөлөлд өртсөн моддын фото зургууд	Бүлэг 2.1, 5.2	Ногоон байгууламжийн төлөв байдал
Хавсралт 10	Төслийн трассын дагуух барилга байгууламж, аж ахуй нэгжүүд, үйлчилгээний байгууллагуудын фото зургууд	Бүлэг 2.2, 5.2, 9	БОН-ийн нөхцөл байдлын баталгаажуулалт
Хавсралт 11	Байгууллагын бүтэц	Бүлэг 4	Үүрэг, хариуцлагын бүдүүвч
Хавсралт 12	Өнгөн хөрс хуулах, хадгалах, дахин ашиглах төлөвлөгөө	Бүлэг 5.1, 5.2	Хөрс хамгаалалт, дахин ашиглалт
Хавсралт 12.1	Гүйцэтгэгчийн Өнгөн хөрстэй ажиллах журам	Бүлэг 4, 5.2	Өнгөн хөрсний стандарт ажиллагааны журам
Хавсралт 12.2	Гүйцэтгэгчийн Газар хөндөх журам	Бүлэг 5.2	Гадаргуугийн эвдрэлийг зохицуулах.
Хавсралт 13	Ундны усны чанарын хяналтын төлөвлөгөө	Бүлэг 6	Ажилчдын эрүүл мэнд, ариун цэвэр
Хавсралт 14	Барилгын ажлын үеийн тоосжилт, дуу чимээ, чичиргээний хяналтын	Бүлэг 5.2, 6	Ажиглалтад суурилсан хяналт-шинжилгээний арга
Хавсралт 15	Гүйцэтгэгчийн сургалтын төлөвлөгөө	Бүлэг 8	Сургалтын матриц, хуваарь, агуулга
Хавсралт 16	Байгаль орчны хяналт-шинжилгээний өдөр тутмын хяналтын хуудас	Бүлэг 6, 14	Өдөр тутмын хэрэгжилтийн хяналт
Хавсралт 17	Ногоон байгууламж, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Бүлэг 5.2, 6, 13	Байгаль орчны нөхөн сэргээлт, тохижилтын арга хэмжээ
Хавсралт 18	2025, 2026 оны ажлын төлөвлөгөө ба хуваарь	Бүлэг 1	2025, 2026 оны төслийн үйл ажиллагааны нарийвчилсан цагийн хуваарь, шат дараалал.

2. Байгаль орчин, нийгмийн төлөв байдлын тойм

Энэхүү бүлэгт Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 7, 11, 12, 13-р хороодын нутаг дэвсгэрт хэрэгжих “Сэлбэ гол”-ын замын дэд төслийн талбайн байгаль орчин, нийгмийн төлөв байдлыг тоймлов. Энд танилцуулсан суурь мэдээлэл нь төслийн Зөвлөх “*CTI Engineering International*” компанийн зураг төслийн шатанд боловсруулсан Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ)-ний нэг хэсэг болох Байгаль орчин, нийгмийн төлөв байдлын үнэлгээ (БОНТБҮ)-нд тулгуурласан болно.

Зураг төслийн шатны БОНТБҮ нь байр зүй, геологи, уур амьсгал, агаар болон усны чанар, дуу чимээ, хөрсний шинж чанар, ургамал, амьтны аймаг гэх мэт байгаль орчны үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, баримтжуулсан. Мөн борооны усны урсац, ус зайлуулах хүчин чадал гэх мэт ус зүйн нөхцөл байдлыг үнэлж, замын зурвас талбайн дагуух байгаль орчны эмзэг байршлуудыг тодорхойлсон.

Нийгмийн төлөв байдлын үнэлгээгээр хүн ам зүй, газар ашиглалт, нийтийн эзэмшлийн дэд бүтэц, нийтийн үйлчилгээ, төслийн коридорын доторх болон эргэн тойрны эмзэг нөлөөллийг хүлээн авагчдыг судалсан.

Гүйцэтгэгчийн хувьд бид зураг төслийн шатны БОНМТ-ний үр дүнг чиглэл болгож, холбогдох дүгнэлтийг Г-БОНМТ-нд тусгасан. Тоног төхөөрөмж, машин механизм, ажиллах хүчнийг талбайд байршуулах үеэр төлөв байдалд томоохон өөрчлөлт ажиглагдаагүй. Гэвч төслийн барилга ажлын өмнөх шатанд аливаа өөрчлөлт гарах, талбайн бодит нөхцлийн ажиглалт, нэмэлт эрсдэл илэрсэн тохиолдолд энэхүү баримт бичгийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ болон хяналт-шинжилгээний төлөвлөгөөнд тусгах болно.

2.1. Одоогийн байгаль орчны нөхцөл байдал ба гүйцэтгэгчийн арга хэмжээ

Гүйцэтгэгч нь зураг төслийн шатны БОНМТ-нд тулгуурлан дараах байгаль орчны нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрч, барилгын ажлын төлөвлөлт, хэрэгжилтэд харгалзан үзэх болно.

Байр зүй, газрын гадаргуу

Төслийн талбай нь Сэлбэ голын сав газрын далайн түвшнээс дээш 984-2,033 м хүртэл өндөрлөг газарт байрлана. Тухайн талбай нь Духын давааны уулархаг бүс, Сэлбэ голын дагуух Аллювийн гаралтай нам дор хөндийг хамруулна. Ийм нөхцөлд хөрсний тогтворжилт, гадаргын усны урсацын шинж чанарыг харгалзан үзсэний дагуу газар шорооны ажил, ухмалын ажлын төлөвлөлтийг хийнэ.

Уур амьсгал

Улаанбаатар хотын цаг уурын станцын 2004–2022 оны мэдээллээр:

- Жилийн дундаж агаарын хэм: 1.05°C. Улирлын хэлбэлзлээс хамааран өвөлдөө -19°C, зундаа 17.5°C байна.
- Хөрсний хөлдөлтийн хугацаа: 10-р сарын дунд үеэс 4-р сарын дунд үе хүртэл (195-200 хоног). Энэ нь ухмал, бетон цутгалт болон асфальтын ажилд нөлөөлнө.
- Агаарын харьцангуй чийгшил: жилийн дундаж 58%, хаврын улиралд ~50.7% хүртэл буурдаг.
- Хур тунадас: дунджаар 269 мм/жил, үүний ~69% нь зун ордог. Энэ нь барилгын ажлын хуваарь, эвдрэл элэгдэлд нөлөөлнө.
- Салхи: жилийн дундаж хурд 1.9 м/с, хавар 3.1 м/с хүрдэг. Салхины нөхцлийг өргөлтийн ажил, материал хадгалалт, тоосжилтын хяналт зэрэгт харгалзан үзэгдэх шаардлагатай.

Агаарын чанар

Төслийн талбайн суурь агаарын чанар нь “Сайн” (AQI 7.4–40.11) гэж үнэлэгдсэн. Гэвч барилгын үе шатанд тоосжилт, тоосонцор үүсэх магадлалтай. Иймээс Гүйцэтгэгч нь Сэлбэ голын замын дэд төслийн зурвас талбайн дагуу 300-500 м тутамд буюу **7 цэгт (ПК 0+380 зүүн; ПК +380 зүүн; ПК 0+460 & ПК 0+520 зүүн; ПК 0+960 – ПК 1+040 зүүн; ПК 1+140 зүүн; ПК 1+100 зүүн; ПК 2+020 зүүн)** Инженерийн заавар, техникийн шаардлагын дагуу CO, SO₂, NO₂, TSP, PM10, PM2.5 (тоосонцор)-ыг хэмжиж, тоосжилтыг ажигласнаар агаарын чанарт хяналт тавьна.

Хяналтыг 2025, 2026 онд жилд дор хаяж хоёр шаттайгаар барилгын улиралд (4-р сарын 15-наас 10-р сарын 15 хүртэл) хоёр долоо хоног тутамд ТХН болон Зөвлөхийн хяналтан дор хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хэрэгжүүлнэ.


Тоосжилтын эсрэг арга хэмжээнд ус шүрших, тээвэрлэлтийн үед материалыг бүтээх, тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах зэрэг багтана. Бүх үйл ажиллагаа нь Монгол Улсын стандарт болон Дэлхийн Банкны БОЭМАБ-ын удирдамжуудыг дагаж мөрдөнө.

Дуу чимээний хэмжилт

Сэлбэ голын авто замын дэд төслийн зам барилгын ажлын явцад булдозер, экскаватор, ачааны автомашин зэрэг хүнд машин механизмын үйл ажиллагаанаас болж дуу чимээний түвшин нэмэгдэх төлөвтэй. Зураг төслийн шатанд хийсэн суурь хэмжилтээр 13 цэгт 46 дБ (А)-аас 66.3 дБ (А) хүртэлх дуу чимээ бүртгэгдсэн бөгөөд зарим цэгт Монгол Улсын MNS 4585:2016 стандартад заасан өдрийн цагаар 60 дБ (А), шөнийн цагаар 45 дБ (А) болон Дэлхийн Банкны удирдамжид заасан өдрийн цагаар 55 дБ (А), шөнийн цагаар 45 дБ (А)-ийн зөвшөөрөгдөх хэмжээг давж байна. Тодруулбал, 6, 7, 8, 9, 10, 11-р цэг нь үндэсний стандартаас, 2, 4, 5, 13-р цэгээс бусад нь Дэлхийн Банкны зөвшөөрөгдөх хэмжээг давсан. Эдгээр цэг нь ПК 0+100–1+700 хэсгийн ойролцоо байрлана.

Гүйцэтгэгч нь төслийн замын зурвас талбайн дагуу хоёр долоо хоног тутамд дор хаяж 7 цэгт дуу чимээний хэмжилт хийнэ. Хэмжилтийг 2025, 2026 онд барилгын улиралд (4-р

сарын 15-наас 10-р сарын 15 хүртэл) тус тус хоёр удаа ТХН болон Зөвлөхийн хяналтан дор магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. Шаардлагатай бол тасралтгүй хяналт тавьж болно.



Зураг 3. Дуу чимээний хэмжилт хийх байршлуудын газрын зураг

Зураг 3-ын Дуу чимээний хэмжилт хийх байршлуудын газрын зурагт үзүүлсэн цэгүүд болон холбогдох барилгын ажлын хэсгүүдэд үндэслэн дуу чимээний хэмжилт хийх 7 байршлыг сонгоно. Дуу чимээний түвшин нэмэгдэх төлөвтэй зохих хяналтын цэгүүдэд дуу чимээний хаалт суурилуулна.

Дуу чимээний сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Гүйцэтгэгч нь чанга дуу чимээтэй ажлыг зөвхөн өдрийн цагаар хийх, машин механизмын бүрэн бүтэн байдлыг хангаж, тогтмол засвар үйлчилгээ хийх, шаардлагатай газарт түр дуу чимээний хаалт суурилуулах, орон нутгийн иргэдтэй идэвхтэй харилцаж, гомдол саналд хариу өгөх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дуу чимээний хяналтыг агаарын чанарын хяналтын хөтөлбөртэй уялдуулан, холбогдох MNS 4585:2016, MNS 0012-1-009:1985 стандартууд, Дэлхийн банкны Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байлдын удирдамжуудыг дагаж мөрдөнө.

Геологи, ус зүй, гадаргын ус

Сэлбэ голын авто замын дэд төсөл нь Туул голын сав газрын Сэлбэ голын хөндийд байрлах бөгөөд Аллювийн гаралтай элс, хайрга, шавранцар, лаг шавран хурдастай.

Эдгээр хөрсний нөхцлийг ухмал, ус зайлуулах шугамын ажлын үед харгалзан үзэж, эвдрэл, тогтворгүй байдлаас сэргийлнэ.

Сэлбэ гол нь улирлын шинжтэй урсах бөгөөд их хэмжээний урсац нь дөрөвдүгээр сараас есдүгээр сар хүртэл үргэлжилдэг. Голын орчимд хийх зам барилгын ажлыг их урсацын үеэр тасалдуулахгүй байхаар төлөвлөж, элэгдлээс сэргийлнэ. 2023 оны усны чанарын хяналтаар зарим цэгт аммони, нитрит, фосфатын хэмжээ өндөр гарсан нь бохирдлын эрсдэлийг харуулж байна. Иймд Гүйцэтгэгч нь урсацад хяналт тавьж, гол руу хаягдал ус орохоос зайлсхийх арга хэмжээ авна.

Тунадасаас дээж авч үзэхэд тодорхой цэгүүдэд, ялангуяа суурьшлын бүсийн ойролцоо хүнд металлын агууламж өндөр байсан. Цаашид бохирдлоос сэргийлэхийн тулд тунадасны хөдөлгөөнийг багасгаж, барилгын ажлын явцад элэгдлээс хамгаалах арга хэмжээг авна.

Гүйцэтгэгч нь дараах **4 байршилд** гадаргын усны чанарыг хянана:

1. ПК 0+080 баруун тал (N5310055, E644293)
2. ПК 0+500 баруун тал (N 5310470, E 644248)
3. ПК 1+020 баруун тал (N 5310983, E 644161)
4. ПК 2+180 баруун тал (N 5312050, E 643719) төслийн замын зурвас талбайн дотор Сэлбэ голын дагуу.



Зураг 4 Газрын гадаргын ус дээж авах цэгүүд

MNS 4943:2015 стандартын дагуу хэмжих үзүүлэлтүүдэд pH, цахилгаан дамжуулах чанар (EC), хатуулаг, натри (Na), кали (K), кальци (Ca), магни (Mg), аммони (NH₄), төмөр (Fe), фтор (F), хлорид (Cl), сульфат (SO₄), нитрит (NO₂), нитрат (NO₃), фосфат (PO₄),



бикарбонат (HCO_3), нийт ууссан хатуу бодис (TDS), биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (BOD), хүнд металлууд багтаж байна.

Мөн гадаргын усны тунгалаг чанарыг нүдээр ажиглана. Хяналтыг ТХН, Зөвлөхийн хяналтан дор барилгын улиралд (4-р сарын 15-наас 10-р сарын 15 хүртэл) сар бүр гүйцэтгэнэ. Зам барилгын ажлын явцад усны чанарыг хамгаалахын тулд бүх үйл ажиллагааг холбогдох Монгол улсын стандартууд (MNS 4586:1998), ДЭМБ-ын удирдамжуудын дагуу хэрэгжүүлнэ.

Сэлбэ гол ба уст давхаргын харилцан үйлчлэл

Сэлбэ гол болон түүний доорх уст давхарга нь улирлын чанартай тодорхой харилцан үйлчлэл үзүүлдэг. Газрын доорх усны түвшин өндөр үед голыг газрын гүний ус тэтгэдэг бол газрын доорх усны түвшин багассан үед (гол хөлдөөгүй нөхцөлд) голын ус нь уст давхаргыг нөхөн сэргээдэг. Ус шүүрэлтийн хэмжээ нь голын урсац болон орон нутгийн хөрсний шинж чанараас хамаарна.


Гүйцэтгэгч нь Сэлбэ голын дагуух төслийн замын зурвас талбайн 4 цэгт усны сээр нуруугүй амьтдад хяналт тавьна. Хяналтыг ТХН, Зөвлөхийн хяналтан дор барилгын ажлын улиралд (4 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 15 хүртэл) хоёр сар тутамд хэрэгжүүлнэ. Бүхий л хяналтын ажиллагаа нь зам барилгын ажлын явцад усны экосистемийг хамгаалах зорилгоор Дэлхийн банкны Байгаль орчин, Эрүүл мэнд, Аюулгүй байдлын (БОЭМАБ) удирдамжийг дагаж мөрдөнө.

Газрын гүний ус

Төслийн талбай орчмын газрын гүний усны дээжийн химийн элемент, хүнд металлын агууламж нь Монгол Улсын стандартууд (MNS 0900:2018, MNS 4586:1998)-д заасан зөвшөөрөгдөх хязгаарт багтсан. Голлох усны чанарын үзүүлэлтүүд болох хүчиллэгийн түвшин (pH), цахилгаан дамжуулалт, хатуулаг болон бохирдуулагч бодисын агууламж нь шаардлагад нийцэж байгаа тул газрын гүний ус нь ноцтой бохирдлын эрсдэлгүй, ашиглах боломжтойд тооцогдож байна.

Гүйцэтгэгч нь Сэлбэ голын ус хураах талбайн газрын гүний усны эх үүсвэрийг зам барилгын ажил (жишээлбэл, тоос дарах, бетон зуурах), ажилчдын ундны болон ахуйн усны хэрэгцээнд ашиглахаар төлөвлөж байна. Зөвлөх СТП-ийн боловсруулсан зураг төслийн шатны БОНМТ-нөөс авсан Зураг 2-ын газрын зурагт төслийн замын зурвас талбайн газрын гүний усны тандан шинжилгээний 6 цэгийг (L-52, L-70, L-71, L-97, L-113, L-166) ногоон гурвалжингаараа тэмдэглэсэн байна. Эдгээр нь барилгын ажлын өмнөх болон барилгын ажлын үеийн байнгын хяналт шинжилгээний цэгүүд болно.


Мөн дээрх эх сурвалжаас төслийн замын зурвас талбайн дагуу орших хоёр чухал худгийг (Зураг 5 – ПК 2+020 зүүн талд орших цэвэр усны худаг, ПК 0+340 баруун талд орших худаг) тодорхойлсон бөгөөд барилгын ажлын явцад эдгээр эмзэг цэгийн газрын гүний усны чанарт сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэхийн тулд хяналт шинжилгээнд хамруулна.



Зураг 5. Газрын гүний усны дээж авах цэгүүд 1

Газрын зурагт трассын ойролцоох хүн амын нягтаршил ихтэй газруудад байрлах таван айл өрхүүдэд ус түгээх цэгийг үзүүлсэн бөгөөд үүнд барилга байшингуудын дунд байрлах жижиг худаг болон хотын усны түгээх шугамд холбогдсон нийтийн худгийг багтаж байна. Эдгээр худгийг зураг төслийн шатны БОНМТ-нд тодорхойлж, газрын зурагт оруулсан бөгөөд энэхүү тайланд дахин хянасан болно. Худгуудын байршил, усан хангамжийн төрөл, эрсдэлийг үнэлсний дараа эдгээр нь хотын нийтийн усан хангамжийн системээс хангагддаг бөгөөд барилгын ажилд ашиглах газрын гүний усны эх үүсвэртэй ус зүйн холбоогүйг тогтоосон. Тиймээс төслийн үйл ажиллагаанаас бохирдох эрсдэл бага юм.

¹ Эх сурвалж: Зөвлөх СТИ-ийн боловсруулсан БОНМТ – Сэлбэ голын зам, Зураг 2: Газрын гүний усны дээж авах цэгүүд, Хуудас 3-25.



Зураг 6. Одоо байгаа усны худгууд

Хог хаягдлын менежмент

Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийн хувьд хууль журам шинэчлэгдсэн ч хог ачих хуваарь тогтмол бус, хууль бусаар хог хаягдлыг зайлуулдаг, олон нийтийн мэдлэг, мэдээлэл хангалтгүй зэрэг байдлын улмаас тодорхой сорилтуудтай тулгарч байна. Сэлбэ голын замын дэд төслийн хүрээнд Гүйцэтгэгчийн ухмал, ажилчдын кэмп байгуулах болон зам барилгын үйл ажиллагаанаас идэвхгүй (барилгын хог хаягдал), аюулгүй (хүнсний хаягдал, сав баглаа боодол), хязгаарлагдмал хэмжээний аюултай хог хаягдал (тос, тос тосолгооны материал, эмнэлгийн хог хаягдал) гарна. Төслийн талбайд урьдчилан хуримтлагдсан хог хаягдал илрээгүй. Хог хаягдлыг Монгол Улсын хууль журам болон Дэлхийн банкны БОЭМАБ-ын тухай удирдамжийн дагуу Сүхбаатар дүүргийн Тохижилт, үйлчилгээний компани (ТҮК)-тай хамтран өдөр бүр зохион байгуулалттайгаар цуглуулж, зайлуулна. Хог хаягдлын менежментийн нарийвчилсан төлөвлөгөөг Бүлэг 13-т оруулав.

Хөрсний төлөв байдал, хяналтын тойм

Сэлбэ голын замын дэд төслийн талбай нь уул, голын хөндийн хөрсний бүсэд байрлах бөгөөд уулын хар шороон хөрс, уулын хүрэн хөрс, уулын хар хүрэн хөрс давамгайлдаг. Төлөв байдлын үнэлгээний хүрээнд 30 гаруй цэгээс хөрсний дээж авч, 6 гол байршилд хими-физикийн шинжилгээ хийж, 30 цэгт хүнд металлын бохирдлын үнэлгээ хийсэн.

Гүйцэтгэгчийн зүгээс хөрсний чанарын хяналтыг дараах 6 цэгт гүйцэтгэнэ. Үүнд:

1. ПК 0+400 Баруун тал (N 5310372, E 644265)
2. ПК 0+900 Зүүн тал (N 5310857, E 644141)

3. ПК 1+300 Баруун тал (N 5311253, E 644075)
4. ПК 1+700 Баруун тал (N 643931, E 5311628)
5. ПК 2+300 Зүүн тал (Кэмп) (N 643616, E 5312138)
6. ПК 2+600 Зүүн тал (N 643700, E 5312416) төслийн замын зурвас талбайн дагуу.

Хяналт шинжилгээний хүрээнд химийн шинж чанар (рН, давсжилт, цахилгаан дамжуулах чанар, карбонатын агууламж, шим тэжээл, ширхэглэлийн хэмжээ), хүнд металлын агууламж (Zn, Cr, Pb, Cu, Ni, As, Cd), бактериологийн үзүүлэлтийг тодорхойлж, бохирдол илрүүлэх нүдэн үзлэгийг хийнэ.

Хяналтыг барилгын улирал бүрт хийхээр хуваарилсан гаргасан бөгөөд Гүйцэтгэгч нь Монгол Улсын MNS 5850:2019, MNS 3297:2019, MNS 6341:2012, MNS 5367:2004 стандартуудын дагуу ТХН, Зөвлөхтэй хамтран хэрэгжүүлнэ.

Төлөв байдлын үнэлгээний гол дүгнэлтүүд нь:

- Хөрсний рН нь саармагаас хүчтэй шүлтлэг (7.28–8.4) хооронд хэлбэлзэж байна.
- Давсжилтын түвшин бага, хөрсийг давсгүй - бага зэрэг давсархаг гэсэн ангилалд оруулсан.
- Карбонатын агууламж маш бага (0–1.81%) байна.
- Хөрсний органик бодис болон зайлшгүй шаардлагатай шим тэжээлүүд нь дунд зэрэг ба хувьсамтгай байна.
- Хөрсний бүтэц нь дунджаас хүнд хооронд хэлбэлзэх бөгөөд зарим цэгт шаврын агууламж 20%-иас дээш гарсан.
- Хүнд металлын агууламж нь зөвшөөрөгдөх дээд түвшин дотор байгаа бөгөөд ноцтой бохирдол илрээгүй.

Гүйцэтгэгч нь зам барилгын ажлын явцад байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, холбогдох шаардлагыг хангахын тулд тогтмол хөрсний хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

Ургамал ба Модны Менежмент

Сэлбэ голын замын дэд төслийн талбайн ургамалжилт, ургамлын бүрхэвчийн төлөв байдлыг өмнө нь зураг төслийн шатны Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ)-нд тогтоосон. Тухайн үнэлгээнд төслийн талбайн өргөн хүрээний экологийн орчныг тодорхойлж, Монгол–Дагуурын уул–ойн хээрийн бүсэд хамаарахыг дурдсан бөгөөд нийт 135 төрөл, 42 овгийн 201 зүйлийн ургамал бүртгэгдсэн. Үүнд өвслөг ургамал, бут сөөг болон мод багтсан бөгөөд ОУБХХ-ны Улаан ном болон Монгол Улсын ховор амьтан, ургамлын жагсаалтад багтсан эмзэг эсвэл устаж болзошгүй зүйл бүртгэгдээгүй болно. Хот байгуулалтын нөлөөгөөр байгалийн ургамалжилтын ихэнх хэсэг солигдож, доройтсон бөгөөд өнөөгийн байдлаар *Ширэг улалж* (*Carex duriuscula*), *Санчирын гичгэнэ* (*Potentilla spp.*), *агь* (*Artemisia spp.*) зэрэг тэсвэртэй зүйлүүд давамгайлагдаж байна.

Зураг төслийн шатны баримт бичигт нийт 41 ширхэг мод, бут сөөг бүртгэгдсэн. Үүнд:

- 32 бургас (Salix glauca),
- 7 улиас (Populus laurifolia),
- 2 хайлаас (Ulmus pumila).

Үүнээс тухайн үеийн үнэлгээгээр:

- 4 ш бургас амьдрах чадваргүй тул шилжүүлэн суулгах боломжгүй,
- 5 ш улиас нь нөлөөллийн бүсээс гадуур оршиж байгаа тул барилгын ажилд өртөхгүй гэж дүгнэсэн.

Энэхүү суурь мэдээлэлд үндэслэн Гүйцэтгэгч нь 2025 оны 7-р сард төслийн замын зурвас талбай доторх моддын талбайн үнэлгээг хийсэн. Тооллогод тухайн зурвас талбайд багтаж буй айл өрхийн хашаан доторх мод, бут сөөгийг тооцоогүй. Үнэлгээгээр 2.7 км замын трассын дагуу барилгын бүсэд нийт 27 ш мод, бут сөөг байгаа бөгөөд зам барилгын ажилд өртөх нь тогтоогдсон. Үүнд:

Хүснэгт 6. Нүүлгэн шилжүүлэх моддын жагсаалт


Байршил	Тарьмал бут сөөг	Бургас (Salix glauca)	Улиас (Populus laurifolia)	Улиас (Суулгац)	Хайлаас (Ulmus pumila)	Тайлбар
0+240	3					Зүүн тал
0+580		3				Баруун тал
0+600			4			Баруун тал
0+700		4				Баруун тал
0+750				1		Баруун тал
0+860		1		1		Баруун тал
0+880		1				Баруун тал
0+890		4				Баруун тал
1+700			2			Баруун тал
2+360					1	Баруун тал
2+520			1			Зүүн тал
2+580					1	Баруун тал
Нийт	3	13	7	2	2	
			27			

Одоо байгаа 27 ш мод, бут сөөг (айл өрхийн хашаанд байрлах модыг оруулаагүй) нь бүгд барилгын бүсэд орших бөгөөд зам барилгын үйл ажиллагаанд өртөхөөр байна. Эдгээр мод, бут сөөгийн нөхцөл байдал, байршлын зургуудыг доор үзүүлсэн бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт 9**-д оруулав.

Зураг 7. Одоо байгаа мод, бут сөөг



0+240 (зүүн тал). Тарьмал бут сөөг - 3



0+580 (баруун тал) Бургас 3



0+600 (баруун тал) Улиас - 4

Моддын төлөв байдал, өндөр (1.5-5 м), насны ангиллыг үндэслэн үнэлэхэд, нөлөөлөлд өртөх мод тус бүрийн экологи, эдийн засгийн үнэлгээ нь дунджаар 700,000 төгрөг болж, нийтдээ 18,900,000 төгрөгөөр үнэлэгдсэн. Үүний дагуу Гүйцэтгэгч нь барилгын ажил эхлэхээс өмнө эдгээр 27 ш модыг дүүргийн захиргаанаас заасан байршилд шилжүүлэн суулгахаар төлөвлөж байна. Мод суулгах нүхийг бэлтгэх, дахин суулгасны дараах арчилгаа зэрэг шилжүүлэн суулгах ажлыг Монгол Улсын MNS 6258-1:2011 стандарт, Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн хүрээний бодлогын шаардлага (WB ESF,

БОНС1 болон БОНС6)-ын дагуу хэрэгжүүлнэ. Мод шилжүүлэн суулгах ажлын дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт 17-ын Ногоон байгууламж ба нөхөн сэргээх төлөвлөгөөнд** тусгав.

Хамгаалалттай газар нутаг ба Соёлын өв

Зураг төслийн шатны БОНМТ-нд зааснаар Сэлбэ голын замын дэд төслийн талбайн дотор болон ойролцоо Тусгай хамгаалалттай газар нутаг байхгүй. Энэ нь орон зайн шинжилгээ, зураглалын үр дүнд баталгаажсан.

Мөн төслийн бэлтгэл шатанд хийсэн археологи, палеонтологийн судалгаагаар зам барилгын зурвас талбайд түүх, соёлын өвийн дурсгал, олдвор, палеонтологийн үлдэгдэл илрээгүй болно.

Гэхдээ Гүйцэтгэгч нь соёлын өвийг хамгаалахын ач холбогдлыг ухамсарлаж, зураг төслийн шатны БОНМТ-дн тусгагдсан “Гэнэтийн олдворын журам”-ыг (Г-БОНМТ-ийн **Хавсралт 1**) чанд мөрдөнө. Хэрэв зам барилга, ухмалын ажлын явцад аливаа дурсгалт зүйл, соёлын өв гэнэт илэрвэл тухайн хэсгийн ажлыг шууд зогсоож, холбогдох орон нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

Энэ нь Монгол Улсын соёлын өвийн тухай хууль тогтоомж, Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС8)-тай бүрэн нийцэх бөгөөд илрээгүй соёлын өвд санаандгүй хохирол учруулахаас сэргийлнэ.

2.2. Нийгмийн төлөв байдлын тойм

Сэлбэ голын замын дэд төслийн нийгмийн суурь мэдээлэл нь Сүхбаатар дүүргийн 7, 11, 12, 13-р хороодыг хамарч байгаа бөгөөд Зураг төслийн шатны БОНМТ болон 2018-2023 онд хийсэн өрхийн судалгааны үр дүнд үндэслэсэн болно.

2022 оны байдлаар дэд төслийн талбайд нийт 39,844 хүн оршин сууж байгаа бөгөөд хүн амын хүйсийн харьцаа тэнцвэртэй (53% нь эмэгтэй) байна. Хүн амын тоо 2018-2021 онд тогтвортой өссөн ч 2022 онд бага зэрэг буурсан үзүүлэлттэй байна. Насны бүтцийг авч үзвэл хүн ам харьцангуй залуу бөгөөд 35% нь хүүхэд (0-17 насны), 11% нь ахмад настан (60 ба түүнээс дээш насныхан) байна.

Боловсролын түвшин харьцангуй өндөр бөгөөд оршин суугчдын гуравны нэгээс илүү хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна. Ажил эрхэлж буй хүн амын ойролцоогоор 35% нь хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг. Харин ажилгүйдлийн түвшин 2022 оны байдлаар 5.7% байна. Судалгаанд хамрагдсан өрхийн бараг тал хувь нь санхүүгийн хэрэгцээгээ хангахад хүндрэлтэй байгаагаа мэдэгдсэн бөгөөд өрхийн сарын дундаж орлого нь ихэвчлэн 500,000-2,000,000 төгрөгийн хооронд байна.

Үндэс, угсаатны бүтэц нь голчлон халх (ойролцоогоор 90%) бөгөөд ястан хоорондын амьжиргааны түвшний ялгаа илрээгүй болно. Дүүрэг рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөн үргэлжилж байгаа бөгөөд энэ нь голчлон боловсрол, хөдөлмөр эрхлэлт, орон сууцны

хэрэгцээтэй холбоотой байна. Мөн жижиг, дунд бизнесийн бүртгэл тогтвортой өсөх хандлага ажиглагдсан.

Хот байгуулалт ба гэр хороолол

Зураг төслийн шатны БОНМТ-нд дурдсанаар Улаанбаатар хотод, ялангуяа гэр хороололд хотын дэд бүтцийг өргөтгөх, ашиглалтын бэлэн байдлыг хангахтай холбоотой хүндрэлүүд тулгарсаар байна. Нийслэлийн нийт хүн амын ойролцоогоор 60 хувь нь гэр хороололд амьдардаг. Энэ нь төвлөрсөн усан хангамж, ариун цэврийн байгууламж, дулаан хангамж, хог хаягдлын үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал, төлөвлөгдөөгүй, нягтрал багатай суурьшлын бүс бөгөөд байна.

Дэд төслийн талбайд хамаарах хороодоос зөвхөн 7-р хороо л хотын дэд бүтцэд бүрэн холбогдсон бол бусад хороо нь ихэвчлэн гэр хорооллын давамгайлсан тул холболт маш бага түвшинд байна. Сүүлийн жилүүдэд цахилгаан эрчим хүчний хүртээмж сайжирч, орон сууцны айл өрхүүд төвлөрсөн дулаанд холбогдох нь нэмэгдсэн ч гэр хорооллын өрхүүд гол төлөв ус түгээх цэгээс хамааралтай хэвээр байна. Гэвч эдгээр цэгийн хүчин чадал ихэвчлэн эрэлт хэрэгцээг хангаж чаддаггүй. Агаар, хөрсний бохирдол болон хог хаягдлын зохисгүй менежменттэй холбоотой байгаль орчин, эрүүл мэндийн асуудлууд даамжирсан хэвээр байна.

Мөн дэд төслийн коридорын дагуу аюулгүй явган хүний зам, дугуйн зам зэрэг явган зорчигчдод зориулсан дэд бүтэц дутмаг байгаа нь замын хөдөлгөөний аюулгүй байдалд нэмэлт эрсдэл болж байна.

Нийтийн үйлчилгээний хүртээмж

Боловсрол, эрүүл мэнд, тээврийн нийтийн үйлчилгээ тодорхой хэмжээгээр сайжирсан ч гэр хороололд хангалтгүй хэвээр байна. Сурагч-багшийн харьцаа нэмэгдэж, эрүүл мэндийн байгууллагууд байгаа ч хүрэх боломж нь замын түгжрэл, тээврийн хэрэгслийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан хүндрэлтэй хэвээр байна. Халдварт өвчний тархалт буурч байгаа ч халдварт бус өвчний ачаалал өндөр түвшинд хадгалагдаж байна.

Тээврийн дэд бүтэц хангалтгүй, ихэнх замууд хатуу хучилтгүй тул түгжрэл үүсдэг. Дийлэнх оршин суугчид нийтийн тээвэр зорчиж эсвэл ойрын зайд алхдаг ч замын чанар муу, тэмдэг тэмдэглэгээ дутмаг, гэрэлтүүлэг хангалтгүй байдлаас шалтгаалан хөдөлгөөний аюулгүй байдал алдагдаж байна.

Гүйцэтгэгчийн үүрэг, хариуцлагын хүрээнд анхаарах асуудлууд:

- Барилгын ажлаас үүдэлтэй тоосжилт, дуу чимээний бохирдол гэх мэт нөлөөллийг хамгийн бага түвшинд барих;
- Эмзэг бүлгүүдийн аюулгүй байдал, зорчих боломжийг хадгалах;
- Орон нутгийн удирдлагуудтай хамтран нийтийн эзэмшлийн инженерийн шугам сүлжээний тасалдлыг бууруулах;

- Ажлын явцад дэд бүцтийн тогтмол ажиллагаа, үйлчилгээний хүртээмжийг дэмжих.

Коридорын одоогийн нөхцөл ба орон нутгийн иргэдийн мэдлэг, мэдээлэл

Сэлбэ голын хамгаалалтын далангийн дагуу анх төлөвлөгдөж байсан 2.7 км хатуу хучилтгүй авто зам нь одоогоор 11, 12, 13 дугаар хороодын оршин суугчдын ашиглаж буй гол замын нэг юм. Замын нөхцөл байдал маш муу бөгөөд их хэмжээний тоосжилт үүсгэдэг тул орчны өрхүүдэд хүндрэл учруулж байна.

Өрхийн судалгааны үндсэн үр дүн:

- Судалгаанд оролцогчдын 50% нь дэд төслийн талаар тодорхой мэдээлэлтэй байсан ба мэдээллийн түвшин хороо бүрт харилцан адилгүй байна.
- 23% нь уг замыг өдөр бүр, харин 25% нь долоо хоногт 1-3 удаа ашигладаг бөгөөд ашиглалтын түвшин 11, 13-р хороонд хамгийн өндөр байна.
- 70% нь замын нөхцөл байдалд, 68% нь ойролцоох ногоон байгууламжид сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлсэн.
- Иргэдийн санааг зовоосон нийтлэг асуудлуудад замын тэмдэг, тэмдэглэгээ, аюулгүй гарц, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан байгууламж дутмаг байгаа, тээврийн хэрэгслэлтэй холбоотой тоос, дуу чимээний бохирдол багтаж байна.
- Судалгаанд оролцогчдын 35% нь барилгын ажил өдөр тутмын амьдралд, ялангуяа зорчих хөдөлгөөн, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжид сөрөг нөлөө үзүүлнэ гэж үзсэн.
- Гэхдээ 87% нь замын хөдөлгөөний аюулгүй байдал сайжрах, үерийн хамгаалалт нэмэгдэх, түгжрэл буурах зэрэг эерэг өөрчлөлт гарна гэж хүлээж буй тул төслийг дэмжихээ илэрхийлжээ.
- Оршин суугчид дараах нөлөөллийг бууруулах арга хэмжээг санал болгосон. Үүнд:
 - Түр зам, маршрут байгуулах;
 - Тоосжилт, дуу чимээг хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх;
 - Ажилчид, орон нутгийн иргэдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний сайжруулах.

Аюулгүй байдлын асуудлууд

Фокус бүлгийн ярилцлага, хэлэлцүүлгээр дараах аюулгүй байдлын асуудлууд хөндөгдсөн:

- Зам барилгын ажлын явцад зам тээврийн ослын эрсдэл нэмэгдэх, ялангуяа Сэлбэ голын дагуу оршин суудах хүүхэд, өндөр настнуудад өндөр эрсдэлтэй;
- Гарц хаах тохиолдолд зохих анхааруулга, түр замгүй бол хөдөлгөөний саатал үүсэх эрсдэл;

- Оршин суугчдын шилжилт хөдөлгөөн нь орон нутгийн үйлчилгээний хүн амын тоонд суурилсан санхүүжилтэд сөргөөр нөлөөлөх магадлалтай (жишээлбэл, эрүүл мэндийн төвүүд).

Эдгээр асуудал нь барилгын ажлын явцад замын тэмдэг тэмдэглэгээ, анхааруулга болон түр зорчих орц гарцаар хангах шаардлагатайг харуулж байна.

Эмзэг бүлэг ба Жендерийн асуудал

Төсөл хэрэгжих бүсэд хамаарах эмзэг бүлэгт өнчин хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойсон эмэгтэйчүүд багтана. 2018-2022 оны чиг хандлага:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хагас өнчин хүүхдийн тоо нэмэгдсэн;
- Өрх толгойсон эмэгтэйчүүдийн тоо буурсан.

Гүйцэтгэгч нь эмзэг бүлгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хүртээмжтэй хэрэгжүүлэхийг зорилго болгоно.

Жендерт суурилсан хүчирхийлэл ба нийгмийн сорилтууд

Төслийн бүс нутагт ядуурал, ажилгүйдэл, өндөр түвшний жендерт суурилсан хүчирхийлэл (ЖСХ) зэрэг ноцтой нийгмийн асуудлууд тулгарч байна. Улсын хэмжээний судалгаагаар:

- 1 10 эмэгтэй тутмын 1 нь 15 нас хүрэхээсээ өмнө хамтрагч бус хүнээс бэлгийн хүчирхийлэлд өртсөн;
- 4 эмэгтэй тутмын 1 нь тодорхой нөхцөлд гэр бүлийн хүчирхийллийг зөвшөөрөх хандлагатай.
- Мөн гэмт хэргийн статистик нь хөнгөн гэмт хэргийн тоо өссөнийг харуулж байна.

Гүйцэтгэгч нь:

- Ажлын байрны хүчирхийллийг үл тэвчих бодлого баримтлан;
- ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах сургалт зохион байгуулж;
- Ялангуяа эмэгтэйчүүдэд хүртээмжтэй, аюулгүй, нууцлалтай гомдол шийдвэрлэх механизм бий болгоно.

Эмзэг нөлөөллийг хүлээн авагчид

Нэн эмзэг хүлээн авагчид нь төслийн 2.7 км замын харалдаа байрлах орон сууцнууд, эмзэг айл өрхүүд, ойр хавийн оршин суугчид юм. Эдгээр бүлэг нь тоосжилт, дуу чимээ, замын хөдөлгөөний эрсдэлд онцгой өртөмтгий байна.

Гүйцэтгэгчийн үүрэг:

- Төслийн талаарх мэдээллийг цаг тухайд, соёлын онцлогт нийцүүлэн түгээх;
- Хүртээмжтэй зөвлөлдөх үйл явцаар хангах;

- Орон нутгийн иргэдийн санал, шүүмжийг төлөвлөлт, хамгааллын арга хэмжээнд тусгах;
- Хэрэгжилтийн туршид нийгмийн нөлөөллийг хянаж, эрсдэлийн уян хатан байдлаар зохицуулах.

2.2.1. Нөлөөллийн бүсийн эмзэг хүлээн авагчдыг тодорхойлох

- Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд төслийн нөлөөллийн бүсэд байрлах эмзэг хүлээн авагчдыг тодорхойлж, баримтжуулсан. Эдгээр нь барилгын ажлын явцад тоосжилт, дуу чимээ, доргилт, нэвтрэх боломж тасалдах зэрэг нөлөөлөлд онцгой өртөмтгий байршил болон хүн амын бүлгүүд юм.
- Тодорхойлох үйл явц нь талбайн үзлэг, нүдэн үзлэгээс бүрдэнэ. Хүлээн авагчдын газарзүйн байршлын тэмдэглэж (geotag), гэрэл зургаар баримтжуулсан. Байгаль орчны хяналт, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, ялангуяа агаарын чанарын хяналтын хүрээнд эдгээр хүлээн авагчид тусгайлан анхаарах шаардлагатай (**Хавсралт 14-ийн Барилгын ажлын үеийн тоосжилт, дуу чимээ, доргилтын хяналтын төлөвлөгөөг үзнэ үү**).


Тодорхойлсон эмзэг нөлөөллийг хүлээн авагчид:

Хүснэгт 7. Тодорхойлсон эмзэг нөлөөллийг хүлээн авагчид

Хүлээн No. авагчийн төрөл	Байршил	Координат	Талбай хүртэлх зай	Байгаль орчны эрсдэл	Зураг
1 Монголын үндэсний номын сан	ПК 0+000, Зүүн	N5309971, E644279	Харалдаа	Тоосжилт, дуу чимээ, чичиргээ	Зураг-1
2 АНУ-ын Элчин сайдын яам	ПК 0+120, Зүүн	N5310036, E644277	Харалдаа	Тоосжилт, дуу чимээ, чичиргээ	Зураг-2
3 Рояль олон улсын их сургууль	ПК 0+380, Зүүн	N5310316, E644274	~20 м	Тоосжилт, дуу чимээ, чичиргээ	Зураг-3
4 Рояль академийн оффисын барилга	ПК 0+380, Зүүн	N5310370, E644257	~25 м	Тоосжилт, дуу чимээ	Зураг-4
5 Ариун очир хотхон	ПК 0+460 & ПК 0+520, Зүүн	N5310428, E644245	~30 м	Тоосжилт, дуу чимээ	Зураг-5, Зураг-6
6 12 давхар барилга	ПК 0+960 – ПК 1+040, Зүүн	N5310893, E644148	~40 м	Тоосжилт, дуу чимээ	Зураг-7
7 9 давхар барилга	ПК 1+140, Зүүн	N5311089, E644105	~30 м	Тоосжилт, дуу чимээ, чичиргээ	Зураг-9

8	4 давхар барилга	ПК 1+100, Зүүн	N5311051, E644111	~30 м	Тоосжилт, дуу чимээ	Зураг-8
9	Цэвэр усны худаг	ПК 2+020, Зүүн	N5311927, E643729	Ойролцоо	Тоосжилт, чичиргээ	Зураг-10
10	УСУГ-ын худаг	ПК 2+340, Зүүн	N5312168, E643639	Ойролцоо	Тоосжилт, чичиргээ	Зураг-13
11	“Зөгий Дизайн” ХХК-ийн агуулах	ПК 2+020, Зүүн	N5311931, E643719	Зэргэлдээ	Тоосжилт	Зураг-11
12	Саак Тавилгын Үйлдвэр	ПК 2+180, Зүүн	N5312038, E643638	Зэргэлдээ	Тоосжилт, дуу чимээ	Зураг-12
13	Сургууль (таамагласан)	ПК 0+380 ойролцоо	N5310316, E644274	Ойролцоо	Тоосжилт, дуу чимээ, чичиргээ	Зураг-3, Зураг-4
14	Эмнэлэг (болзошгүй)	Суурьшлын бүс (байршлыг удахгүй тодорхойлно)		~50–70 м	Тоосжилт, дуу чимээ	Тодорхойгүй

- **Хавсралт 14-ийн** тоосжилт, дуу чимээ, доргилтын мониторингийн төлөвлөлтөд хүлээн авагч бүрийн зураг, дүрс, координатыг оруулсан.
- Тодорхойлсон бүх эмзэг хүлээн авагчдад зориулсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг боловсруулах, мөн зам барилгын ажлын үеийн тоосжилт, дуу чимээ, чичиргээний хяналтын төлөвлөгөөнд тусгасан. Хяналтын давтамж, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зэргийг нь тухайн хүлээн авагчийн байршил, мэдрэг байдлын түвшнээс хамааран өөрчилнө.



Зураг 8. Хяналтын цэгүүд ба эмзэг хүлээн авагчид

Зураг 7-д төслийн нөлөөллийн бүсийн эмзэг хүлээн авагчдын байрилыг газрын зургаар харуулсан. Эдгээр байриилд тоосжилт, дуу чимээ, чичиргээний шалгалт хийгдэх бөгөөд тодорхойлсон дуу чимээний хяналтын цэгүүдэд дуу чимээний хаалт суурилуулна.

Бизнесийн болон үйлчилгээний байгууллагуудын судалгаа

Гүйцэтгэгч нь трассын дагуух бизнесийн болон үйлчилгээний байгууллагуудын судалгааг явуулсан.

Энэхүү судалгааг нөлөөлөлд өртөх бизнес болон үйлчилгээ эрхлэгч нартай эртнээс хамтран ажиллахын тулд барилгын ажлын өмнөх бэлтгэл ажлын хүрээнд хэрэгжүүлсэн. Гүйцэтгэгч нь гудамжны хоёр талаар жижиг хүнсний дэлгүүр, худалдааны төвүүд, оффис, сургууль, агуулах, үйлдвэр, боловсруулах болон үйлдвэрлэлийн байгууламж зэрэг нийт 18 бизнес, үйлчилгээний байгууллагыг бүртгэсэн. Мөн барилгын ажлын явцад ан цав, эвдрэл гэмтэл үүсээгүйг нотлох гэрэл зургийг авч, баримтжуулсан тул гүйцэтгэгч нь хариуцлага хүлээхгүй болно. Хавсралт 10-д эдгээр фото зургийг оруулав.

Хүснэгт 8. Төслийн трассын дагуух бизнесийн болон үйлчилгээний байгууллагууд

№	Байршил		Бизнесийн болон үйлчилгээний байгууллагууд
1	0+000	Зүүн	Монголын үндэсний номын сан
2	0+120	Зүүн	АНУ-ын Элчин сайдын яам
3	0+380	Зүүн	Рояль олон улсын их сургууль
4	0+420	Зүүн	Рояль академийн оффисын барилга

5	0+460	Зүүн	“Ариун Очир” хотхоны 19 давхарт 9 давхар орон сууцны 1 давхарт байрлах “Мархай” хүнсний дэлгүүр.
6	0+520	Зүүн	“Ариун Очир” хотхоны 21 давхарт 16 давхар орон сууцны 1 давхарт байрлах “Сэлбэ” хүнсний дэлгүүр
7	0+840 ~ 0+880	Зүүн	Барилгын материалын агуулах
8	0+890	Зүүн	Тавилгын үйлдвэр
9	0+910	Зүүн	Сэндвичэн агуулах
10	1+080	Зүүн	Вакум цонхны үйлдвэр
11	1+140	Зүүн	9 давхар орон сууцны 1 давхарт байрлах “Тамир” хүнсний дэлгүүр
12	1+420	Зүүн	“Буман Наяд” ХХК-ийн Барилгын материалын агуулах /Шар сэндвичэн агуулах/
13	1+480	Зүүн	“Рэд вүүд” Барилгын материалын хавтангийн үйлдвэр
14	2+020	Зүүн	УСУГ-ын цэвэр ус түгээх цэг
15	2+080	Зүүн	“Зөгий Дизайн” ХХК-ийн Сэндвичэн агуулах
16	2+180	Зүүн	Саак Тавилгын Үйлдвэр
17	2+260	Зүүн	Тавилгын Үйлдвэр /сэндвичэн барилга/
18	2+667	Зүүн	Зүүн хойд талд “Тэс петролиум”-ийн ШТС, зүүн урд талд “Сод Монгол”-ын ШТС.

Нийгмийн төлөв байдлын үнэлгээний дүгнэлт

Сэлбэ голын авто замын дэд төслийн нөлөөллийн бүс, ялангуяа 11, 12, 13-р хорооны оршин суугчид замын муу нөхцөл, хүрээлэн буй орчны эрүүл мэндийн эрсдэл, дэд бүтцийн хомсдолоос үүдэлтэй **эмзэг байдалд** ихээр өртөж буй коридорт байрлаж байна. Иргэдийн мэдээллийн түвшин дунд зэрэг байгаа ч дийлэнх оршин суугчид дэд бүтэц, замын хөдөлгөөний урсгал сайжрах, үерээс хамгаалах чадавх, явган зорчигчийн аюулгүй байдал нэмэгдэнэ гэсэн хүлээлтээр төслийг дэмжиж байна.

Гэвч зам барилгын үйл ажиллагаа нь хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд зэрэг эмзэг бүлгийн хүн амд харьцангуй өндөр нөлөө үзүүлэх эрсдэлтэй. Аюулгүй байдлын эрсдэл, үйлчилгээний тасалдал, түр шилжилт хөдөлгөөний асуудал зэрэгт урьдчилан сэргийлэх арга хэмжээ шаардлагатай. Үүнээс гадна ЖСХ, ядуурал зэрэг өргөн хүрээний нийгмийн асуудлууд нь төслийг хэрэгжүүлэх явцад мэдрэг, хүртээмжтэй байхыг шаардаж байна.

Гүйцэтгэгчийн хувьд эдгээр дүгнэлтийг **Бүлэг 5-ын Байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд** авч үзнэ. Сөрөг гөлөөллийг бууруулах арга хэмжээг Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ)-ний дагуу төлөвлөнө. Гүйцэтгэгч нь болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахын тулд бүх нөлөөлөлд өртсөн иргэдэд хүртээмжтэй байдлаар сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3. Хууль эрх зүй, байгууллагын тогтолцоо

3.1. Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн шаардлагыг хангах тухай

Төслийн гүйцэтгэгчийн хувьд бид төслийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ (БОНМХ) нь Дэлхийн банкны Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын (БОЭМАБ) удирдамжууд, Сайн туршлагын жишээнүүийг иш татсан гэдгийг мэдэгдэж байна. Эдгээр үүрэг нь төслийн зураг төслийн шатны БОНМТ-г чиглэл болгосон бөгөөд төслийн хэрэгжилтийн туршид байгаль орчин, нийгмийн эрсдэлийг зохицуулах арга хэмжээг тодорхойлсон Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандартууд (БОНС)-тай уялдаж байна.

Төсөл нь доорх Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандартуудыг (БОНС) дагаж мөрдөнө. Хамаарах БОНС тус бүрийг үнэлж, хэрэгжилтийн явцад шаардлагыг хангах, харгалзан үзэх тодорхой арга хэмжээг боловсруулсан болно.

Хүснэгт 9. Дэлхийн банкны БОНС-аас хамаарах, хэрэгжүүлэх арга хэмжээ

БОНС №	Стандартын нэр	Гол арга хэмжээ / Үүрэг даалгавар
БОНС1	Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ	- Гол эрсдэлүүд: Агаар болон дуу чимээний бохирдол, усны бохирдол, нутгийн иргэдийн аюулгүй байдал - БОНМТ-г хэрэгжүүлэх, агаар, дуу чимээ, ус, хөрсний хяналтыг тогтмол явуулах - Барилгын ажлын туршид оролцогч талуудын оролцоог хангах.
БОНС2	Хөдөлмөр, ажлын нөхцөл	- Хөдөлмөрийн шударга дадал зуршил, ХХХ/ эрүүл ахуйн байгууламжаар хангах - ЖСХ, ажлын байрны хүчирхийллийг таслан зогсоох - Ёс зүйн дүрэм - Ажилчны ГБМ - Хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрийг хориглох - Монгол улсын хууль журам, олон улсын стандартуудыг мөрдөх - Хавсралт 2 – Хөдөлмөрийн менежментийн журам, Хавсралт 2.1 – ХАБЭА журам (монгол хэл дээр)
БОНС3	Нөөцийг үр ашигтай ашиглах, бохирдлоос урьдчилан сэргийлэх менежмент	- Тоос дарах арга хэмжээ, бохир усны хяналт, аюултай хог хаягдлын зохистой менежмент, газрын доорх усны хамгаалалт - Ус болон материалын үр ашигтай хэрэглээ - Зохистой нөхөн сэргээлт - Байгалийн нөөцийн ашиглалттай холбоотой зөвшөөрөл, татвар бүрэн баталгаажсан - Хог хаягдлыг бууруулах, Байгаль орчны гэрчилгээний шаардлагыг биелүүлэх
БОНС4	Нутгийн иргэд, бүлгийн эрүүл мэнд ба аюулгүй байдал	- Олон нийтийн эрсдэлийг зохицуулах: Тоосжилт, замын хөдөлгөөн, дуу чимээ - Хүүхдүүд, өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх мэт эмзэг бүлгүүдийн хамгаалалт - Дуу чимээний хаалт, яаралтай тусламжийн гарц, тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохион байгуулалт - Сургалт, ёс зүйн дүрмээр дамжуулан Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл/бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх

		Г-БОНМТ-г хэрэгжүүлэх, Хөдөлгөөн зохион байгуулалтын төлөвлөгөө (Хавсралт 3), Гүйцэтгэгчийн Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө (Бүлэг 9), БОНУАД (Хавсралт 4)
БОНС5	Газар чөлөөлөлт, газрын ашиглалтын хязгаарлалт ба албадан нүүлгэн шилжүүлэлт	• Зураг төслийн шатны Нүүлгэн шилжүүлэлтийг дэмжих төлөвлөгөөнд газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн асуудлыг тусгасан • Гүйцэтгэгч нь Нүүлгэн шилжүүлэлтийг дэмжих төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцахгүй • Гүйцэтгэгч нь иргэдийн санал, гомдлыг ТХН, ГАА-нд дамжуулна.
БОНС6	Биологийн олон янз байдлыг хамгаалах ба амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент	• Нийт 27 нас бие гүйцсэн мод нөлөөлөлд өртөхөөр байна • Амьдрах боломжтой моддыг холбогдох байгууллагатай хамтран шилжүүлэн суулгана • Хотын ногоон байгууламжид учрах тасалдлыг хамгийн бага түвшинд барина
БОНС7	Уугуул иргэд/Сахар орчмын Африкийн уламжлалт хэв маягаар амьдарч буй эрх ашиг нь орхигдох хандлагатай орон нутгийн иргэд	• Төслийн талбайд уугуул иргэд тогтоогдоогүй • Гүйцэтгэгч нь хяналт тавьж, нөхцөл байдал өөрчлөгдвөл БОНС7-ын шаардлагыг дагаж мөрдөнө.
БОНС8	Соёлын өв	• Төслийн талбайд мэдэгдэж буй соёлын өв байхгүй • Гэнэтийн олдворын журмыг мөрдөнө • Олдвор илэрвэл ажлыг зогсоож, холбогдох байгууллагад мэдэгдэнэ.
БОНС9	Санхүүгийн зуучлагчид	Хамааралгүй – Санхүүгийн зуучлагч байгууллага хөрөнгийн зарцуулалтад оролцоогүй
БОНС10	Талуудын оролцоог хангах ба мэдээллийн ил тод болгох	• Иргэдийн мэдлэг дундаж түвшинд байгаа ч төслийг хүчтэй дэмжиж байна (87%) • Төслийн хэрэгжилтийн явцад тогтмол, ил тод байдлаар мэдээллийг түгээнэ • Гомдол, саналд хариу өгөх механизм байгаа • ОТОТ-ний дагуу хэрэгжүүлнэ.

3.2. Монгол Улсын холбогдох хууль журам

Монгол Улсын хууль журам, стандарт

Төслийн бүх үйл ажиллагаа нь Монгол Улсын холбогдох хууль, журам, стандартад нийцэх ёстой. Эдгээр эрх зүйн баримт бичиг нь байгаль орчны хамгаалалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА), хөдөлмөр эрхлэлт, хүүхэд хамгаалал, нийгмийн халамж, хүний эрх зэрэг үндсэн чиглэлийг хамардаг. Ингэснээр төслийн үйл ажиллагаа нь улсын бодлогын тэргүүлэх чиглэлүүдтэй уялдан, хууль журмын шаардлагыг хангаж, бүх төслийн оролцогч талуудын эрүүл мэнд, аюулгүй байдал, эрхийг хамгаалах юм.

А. Байгаль орчныг хамгаалах тухай хууль журам, стандарт

Гол хууль тогтоомж:

- **Байгаль орчныг хамгаалах тухай хууль (2024 онд шинэчлэн найруулсан):** Байгаль орчныг хамгаалах харилцааг зохицуулдаг гол хууль юм. Энэ хууль нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, байгалийн баялгийг зохистой ашиглах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс тогтвортой хөгжлийн хангахын тулд байгаль орчны үнэлгээ хийх, хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэдэг.

Холбогдох стандартууд:

№	Сэдэв	Стандартын нэр	Код
1	Хөрс	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.	MNS 5850:2019
2	Хөрс	Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх.	MNS 3297:2019
3	Ус	Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.	MNS 6148:2010
4	Ус	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ.	MNS 0900:2018
5	Агаар	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.	MNS 4585:2016
6	Агаар	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ.	MNS 5885:2008
7	Хог хаягдал	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага	MNS 5344:2011

В. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА)-н хууль журам, стандарт

Гол хууль тогтоомж:

- **Хөдөлмөрийн тухай хууль (2024 онд шинэчлэн найруулсан):** Хөдөлмөрийн харилцааг зохицуулж, ХАБЭА, хөдөлмөрийн нөхцөл, хүйсийн тэгш байдал, насанд хүрээгүй ажилчдыг хамгаалах тухай заалтуудыг тусгасан.
- **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2023 онд шинэчлэн найруулсан):** Барилга байгууламж, тоног төхөөрөмж, химийн бодис, хувийн хамгаалах хэрэгсэл (ХХХ), мэргэжлээс шалтгаалах өвчин, ажлын байрны үзлэг шалгалтын аюулгүй байдлын стандартыг хамарна.
- **Монгол Улсын Үндсэн хууль (16 дугаар зүйл):** Хөдөлмөрийн аюулгүй, аятай нөхцөлөөр хангуулах эрхийг баталгаажуулж өгсөн.
- **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хөтөлбөр (2001)**

Холбогдох стандартууд:

№	Сэдэв	Стандартын нэр	Код
1	ХАБЭА-н менежмент	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны менежментийн систем	OHSAS 18001:2012

2	ХАБЭА-н менежмент	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо	MNS ISO 45001:2018
3	Ажлын байрны аюулгүй байдал	Ажлын байрны орчин, Эрүүл ахуйн шаардлага	MNS 4990:2015
4	Галын аюулгүй байдал	Галын аюултай бүтээгдэхүүний ангилал, галын тоног төхөөрөмж	MNS 4999:2000, MNS 5566:2015, MNS 4284:2017
5	ХХХ	Хамгаалалтын бээлий, Амьсгал хамгаалах хэрэгсэл	MNS 5622:2011, MNS 6654:2017
6	Агаар & Гэрэлтүүлэг	Агааржуулалтын систем, Ажлын байрны агаарын нийт тоос, Гэрэлтүүлэг	MNS 5078:2001, MNS 6656:2017, MNS 6658:2017, MNS 6767:2019
7	Дуу чимээ & Доргион	Шуугианы зөвшөөрөх дээд хэмжээ, Механик доргион	MNS 6768:2019, MNS 6769:2019, MNS 6770:2019

С. Хот байгуулалт ба Хотын стандартууд (UCS)

Эдгээр стандартууд нь дэд бүтэц, барилга байгууламж, хотын орчны менежментэд мөрдөгдөнө.

№	Сэдэв	Стандартын нэр	Код
1	Хотын аюулгүй байдал	Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах	UCS 0301B:2022
2	Усны дэд бүтэц	Бие даасан инженерийн дэд бүтэц	UCS 0701B:2023
3	Бохир ус	Бохир усны цооног, бие даасан цэвэрлэх байгууламж	UCS 0702B:2023
4	Хот тохижуулалт	Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж	UCS 0801A:2022
5	Хог хаягдлын менежмент	Хог хаягдлын менежмент. Барилгын хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх.	UCS 1701A:2022, UCS 1703A:2022, UCS 1706A:2022
6	Дуу чимээ	Дуу чимээний бохирдол. Дуу чимээний бохирдлыг бууруулах.	UCS 2001A:2023, UCS 2002A:2023

D. Хөдөлмөр ба Нийгмийн хамгааллын хуулиуд

Гол хууль тогтоомж:

- **Хөдөлмөрийн тухай хууль (2024 онд шинэчлэн найруулсан):** Хөдөлмөр эрхлэгчийн эрх, ажлын цагийн зохицуулалт, хамтын гэрээ, хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх асуудлыг хамруулах бөгөөд хүйсээр ялгаварлан гадуурхахыг хориглосон.
- **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2023 онд шинэчлэн найруулсан):** Хөдөлмөрийн аюулгүй байдал, ослын талаар мэдэгдэх, хувийн хамгаалах хэрэгслийн хэрэглээ, үйлдвэрлэлийн эрсдэлийн хяналтыг зохицуулдаг.
- **Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль:** Монгол Улсын иргэн гадаадад, гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх,

тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна.

- **Нийгмийн халамжийн тухай хууль (2023 онд шинэчлэн найруулсан):** Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн тогтолцоо, үйлчилгээний хамрах хүрээг тодорхойлсон.

Е. Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын тухай хуулиуд

Гол хууль тогтоомж:

- **Хүүхдийн эрхийн тухай хууль (2022 онд шинэчлэн найруулсан):** 18 насанд хүртэлх хүүхдийг хамгаалах, амьд явах, хөгжих эрхийг баталгаажуулж, хүүхдээр аюултай хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон.
- **Хүүхэд хамгааллын тухай хууль (2022 онд шинэчлэн найруулсан):** Хүүхдийн хүчирхийлэл, мөлжлөг, дарамтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах болон байгууллагуудын уялдаа холбоог тогтоосон.
- **Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зүйлүүд:**
 - **109 дүгээр зүйл:** 14–16 насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн журам.
 - **110 дугаар зүйл:** Эрүүл мэндийн шинжилгээний шаардлага, хориглосон ажил мэргэжил, хүүхдийн ажиллах цагийн хязгаар.
 - Ажил олгогч нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл хөтөлж, холбогдох хөдөлмөрийн байгууллагад мэдэгдэнэ.
 - Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн эрүүл мэндийн үзлэгийг хагас жил тутам хийлгэх бөгөөд зардлыг ажил олгогч хариуцна.

Е. Нийгмийн болон Хүний эрхийн хуулиуд

Гол хууль тогтоомж:

- **Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль (2022 онд шинэчлэн найруулсан):** Хүний эрхийг дэмжих, хяналт тавих, гомдол шийдвэрлэх чиг үүргийг тогтоосон.
- **Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2024 онд шинэчлэн найруулсан):** Хүчирхийллийн хохирогчийг хамгаалах, гэмт этгээдэд хариуцлага тооцох, төрийн болон ТББ-уудын хамтын ажиллагааг зохицуулна.
- **Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2024 онд шинэчлэн найруулсан):** Бүх салбарт хүйсийн эрх тэгш байдлыг баталгаажуулж, жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт, байгууллагын бодлогыг хэрэгжүүлэхийг шаардсан бөгөөд бэлгийн дарамтын эсрэг хатуу зохицуулалтыг нэвтрүүлсэн.

Нэмэлт хууль журмын чиглэлүүд

Төслийн зураг төслийн шатанд зөвлөх **CTI Engineering International ХХК** нь **Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ)**-ний хүрээнд хэд хэдэн нэмэлт хууль эрх зүйн чиглэлийг судалж, тусгасан. Үүнд:

Г. Барилга, хот байгуулалтын тухай хууль тогтоомжууд

Н. Гамшгийн эрсдэл, онцгой байдлын бэлэн байдал

I. Нийгмийн эрүүл мэнд, олон нийтийн аюулгүй байдал

J. Лиценз, хяналт шалгалт, зөвшөөрлийн тухай хууль тогтоомжууд

К. Олон улсын гэрээ, конвенц

Зураг төслийн шатны БОНМТ нь төслийн гэрээний баримт бичгийн нэг хэсэг тул эдгээр чиглэлтэй холбоотой дэлгэрэнгүй хууль эрх зүйн болон бодлогын шаардлага, тайлбарыг БОНМТ-ний **Бүлэг 2 (Бодлого, эрх зүйн орчин)**-оос үзэх ёстой. Ингэснээр мэдээлэл давхардахаас зайлсхийж, төслийн бүх дагаж мөрдөх ёстой баримт бичгийн уялдааг хангах ач холбогдолтой.

Монгол Улсын хууль тогтоомж болон Дэлхийн банкны шаардлагад нийцүүлэх тухай

Гүйцэтгэгчийн нь зураг төслийн шатны БОНМТ-д тусгагдсан хууль тогтоомжийн зөрүүг илрүүлэх дүн шинжилгээг хүлээн зөвшөөрч байна. Энэ дүн шинжилгээ нь Монгол Улсын байгаль орчин, нийгмийн тухай хууль тогтоомжийг Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ)-тэй харьцуулан үнэлсэн. Үнэлгээгээр Монгол Улсад “бохирдуулагч төлнө” гэсэн зарчим, эрсдэлийн үнэлгээ, байгаль хамгааллын арга хэмжээг тусгасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний (БОНБҮ) тухай хууль зэрэг өргөн хүрээтэй эрх зүйн тогтолцоо байна гэж дүгнэсэн.

Монгол Улсын БОНБҮ-ний тухай хуулийн заалтууд нь эрсдэлд суурилсан төслийн ангилал, байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ийн шаардлага, олон нийтийн оролцоо гэх мэт Дэлхийн банкны БОНХ-тэй төстэй олон нийтлэг элементүүдийг агуулдаг ч ялангуяа байгууллагын чадавх, мэдээлэл түгээх чиглэлээр хэрэгжилтийн түвшинд ялгаа ажиглагдсан. Жишээлбэл, Монгол Улсын хуулиар БОНБҮ-ний тайланг олон нийтэд нээлттэй болгохыг албан ёсоор шаарддаггүй бол Дэлхийн банкны БОНХ нь мэдээллийн ил тод байдал, олон нийтийн идэвхтэй оролцоог зайлшгүй хангахыг шаарддаг.

Мөн Дэлхийн банкны БОНХ нь БОНМТ-ний бүтэц, агуулгад илүү нарийн шаардлага тавьдаг бөгөөд эрсдэлийг бууруулах арга хэмжээ, хяналтын тогтолцоо, байгууллагын хариуцлага, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа, гомдол шийдвэрлэх механизмыг тодорхой тусгахыг шаарддаг.

Гүйцэтгэгчийн хувьд бид үйл ажиллагаандаа холбогдох Монгол Улсын хууль тогтоомж, мөн Дэлхийн банкны БОНХ, БОНС-ын удирдамжтай бүрэн нийцүүлэхээ амлаж байна. Мөн зураг төслийн шатны БОНМТ-ний дүгнэлт, шаардлагыг чанд мөрдөж, төслийн үйл ажиллагааг үндэсний болон олон улсын байгаль орчин, нийгмийн менежментийн шаардлагуудтай нийцүүлэхийг эрмэлзэнэ.

4. Үүрэг, хариуцлага

Барилгын ажлын гүйцэтгэгч нь Г-БОНМТ-г Монгол Улсын холбогдох хууль журам, Дэлхийн банкны БОНХ-ний шаардлагатай бүрэн нийцүүлэн төслийн талбайд хэрэгжүүлэх тусгай Байгаль орчин, нийгмийн (БОН) багийг байгуулсан болно.

Г-БОНМТ-ний өдөр тутмын хэрэгжилтийг хангах үүднээс бүх гол техникийн ажилтнууд, талбайн БОН-ийн удирдлагын бүтцийг харуулсан төслийн хэмжээний зохион байгуулалтын бүдүүвчийг боловсруулсан (Хавсралт 11-д үзүүлэв).

Талбайн түвшний БОН-ийн үүрэг хариуцлага

1. Байгаль орчны мэргэжилтэн

Үүрэг, хариуцлага:

- Г-БОНМТ-нд тусгагдсан бүх байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.
- Тогтмол байгаль орчны үзлэг, хяналт шинжилгээ хийх (жишээ нь: агаарын чанар, дуу чимээ, доргилт, усны чанар).
- Байгаль орчны хяналт-шинжилгээний бүртгэлийг үнэн зөв хөтөлж, хууль эрх зүйн шаардлагыг хангах.
- Байгаль орчин, соёлын эмзэг байршлыг барилгын үйл ажиллагааны нөлөөллөөс хамгаалах.
- ТХН-д сар тутмын Байгаль орчны хяналтын тайланг хүргүүлэх.
- Талбайн нөхцөл байдал, хууль эрх зүйн зохицуулалтын өөрчлөлтөд нийцүүлэн байгаль орчны төлөвлөгөө, журамд шинэчлэлт оруулах.
- Байгаль орчны гүйцэтгэлийн асуудлаар ТХН, Зөвлөхтэй хамтран ажиллах.

2. Нийгмийн мэргэжилтэн *(Гомдол хүлээн авах гол цэгийн үүрэг гүйцэтгэж, Харилцаа холбооны ажилтныг удирдан чиглүүлнэ)*

Үүрэг, хариуцлага:

- Төслийн ГБМ-ын дагуу ажилчид, орон нутгийн иргэдийн гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх гол цэгийн үүрэг гүйцэтгэх.
- Гүйцэтгэгчийн Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ)-г хэрэгжүүлэх ажлыг удирдах.
- Нийгмийн эрсдэл, ажилчдын аюулгүй байдал, орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөллийг хянах.
- БМХД, ЖСХ-н эсрэг Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах.
- Харилцаа холбоо, сургалт хариуцсан ажилтныг удирдан чиглүүлж, олон нийттэй харилцах стратегийн талаар зөвлөгөө өгөх.
- Гомдлын бүртгэл хөтлөх, нууцлалыг хангах, шийдвэрлэлтийн явцыг хянах.
- ТХН-д сар тутмын нийгмийн гүйцэтгэл, санал гомдлын тайланг хүргүүлэх.

3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) мэргэжилтэн

Үүрэг, хариуцлага:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тогтмол хянах.
- Эрсдэлийн үнэлгээ, аюулгүй байдал аудит, ослын шинжилгээ хийх.
- Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм, ХХХ-ийн зохистой хэрэглээ, Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах.
- ХАБЭА-н хэлэлцүүлэг, сургалт, яаралтай нөхцөл байдлын бэлтгэлийг зохион байгуулах, баримтжуулах.
- Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөө, талбайн ослын тайланг зохицуулах.
- Ослын бүртгэл, засч залруулах арга хэмжээ, ХАБЭА-н сургалтын бүртгэлийг үнэн зөв хөтлөх.
- Барилгын ажил, баталгаат хугацааны туршид ТХН-ийн хяналтыг дэмжих.

4. Харилцаа холбоо, сургалт хариуцсан мэргэжилтэн (Нийгмийн мэргэжилтэнд тайлагнана)

Үүрэг, хариуцлага:

- Олон нийттэй харилцах ажилтан (ОНХА)-ны үүргийг гүйцэтгэж, төсөлд өртсөн иргэд (ТӨИ), оршин суугчид, орон нутгийн оролцогч талуудтай шууд харилцаа холбоо тогтоох.
- Барилгын ажлын хуваарь, болзошгүй хүндрэл, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар мэдээллийг оршин суугчдад тогтмол түгээх.
- Нийгмийн мэргэжилтний удирдлага дор олон нийтийн хэлэлцүүлэг, оролцогч талуудын оролцооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.
- Ажилчид болон туслан гүйцэтгэгчдэд зориулсан сургалт зохион байгуулах (жишээлбэл, ХАБЭА, БМХД, ГБМ-ын талаар мэдлэг олгох).
- Талбай дээрх гол БОН-ийн мэдээлэл тод харагдаж буй эсэхийг баталгаажуулах (тэмдэг, тэмдэглэгээ, постер, холбоо барих мэдээлэл)
- Сургалтад оролцогчдын бүртгэл хөтлөх, сар тутмын тайланд зориулан харилцаа холбооны тэмдэглэл бэлтгэх.
- Харилцаа холбооны материалуудыг соёлын онцлогт нийцүүлэн, орон нутгийн хэлээр, зураг, дүрслэл ашиглан бэлтгэсэн эсэхийг баталгаажуулах

ТХН, Зөвлөхтэй харилцах, хамтран ажиллах

Бид Гүйцэтгэгчийн Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (Г-БОНМТ)-ний хууль журам, шаардлагад нийцсэн, саадгүй хэрэгжилтийг хангахын тулд Төсөл хэрэгжүүлэх нэгж болон Зөвлөхтэй тогтмол харилцан, хамтран ажиллана.

Хамтран ажиллах, тайлагнах бүтэц

Гүйцэтгэгчийн багийн дотоод тайлагнах үйл явц

- Байгаль орчны мэргэжилтэн, Нийгмийн мэргэжилтэн, ХАБЭА-н мэргэжилтэн, Харилцаа холбоо, сургалт хариуцсан мэргэжилтэн нь Гүйцэтгэгчийн төслийн менежерт шууд тайлагнана.
- Төслийн менежер нь талбайн үйл ажиллагаанд Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдлын (БОНЭМАБ) шаардлагыг тусгах, бүх БОН-ийн тайланг хүргүүлэхээс өмнө хянан, батлах үүрэг хүлээнэ.

ТХН, Зөвлөхтэй хамтран ажиллах

- Гүйцэтгэгчийн төслийн менежер нь Зөвлөхтэй харилцах үндсэн хүн бөгөөд бүх шаардлагатай байгаль орчин, нийгэм, аюулгүй байдлын баримт бичгийг (жишээлбэл, Г-БОНМТ-ний сар бүрийн тайлан, ослын тайлан гэх мэт) хүргүүлнэ.
- Зөвлөх нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн материалыг хянаж, хэрэгжилтэд хяналт тавьж, дүгнэлт, зөвлөмжийг ТХН-д хүргэнэ.
- ТХН нь бүх гүйцэтгэгчийн мэдээллийг нэгтгэн, төслийг бүхэлд нь хамарсан БОНЭМАБ-ын тайланг дараах байгууллагуудад хүргүүлнэ:
 - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба,
 - Дэлхийн банк.

Гомдол барагдуулах механизм (ГБМ)-ын тайлагнах үйл явц

- Гүйцэтгэгчийн нийгмийн мэргэжилтэн нь гомдол хүлээн авах гол цэгийн үүргийг гүйцэтгэж, өдөр тутамд ажилчид, олон нийтээс ирүүлсэн гомдлыг зохицуулна.
- Бүх гомдлыг төвлөрсөн байдлаар бүртгэн, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Дэлхийн Банканд хүргэх төслийн нэгдсэн тайланд тусгуулахын тулд Сар бүрийн ГБМ-ын тайланг ТХН-ийн Нийгмийн мэргэжилтэнд шууд хүргүүлнэ.

Барилгын ажлыг эхлүүлэхийн өмнөх шат

Барилгын ажлыг эхлэхээс өмнө ТХН-ээр хянуулж, зөвшөөрөл авахын тулд Гүйцэтгэгчийн БОНМТ, холбогдох дэд төлөвлөгөөнүүдийг хүргүүлнэ. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) төлөвлөгөө
- Хөдөлгөөн зохион байгуулалтын төлөвлөгөө (ХЗБТ)
- Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөө
- БМХД, ЖСХ-ийн эсрэг Арга хэмжээний төлөвлөгөө
- Гүйцэтгэгчийн Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө (Г-ОТӨТ)

Барилгын ажлын явцад

Зам барилгын ажлын шатанд бид:

- ТХН, Зөвлөхийн хамтаар тогтмол талбайн уулзалтад оролцох.
- БОН-ийн арга хэмжээний хэрэгжилт, зөрчлийн талаар шинэ мэдээллийг цаг тухайд нь хүргэнэ.
- Илэрсэн зөрчлийг яаралтай арилгаж, ТХН болон Зөвлөхөөс шаардсан засч залруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- Талбайн үзлэг, аудит эсвэл хяналт шалгалтын үеэр цуглуулсан өгөгдөл, үзлэг, сургалт, санал гомдлын бүртгэл гэх мэт бүр холбогдох баримт бичигт бүрэн нэвтрэх боломжоор хангана.

Тайлагнах үүрэг

- Бид дараах мэдээллийг багтаасан сар бүрийн явцын тайланг Зөвлөхөд хүргүүлдэг:
 - Г-БОНМТ-ний арга хэмжээний хэрэгжилтийн явц
 - Хяналтын үр дүн
 - Хүлээн авч, шийдвэрлэсэн санал, гомдол
 - Аюулгүй байдлын гүйцэтгэл, аливаа ослын мэдээлэл
- Аливаа ноцтой байгаль орчин эсвэл аюулгүй байдлын асуудлыг ТХН, Зөвлөхөд 24 цагийн дотор тайлагнана.
- ТХН-ийг Дэлхийн банкинд хүргүүлэх нэгдсэн тайланг бэлтгэхэд шаардагдах бүхий л баримт бичиг, өгөгдлөөр хангах.

5. Байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Төслийн талбайн хүрээнд илэрсэн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн хураангуй

Талбайн үнэлгээ, оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт, төлөв байдлын үнэлгээнд үндэслэн төслийн талбайд буй дараах гол байгаль орчин, нийгмийн эрсдэл, сөрөг нөлөөллийг тодорхойлов:

Байгаль орчны эрсдэл

- **Мод, ургамлын алдагдал** – трассын дагуу болон түр ажлын талбайд 27 мод устах эрсдэлтэй
- Ухмалын, тэгшилгээний ажилтой холбоотой **Хөрсний эвдрэл, элэгдэл.**
- **Тоосжилт, дуу чимээний ялгарал** нь ойролцоох орон сууц, худалдааны бүсэд нөлөөлнө.
- Барилгын талбайн урсац, түлш хадгалалт, түр байрны ариун цэвэртэй холбоотойгоор **Ус бохирдох эрсдэл.**
- Сэлбэ голын үерийн улиралд **үерийн сөрөг нөлөөлөл** үзүүлэх боломжтой.

Нийгмийн эрсдэл

- Орон сууц, дэлгүүр, олон нийтийн үйлчилгээний байгууллагад **түр хугацааны нэвтрэх хязгаарлалт.**
- Замын хөдөлгөөн, хүнд машин механизм, ухсан нүхнээс үүдэлтэй **олон нийтийн аюулгүй байдлын эрсдэл.**
- **Хөдөлмөрийн нөхцлийн асуудал**, ХАБЭА-н хэрэгжилт, БМХД-ын эрсдэл.
- Хангалттай оролцуулж, мэдээлэл өгөөгүй тохиолдолд **Оролцогч талуудын сэтгэл ханамж буурах.**
- Өндөр настан, сургуулийн хүүхэд зэрэг **эмзэг бүлэгт** үзүүлэх хүндрэл.

5.1. Барилгын ажлын өмнөх шат

№	Төрөл	Нөлөөлөл ба асуудлууд:	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх	Хянах	Тооцоот өртөг	Хуваарь
1	Барилгын ажлыг	Г-БОНМТ-г бэлтгэх	1.1 Гүйцэтгэгч нь зураг төслийн шатны БОНМТ, Монгол Улсын хууль журам,	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Гэрээнд тусгасан	Талбайд ажиллах

	эхлүүлэх бэлтгэл		Дэлхийн банкны БОНХ-ний шаардлагын дагуу Г-БОНМТ-г боловсруулсан. Г-БОНМТ-г батлуулахаар хүргүүлсэн бөгөөд шаардлагатай тохиолдолд шинэчлэлт хийнэ. 1.2 Г-БОНМТ-нд дараах төлөвлөгөө, журмууд багтсан: ХЗБТ (Хавсралт 3), ХМТ (Хавсралт 2), ХХМТ (Бүлэг 13), ОБХАХТ (Бүлэг 11, Хавсралт 7, 7.1 болон Дотоод ОБХАХТ-Хавсралт 7.2), ТОХТ (Бүлэг 9), Гэнэтийн олдворын журам (Хавсралт 1) болон бусад холбогдох баримт бичиг.				хүч, тоног төхөөрөмж ийг байрлуулах аас өмнө
2	БОМТ-г боловсруула х, бэлтгэх	БОМТ-г дотооддоо батлах үйл явц удаашрах	2.1 Талбайд ажил эхлэхээс өмнө дотоод БОМТ-г Нийслэлийн Байгаль орчны газраар батлуулахаар хүргүүлнэ.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Гэрээнд тусгасан	Талбайд ажиллах хүч, тоног төхөөрөмж ийг байрлуулах аас өмнө
3	Чадавхыг бэхжүүлэх, мэдлэг олгох	Ажилчид, инженерүүдий н мэдлэг, ойлголт дутмаг байх	3.1 Ажилчид, талбайн хяналтын ажилтнуудад Г-БОНМТ-ний шаардлагын талаар сургалт зохион байгуулна (Бүлэг 8). 3.2 Үзүүлэн материал, товхимол гарын авлагаар хангана. Хавсралт 2 -ийн Хөдөлмөрийн менежментийн журмыг үзнэ үү.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Сургалт ын төсөв	Барилгын ажил эхлэхээс өмнө

			ДБ-ны БОНС2-д нийцсэн албан ёсны ХМЖ нь хөдөлмөрийн нөхцөл, ХАБЭА, ажилчдын гомдол, БМХД, Ёс зүйн дүрмийг багтаана. Хавсралт 2.1 – Дотоод ХАБЭА-н журам (монгол хэлээр). Гүйцэтгэгчийн үйл ажиллагааны журамд ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, ослын мэдээлэл, талбайн өдөр тутмын ХАБЭА-ийн үүрэг, хариуцлагууд тусгагдсан.				
4	Гүйцэтгэгчийн БОМТ-г хэрэгжүүлэх чадавх	Дотоод менежментийн зөрүү	4.1 Бүтэн цагаар талбай дээр ажиллах Байгаль орчин, ХАБЭА-н мэргэжилтэн томилох. 4.2 Г-БОНМТ-ний үүрэг, хариуцлагыг ажлын журам, ажлын байрны тодорхойлолтод нэгтгэх. Хавсралт 2 – Хөдөлмөрийн менежментийн журам (ДБ-ны БОНС2-т нийцсэн ХМЖ нь хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, ХАБЭА, ажилчдын гомдол, БМХД болон Ёс зүйн дүрмийг багтаана). Хавсралт 2.1 – Дотоод ХАБЭА-н журам (монгол хэлээр). Гүйцэтгэгчийн үйл ажиллагааны журамд ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, ослын мэдээлэл,	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Ажилчдын цалин	Одоо үргэлжилж буй

			талбайн өдөр тутмын ХАБЭА-н үүрэг, хариуцлага тусгагдсан байна.				
5	Байгаль орчны хяналтын бэлтгэл	Хяналтын бэлэн бус байдал	5.1 Төлөв байдлын үнэлгээ, тогтмол хяналт хийх магадлан итгэмжлэгдсэн лабораторитой гэрээ байгуулах. 5.2 Гол үзүүлэлтүүдийн хүрээнд лабораторийн чадавхийг хангах. Бүлэг 6-ын Хяналтын төлөвлөгөөг үзнэ үү.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Хяналтын гэрээний өртөг	Барилгын ажлыг эхлүүлэхийн өмнө ба барилгын ажлын үеэр
6	Зөвшөөрөл ба баталгаажуулалт	Талбайд ажил эхлэхэд саатал гарах эрсдэл	6.1 Бүх шаардлагатай зөвшөөрөл (ус ашиглалт, цахилгааны хэрэглээ, ашигт малтмалын олборлолт, газар ашиглалт, зам ашиглалт гэх мэт)-ийг авах. 6.2 Кемпийн төлөвлөлтийн зургийг батлуулахаар хүргүүлэх. 6.3 Холбогдох төлбөр, хураамжийг төлөх.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Дүрэм журамд заасан төлбөр	Талбайд ажиллах хүч, тоног төхөөрөмжийг байрлуулах аас өмнө
7	Хог хаягдлын тээвэрлэлт	Зохион байгуулалтгүй хог хаягдлыг зайлуулах	7.1 Тусгай зөвшөөрөлтэй хог хаягдлын компанитай гэрээ байгуулах. Бүлэг 13-ын Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг үзнэ үү.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Гэрээний өртөг	Барилгын ажлын туршид
8	Инженерийн шугам сүлжээний бэлэн байдал	Аюултай цахилгаан холболт	8.1 Аюулгүй суурилуулалтын техникийн шаардлага авах, газардуулгатай систем суурилуулах, үндэсний аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөх.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Суурилуулах өртөг	Цахилгаан холболт хийхээс өмнө

9	Түүхий эдийн эх үүсвэрийн төлөвлөлт	Зөвшөөрөлгүй олборлолт, газрын эвдрэл	9.1 Хууль ёсны олборлолтын талбайг тодорхойлох. 9.2 Зөвшөөрөл авах, нөхөн сэргээлтийн гэрээ байгуулах. 9.3 Ашиглалтын дараа талбайг нөхөн сэргээх.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Зөвшөөрөл, нөхөн сэргээлт	Барилгын ажлын туршид
10	Усны нөөцийн төлөвлөлт	Усны хэрэглээ, усны чанарын асуудал	10.1 Монгол улсын стандартын дагуу Ус ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах. 10.2 Зөвшөөрөгдсөн хорооны худгийн усыг ашиглаж, улирал тутам шинжилгээ хийлгэх.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Шинжилгээний өртөг	Барилгын ажлын туршид
11	Агаарын чанарын менежмент	Машин механизм, тоосжилтоос үүдэлтэй агаарын бохирдол	11.1 Талбайд тоног төхөөрөмжийг байршуулахаас өмнө засвар үйлчилгээ хийж, бүртгэл хөтлөх. 11.2 Тоос дарах зорилгоор ус цацах, хурдны хязгаар мөрдүүлэх, тээвэрлэж буй ачааг бүтээх.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Тоног төхөөрөмжийн засвар	Барилгын ажлын туршид
12	Түр газар ашиглалт	Барилгын ажлын явцад нэвтрэхэд хүндрэл учрах	12.1 Газрыг бүр мөсөн худалдан авахгүй байх. 12.2 Тойруу зам төлөвлөх, зам хаах ажлыг зохион байгуулах. 12.3 Барилгын материалыг зөвшөөрөгдсөн талбайд хадгалах. 12.4 Орон нутгийн захиргаатай хамтран ажиллах.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН, Орон нутгийн захиргаа	Зохицуулах зардал	Барилгын ажлын өмнө ба дараа

13	Мод нүүлгэн шилжүүлэх (27 мод)	Ургамлын алдагдал	13.1 НБОГ болон/эсвэл Ногоон хөгжлийн хэлтэстэй зөвшилцөн шилжүүлэн суулгах эсвэл нөхөн төлбөр олгох. Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах Ерөнхий шаардлага MNS 6258-1:2011 стандарт, Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ), БОНС1, БОНС6 -д нийцүүлэн бэлтгэсэн Хавсралт 17-ийн Ногоон байгууламж, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг үзнэ үү.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН, НБОГ	Модыг нүүлгэн шилжүүлэх өртөг	Зайлуулахаас өмнө
14	Кемп байгуулах, тэмдэг, тэмдэглэгээ суурилуулах	Кемпийн үзэгдэх байдал муу, зөвшөөрөлгүй байрлуулсан	14.1 Кемпийн бүх орц, гарц дээр хоёр хэлээр бичсэн тэмдэг, самбар суурилуулах. 14.2 Кемпийн газрын зөвшөөрөл авах. 14.3 Эмзэг бүсээс хол, авто замын ойролцоо байрлал сонгох. 14.4 Дэлгэрэнгүй төлөвлөгөөг батлуулахаар хүргүүлэх.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Тэмдэг, тэмдэглэгээ, кемпийн зохион байгуулалт	Барилгын ажлын өмнө
15	Кемпийн зохион байгуулалт, агуулах	Аюулгүй байдал, ариун цэвэр, орчны үзэмж	15.1 Газар тэгшлэх, хашаа барих, оффис, агуулах, усны сав, гал тогоо, ариун цэврийн байгууламжийг зохих журмын дагуу байрлуулах. 15.2 Зураг 8-ийн байгуулалтын зургийн дагуу энгийн тохижилт хийх. Хавсралт 5-ын Ажилчдын кемпийн төлөвлөлтийг үзнэ үү.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Кемп байгуулах өртөг	Барилгын ажлын өмнө

16	Замын хөдөлгөөн ба оршин суугчдад учрах хүндрэл	Замын түгжрэл, тойруу зам, нэвтрэх хязгаарлалт	16.1 Замын цагдаа, НЗХГ-тай хамтран ХЗБТ боловсруулах. 16.2 ХЗБТ-нд тээвэрлэлт хийх маршрутууд, тэмдэг, тэмдэглэгээ, түр хаалт, явган хүний гарц, сургууль болон түргэн тусламжийн нэвтрэх боломжийг тусгах. 16.3 Барилгын ажлын өмнө уулзалт зохион байгуулж, санал хүсэлтэд үндэслэн ХЗБТ-г шинэчлэх. 16.4 Хоёр хэлээр бичсэн тэмдэг, дүрс тэмдэг (пиктограмм) суурилуулах. 16.5 Жолооч нарт сургалт зохион байгуулж, хөдөлгөөн зохицуулагчийг томилох. 16.6 Замын хөдөлгөөнтэй холбоотой СГБМ-ыг боловсруулж, хэрэгжүүлэх. Хавсралт 3-ын Хөдөлгөөн зохион байгуулалтын төлөвлөгөө (ХЗБТ) болон Бүлэг 10-ын СГБМ-ыг үзнэ үү.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН, Замын цагдаа	Хөдөлгөөн зохион байгуулалтын өртөг	Барилгын ажлын өмнө ба барилгын ажлын үеэр
17	Нэвтрэх боломж, амжиргаанд үзүүлэх нөлөөллийг бууруулах	ААН-рүү нэвтрэх боломж, Эмзэг бүлгийн аюулгүй байдал	17.1 Айл өрх, дэлгүүр, бусад байгууламж руу нэвтрэх боломжийг хадгалах. 17.2 Шинэ орц руу зам хэрэглэгчдийг чиглүүлэх тэмдэг суурилуулах. 17.3 Хөдөлгөөнд саад учруулах ажлыг үйлчилгээний байгууллагуудын оргил цагаар гүйцэтгэхээс зайлсхийх.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Тэмдэг, тэмдэглэгээний өртөг	Барилгын ажлын туршид

			17.4 Замын хөдөлгөөний төлөвлөлтөд өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдийг нэн тэргүүнд тавих.				
18	Зөвлөлдөх уулзалт, Мэдээллийн ил тод байдал, ГБМ	Оршин суугчдын бухимдал, төөрөгдөл	18.1 Зам хаах хуваарь, холбогдох эрсдэлийн талаар олон нийттэй зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, мэдээлэл түгээх. 18.2 Постер, тараах материал, аман мэдээлэл, цахим орчныг ашиглах. 18.3 Эмзэг бүлгийн иргэдийг хамруулах. 18.4 Санал хүсэлтийг хянаж, төлөвлөгөөг шинэчлэх. ТОХТ (Бүлэг 9), СГБМ (Бүлэг 10)-ийг үзнэ үү.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Олон нийттэй харилцах төсөв	Барилгын ажлын туршид
19	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	Барилгын талбайн аюул, гэмтэл бэртэл	19.1 Монгол Улсын хууль журам, Дэлхийн Банкны ХАБЭА-н стандартыг мөрдөх. 19.2 ХХХ-ээр хангаж, өндөрт ажиллах журамд заасан хязгаарыг мөрдүүлж, ХХХ-ийг тогтмол шалгах. 19.3 Аюулгүй, цэвэр ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах. Хавсралт 2-ын Аюулгүй ажиллагааны журам (ААЖ,) болон Хавсралт 2.1-ийн Дотоод ХАБЭА-н журмыг үзнэ үү (Монгол хэлээр).	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	ХХХ, сургалтын өртөг	Барилгын ажлын туршид
20	Халдварт өвчин ба нийтийн эрүүл мэнд	Өвчний дэгдэлт болон аюултай нөхцөл	20.1 COVID-19, БЗХӨ, томуугийн протокол бүхий ХАБЭА-н дэд төлөвлөгөө боловсруулах. 20.2 Жил бүрийн сургалт, аюулгүй	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Сургалт, нийлүүлэлт	Барилгын ажлын туршид

			ажиллагааны хэлэлцүүлгийг зохион байгуулж, ариун цэврийн хэрэгслээр хангах. Хавсралт 4-ийн БОНҮАД-ийг үзнэ үү.				
21	Онцгой байдлын бэлэн байдал	Ослын үед арга хэмжээ авах чадавх дутмаг байх	21.1 ОБХАХТ боловсруулж, холбоо барих журам боловсруулж, сургуулилалт хийх, ажилчдыг бэлтгэх. 21.2 Кемпийг гал унтраагч, дохиолол, анхны тусламжийн хэрэгслээр хангах. 21.3 Талбайд мэргэжлийн эмч ажиллуулах. Бүлэг 11-ийн Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөөг үзнэ үү.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Онцгой байдал, яаралтай тусламжийн тоног төхөөрөмж	Барилгын ажлын туршид
22	БМХД-аас урьдчилан сэргийлэх	Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, дарамт	22.1 БМХД-ыг үл тэвчих бодлого хэрэгжүүлэх. 22.2 Ажилд авахдаа болон улирал тутам ажилчдад зориулан сургалт зохион байгуулах. 22.3 Ёс зүйн дүрэмд бүх ажилчдаар гарын үсэг зуруулна. 22.4 Нууцлалыг задлалгүй гомдол хүлээн авах сувгийг ажиллуулж хариуцсан ажилтанг томило. Хавсралт 2, 2.1-ийн Хөдөлмөрийн удирдлагын журмыг үзнэ үү.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Сургалтын өртөг	Барилгын ажлын туршид
23	Нийтийн эрүүл мэнд ба аюулгүй	Олон нийтийн эрсдэл, төөрөгдөл	23.1 Иргэдэд ойлгомжтой хэл, дүрслэлээр, хоёр хэл дээр постер бэлтгэн, идэвхтэй	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Мэдээлэл түгээх өртөг	Барилгын ажлын туршид

	байдлын мэдээлэл		мэдээлэл хүргэх. Бүлэг 9-ийн ТОХТ-г үзнэ үү.				
24	Талбайн аюулгүй байдал ба биет хамгаалалт	Олон нийтийн гэмтэл эсвэл зөвшөөрөлгүй нэвтрэх эрсдэл	24.1 Кемп болон аюултай бүсэд хашаа суурилуулах. 24.2 Жолооч, явган зорчигчдын харааны түвшинд тодорхой дүрс ашигласан, цаг уурт тэсвэртэй тэмдэг байрлуулах. Хавсралт 5- ын Ажилчдын кемпийг төлөвлөлтийг үзнэ үү.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Харуул хамгаалл ын өртөг	Барилгын ажлын туршид
25	Нэвтрэх хяналт, харуул хамгаалалт	Зөвшөөрөлгүй нэвтрэхтэй холбоотой аюулгүй байдлын эрсдэл	25.1 Эрсдэлтэй бүсэд 24 цаг хамгаалагч ажиллуулах. 25.2 Хамгаалагчдыг хүндэтгэлтэй, хүчирхийлэл хэрэглэхгүй харилцаанд сургах. Бүлэг 9-ийг үзнэ үү.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Харуул хамгаалл ын өртөг	Барилгын ажлын туршид
26	Ажилчдад мэдлэг олгох хөтөлбөр	Гүйцэтгэгч, ажилчид дагаж мөрдөхгүй байх	26.1 26.1 Тогтмол аюулгүй байдлын хэлэлцүүлэг зохион байгуулах, гарын авлага тараах, аюулгүй байдал, ажилчны эрх, олон нийттэй хүндэтгэлтэй харилцах талаар сургалт явуулах. Бүлэг 8-ын Сургалт явуулах ба Мэдлэг олгох хөтөлбөрийг үзнэ үү.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Сургалт ын өртөг	Барилгын ажлын туршид
27	Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт	Газар чөлөөлөлт, шилжилт хөдөлгөөн	27.1 Зураг төслийн шатанд Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (НШТ)-г боловсруулсан. Гүйцэтгэгч хэрэгжүүлэх үүрэггүй. Харин олон нийтийн санал	ТХН/ ГЗБГЗЗГ	Зөвлөх, ТХН, ГЗБГЗЗЕ Г	Хамаара лгүй	Зураг төслийн шатанд

			гомдлыг СГБМ-ын дагуу ГЗБГЗЗЕГ, ТХН-мэдээлнэ. НШТ-г үзнэ үү (БОНМТ-ний үндсэн баримт бичиг).				
28	СГБМ-ын ил тод байдал, хяналт	Олон нийт гомдол барагдуулах үйл явцыг ашиглах боломжгүй байх	28.1 Гүйцэтгэгчид ГБМ-ын сургалт явуулах. СГБМ-ын холбоо барих мэдээллийг (утас, факс, и-мэйл, хаяг) хороо бүрт түгээх. ТХН нь СГБМ-ын ажиллагааг хянан, БОНМТ-ний хүрээнд хэрэгжиж буй эсэхийг баталгаажуулна. Бүлэг 10-ын СГБМ болон Хавсралт 2, 2.1-ийн Ажилчдын гомдол барагдуулах механизмыг үзнэ үү.	Гүйцэтгэгч/ТХН	Зөвлөх, ТХН	Сургалт, мэдээлэл түгээх	Барилгын ажлын туршид

5.2. Барилгын ажлын шат

№	Төрөл	Нөлөөлөл ба асуудлууд:	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх	Хянах	Тооцоот өртөг	Хуваарь
1	Хөрс ба Ургамлын бүрхүүл	- Хөрсний эвдрэл, нягтралт, ургамлын бүрхүүлийн алдагдал - Элэгдэл, хөрсний доройтол үүсэх эрсдэл	- Түр хашаа, ариун цэврийн байгууламж суурилуулах. - Төслийн талбайг хамгаалж, тогтмол цэвэрлэх. - Олборлосон шороог ангиалан, боломжтой тохиолдолд дахин ашиглах. - Элэгдэл, асгаралтаас сэргийлэх хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх. - Өнгөн хөрсний түр агуулахад MNS 5916:2008 стандартыг мөрдөх.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Гэрээнд тусгасан	Барилгын ажлын туршид

		- Асгаралт, алдагдлаас үүдэлтэй бохирдол	- Эвдэгдсэн талбайг ногоонжуулж, өнгөн хөрсийг дахин ашиглан нөхөн сэргээх. - Хөрсний чанарын хяналтыг жилд ≥ 2 удаа, ≥ 5 цэгт хийх (Бүлэг 6). - Бохирдсон хөрсийг зохих ёсоор ухаж зайлуулах. - Ажлын талбайн хэмжээг нарийвчлан тогтоож, газрын нөөцийг хамгаалах. Холбогдох баримт бичиг: - Хавсралт 12 – Өнгөн хөрс хуулалт, хадгалалт ба дахин ашиглалтын төлөвлөгөө - Хавсралт 12.1 – Гүйцэтгэгчийн Өнгөн хөрстэй ажиллах журам (Монгол) – Монгол Улсад мөрдөж буй шаардлагын дагуу өнгөн хөрсийг хуулах, тээвэрлэх, хадгалах дотоод журам - Хавсралт 12.2 – Газрын эвдрэлийн журам ба зөвшөөрлийн маягт – Газрыг эвдэх бүх ажлын өмнө зөвшөөрөл авах үйл явц				
2	Агаарын чанар, Дуу чимээ, Доргион	- Машинаас ялгарах тоос, утаа - Дуу чимээ, доргион нь орон нутгийн иргэдэд	- Тоос дарахын тулд тогтмол ус цацах. - Агаарын бохирдлын MNS 4585:2016 стандартыг мөрдөх. - Ажлыг зөвхөн өдрийн цагт гүйцэтгэх; шөнийн ажил хийх бол урьдчилан мэдэгдэх. - Бага дуу чимээтэй тоног төхөөрөмж ашиглаж, дуу чимээний хаалт суурилуулах.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Гэрээнд тусгасан	Барилгын ажлын туршид

		хүндрэл учруулах - Агаарын чанарын стандартыг зөрчих	- Хувийн хамгаалах хэрэгсэл (ялангуяа чихний хамгаалалт) олгох. - Шаардлагатай тохиолдолд доргионы хяналт хийх. - Эмзэг бүсийн ойролцоо анхааруулах тэмдэг, дуу чимээ сааруулагч байрлуулах. Хавсралт 14-ийг үзнэ үү.				
3	Гадаргын ба Гүний ус	- Асгаралт, урсацын бохирдлоос үүдэх эрсдэл - Байгалийн урсац өөрчлөгдөх - Гүний ус бохирдуулах эрсдэл	- Их бороо, хур тунадасны үеэр барилгын ажил хийхээс зайлсхийх. - Кемп, агуулахад лаг баригч, ус зайлуулах байгууламжийг суурилуулах. - Хамгаалалтын бүсийн тухай 2015 оны А-230/127 тоот хамтарсан тушаалыг мөрдөх. - Түлшний агуулахыг зөвшөөрөгдсөн талбайд байршуулж, хамгаалах. - Замын коридорын ойролцоо тогтмол цэвэрлэгээ хийж, бохирдлоос урьдчилан сэргийлэх. - Ойролцоох нугын болон голын экосистемийг хамгаалах. - Усны тухай хуулийн 28.4, 29.1 дүгээр зүйлүүдийг мөрдөх. - Эрүүл ахуйн шаардлага хангасан ундны ус, цэвэр савнуудыг хангах. - Худаг бүрийг холбогдох журмын дагуу бүртгэж, тогтмол хяналт тавих.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Гэрээнд тусгасан	Барилгын ажлын туршид

			Хавсралт 13-ын Усны менежментийн төлөвлөгөөг үзнэ үү.				
4	Үерийн эрсдэл	- Талбай, эд хөрөнгө үерт автах эрсдэл - Барилгын ажлын саатал	- Сэлбэ голын үерийн улиралд ажил гүйцэтгэхээс зайлсхийх. - Эмзэг материалуудыг үерийн түвшнээс дээш байрлуулах. - Талбайн ус зайлуулах байгууламжийг бүрэн ажиллагаатай байлгах.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Гэрээнд тусгасан	Улирлын чанартай
5	Хог хаягдлын менежмент (үүнд аюултай хог хаягдал багтана)	- Талбай бохирдох эрсдэл - Хог хаягдлыг буруу ялгах, зайлуулах	- Талбайн онцлогт тохирсон Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх. - Хатуу хог хаягдлыг битүү саванд хадгалах. - Аюултай хог хаягдлыг шошголон, ялгаж ангилах. - Ажилчдад хог хаягдалтай ажиллах сургалт зохион байгуулах. - Хог хаягдлыг зөвшөөрөлтэй хогийн цэг рүү тээвэрлэх. - Ашигласан тос, тосолгооны материалыг аюулгүй хадгалах. - Асфальтан хучилтыг буулгасан тохиолдолд дахин боловсруулах. - Түр хадгалах цэгүүдийн битүүмжлэл, ангилалтыг сайжруулах. - Монгол Улсын хог хаягдлын тухай хууль тогтоомжийн дагуу бүх үйл ажиллагааг	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Хог хаягдлын менежментийн төсөв	Барилгын ажлын туршид

			явуулах. Бүлэг 13-ын Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг үзнэ үү.				
6	Амьтан, ургамал	- Амьдрах орчин алдагдах эрсдэл - Тоосжилт, барилгын ажлын сөрөг нөлөөлөл	- Шаардлагагүй үед мод, ургамлыг зайлуулахаас зайлсхийх. - Шилжүүлэн суулгалтад өнгөн хөрсийг дахин ашиглах. - Барилгын ажил дууссаны дараа Ногоон байгууламжийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх. - Эмзэг бүсэд ажил гүйцэтгэхээс зайлсхийж, нутгийн унаган ургамлыг хамгаалах.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Гэрээнд тусгасан	Барилгын ажлын туршид
7	Орон нутгийн иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэнд	- Нийтийн аюулгүй байдлын эрсдэл, тоосжилт, дуу чимээ - Үйлчилгээ тасалдах эрсдэл - ЖСХ/БМХД-д өртөх	- Явган хүний аюулгүй байдлыг хангах хэрэгсэл, тодорхой тэмдэг, тэмдэглэгээг суурилуулах. - Үйлчилгээ (цахилгаан, замын хөдөлгөөн, нэвтрэх боломж гэх мэт)-ний тасалдлын талаар олон нийтэд урьдчилан мэдэгдэх. - ГБМ, холбоо барих мэдээллийг танилцуулах самбар байрлуулах. - Олон нийттэй харилцах ажилтан (ОНХА)-ыг томилох. - Ёс зүйн дүрэм, ЖСХ/ БМХД-ын эсрэг сургалт зохион байгуулах. - Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөвлөгөө, ОТОТ-г хэрэгжүүлэх.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Гэрээнд тусгасан	Барилгын ажлын туршид

			- Ажлын цагийг хязгаарлаж, олон нийтэд учруулах саадыг багасгах. Хавсралт 4-ийн БОНҮАД-ийг үзнэ үү. ESCOP (4-р хавсралт).				
8	Оролцогч талуудын оролцоо ба гомдол	- Олон нийтийн сэтгэл ханамжгүй байдал - Төслийн удаашрал	- ТОХТ-г шинэчилж, хэрэгжүүлэх. - СГБМ-ыг ашиглах, сурталчлах. - Тогтмол мэдээлэл түгээх уулзалт зохион байгуулах. - Ажилчдад СГБМ-ын сургалт явуулах. - Гомдол, санал болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бүртгэн, хянах. Бүлэг 9-ийн ТОХТ, Бүлэг 10-ын СГБМ-ыг үзнэ үү.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Мэдээлэл түгээх төсөв	Барилгын ажлын туршид
9	Ажилчдын кемп	- Орон нутгийн иргэдтэй зөрчилдөх - Эрүүл ахуйн эрсдэл	- Кемпийг орон сууцны бүсээс хол байрлуулах. - Кемпийн дүрэм, Ёс зүйн дүрмийг боловсруулан, мөрдүүлэх. - Эрүүл мэндийн үйлчилгээ, цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар хангах. - Ажилчдад эрүүл ахуй, сахилга баттай холбоотой сургалт зохион байгуулах. Хавсралт 5-ын Ажилчдын кемпийн менежмент, Хавсралт 2, 2.1-ийн Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөөг үзнэ үү.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Кемпийн менежментийн төсөв	Барилгын ажлын туршид

10	Ажил эрхлэлт, орон нутагт ирэх өгөөж	- Орон нутгийн иргэдэд олдсон боломжийг алдах - Олон нийтийн сэтгэл ханамжгүй байдал	- Боломжтой тохиолдолд орон нутгийн эрэгтэй, эмэгтэй ажилтнуудыг ажилд авах. - Бригадын арга барилыг дэмжих. - Жижиг бизнес, албан бус худалдаачдыг дэмжих. - Ажлын байр, тендерийн сургалт зохион байгуулах. - Ажилгүй иргэдийг ажлын байранд зуучлахад туслах.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Гэрээнд тусгасан	Барилгын ажлын туршид
11	Хөдөлмөрийн нөхцөл ба ажилчдын эрх	Хөдөлмөрийн н зөрчил - Аюултай нөхцөл, хүүхдийн хөдөлмөрийн эрсдэл	- 2024 онд шинэчлэн найруулсан Хөдөлмөрийн тухай хууль, Дэлхийн банкны БОНС2-ыг мөрдүүлэх. - Бүх ажилтны нас, гэрээг баталгаажуулах. - Хөдөлмөрийн эрх, аюулгүй байдлын сургалтыг тогтмол зохион байгуулах. - Ажилчдын СГБМ-ыг ажиллуулах. - Шударга харьцах, соёлын мэдрэмжтэй байх. - ХХХ, багаж хэрэгслийг тогтмол шалгах. Хавсралт 2-ын Хөдөлмөрийн менежментийн журам, Хавсралт 2.1-ийн Дотоод ХАБЭА-н журмыг мөрдөх.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Сургалт, журмыг дагаж мөрдөх	Барилгын ажлын туршид

12	Соёлын өв	Бүртгэгдээгүй дурсгалт газрыг гэмтээх	- Хавсралт 1-ийн “Гэнэтийн олдворын журам”-ыг мөрдөх. - Олдвор илэрсэн даруйд ажлыг нэн даруй зогсоох. - Хариуцсан байгууллагад мэдэгдэх. - Шаардлагатай тохиолдолд соёлын өвийн мэдээллийн санг дэмжих.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Хамааралгүй	Барилгын ажлын туршид
13	Замын хөдөлгөөний аюулгүй байдал ба техник ашиглалт	- Хүнд даацын тээврийн хэрэгслийн осол - Барилгын талбайн хөдөлгөөний аюултай нөхцөл	- Хавсралт 3-ын Хөдөлгөөн зохион байгуулалтын төлөвлөгөөг мөрдөх. - Тоног төхөөрөмжийн операторуудыг сургах, тусгай зөвшөөрөл олгох. - Ухрах хөдөлгөөнд дохиолол ашиглах. - Хурдны хязгаар, тогтоосон чиглэлийг мөрдүүлэх. - Хувийн тээврийн хэрэгсэл, тээвэрлэлтийн автомашины хөдөлгөөнийг тогтоосон чиглэлд хязгаарлах. - Яаралтай гарах гарцыг тодорхой тэмдэглэж, чөлөөтэй байлгах. - Зөвхөн гэрчилгээтэй операторуудаар техник хэрэгсэл ажиллуулах.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Замын хөдөлгөөний удирдлагын зардал	Барилгын ажлын туршид
14	Ажилтан болон олон нийтийн эрүүл мэнд	- Гэмтэл, өвчин, гал түймэр, халдварт өвчин	- Бүлэг 11, Хавсралт 7-ын Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх. - Цэвэр ундны ус, аюулгүй хүнсээр хангах.	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	ХАБЭА-н төсөв	Барилгын ажлын туршид

		- Аюултай хүнс, ус	- Аюулгүй байдлын сургалт, дадлага сургуулийг тогтмол зохион байгуулах. - Анхны тусламжийн хэрэгсэл, гал унтраагуур байрлуулах. Бүлэг 11-ийн ОБХАХТ, Хавсралт 2-ын Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөө, Хавсралт 2.1-ийн Дотоод ХАБЭА-н журмыг үзнэ үү.				
--	--	--------------------	---	--	--	--	--

5.3. Ашиглалтын үе

№	Нөлөөллийн төрөл	Болзошгүй нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх	Хянах	Тооцоот өртөг	Хуваарь
1	Байгаль орчны	Үйл ажиллагаан аас гарах дуу чимээ	- Дууны ялгаруулалт бага зам засварын тоног төхөөрөмжийг сонгон ашиглах. - Тоног төхөөрөмжийн дуу чимээ, доргилтыг багасгахын тулд тогтмол засвар үйлчилгээ хийх. - Шаардлагатай тохиолдолд дуу намсгагч хана, доргилт сааруулагч төхөөрөмж суурилуулах. - Хэрэв дуу чимээний түвшин Монгол Улсын болон Дэлхийн банкны зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан бол сургууль, орон сууц зэрэг мэдрэмтгий бүсийн ойролцоо түр болон байнгын дуу чимээний хаалт суурилуулах.	Гүйцэтгэгчийн талбайн инженер ба ХАБЭА-н ажилтан (өдөр тутмын болон долоо хоног бүрийн шалгалт)	ТХН-ийн Байгаль орчны мэргэжилтэн / Зөвлөхийн БОН-ийн мэргэжилтэн (сар бүрийн хяналт)	Тооцоолно	


		Хоёрдогч болон ажлын талбайн хатуу хог хаягдлын хуримтлал	- Бүх үйл ажиллагааны талбайд тодорхой тэмдэглэгээ бүхий хог цуглуулах цэгүүдийг байгуулах. - Хог хаягдлыг дахин боловсруулах боломжтой, органик, аюултай гэсэн ангиллаар ялган цуглуулах. - Аюултай хог хаягдлыг хамгаалалттай саванд хадгалж, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаар зайлуулах. - Хуваарийн дагуу хог хаягдлыг зайлуулахын тулд орон нутгийн хог хаягдлын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах. - Ажилтнуудад хог хаягдлын менежментийн журамтай холбоотой сургалт явуулах. - Түр хадгалах болон засвар үйлчилгээний зориулалтаар ашигласан талбайг нөхөн сэргээх. Бүлэг 13-ын Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг үзнэ үү.	Гүйцэтгэгчийн Хог хаягдлын менежментийн ажилтан	ТХН-ийн Байгаль орчны мэргэжилтэн / Зөвлөхийн БОН-ийн мэргэжилтэн, Орон нутгийн хог хаягдал хариуцсан байгууллагууд	Тооцоолно	
		Замын хучилтын эвдрэл	- Гүйцэтгэгчийн хариуцсан засвар арчлалтын хугацаанд замын хучилтын нөхцөл байдлыг тогтмол шалгах. - Хагарал, нүх зэрэг эвдрэлийг илрүүлж тайлагнах. - Чанартай материал ашиглан цаг алдалгүй нөхөлт болон дахин хучилтын ажил гүйцэтгэх.	Гүйцэтгэгчийн засвар үйлчилгээний ахлах ажилтан	ТХН / Зөвлөх ба Зөвлөхийн БОН-ийн мэргэжилтэн	Тооцоолно	Ээлжит

			- Засвар арчлалтын бүртгэл, эвдрэлийн тайланг ТХН-д хүргүүлэх.				
		Нөхөн сэргээгүй эсвэл хангалтгүй нөхөн сэргээгдсэн шороон орд	- Барилгын ажил гүйцэтгэх явцад ашигласан шороон ордны талбайг шороогоор булах, хэлбэржүүлэх, тогтворжуулах. - Ургамал нөхөн ургуулахын тулд хадгалсан дээд хөрсийг тараан, үр тарих. - Зөвшөөрөлгүй нэвтрэхийг таслан зогсоохын тулд хашаа эсвэл анхааруулах тэмдэг байрлуулах. - Усыг тогтоон барих болон элэгдэл үүсэхээс сэргийлэхийн тулд зохих ус зайлуулах нөхцөлийг бүрдүүлэх. - Гэрэл зураг, GPS координат бүхий талбайн нөхөн сэргээлтийн тайланг гаргаж өгөх.	Гүйцэтгэгчийн Байгаль орчны ажилтан	ТХН-ийн хяналтын баг, Зөвлөхийн БОН-ийн мэргэжилтэн, орон нутгийн байгаль орчны байцаагч	Тооцоолно	Ажил дууссаны дараа
		Байгаль орчны тохижилт ба нөхөн сэргээлт	Ногоон байгууламж, мод тарих, талбайг зүлэгжүүлэх, эвдэрсэн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх ажлыг холбогдох үндэсний стандартууд (MNS 5918:2023, MNS 6258-1:2011, MNS 6258-2:2011) болон Дэлхийн банкны БОНХ-ний шаардлагууд (БОНС1 ба БОНС6)-тай нийцүүлэн, Хавсралт 17-ын Байгаль орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ. Техникийн шаардлагын Бүлэг 138, 139-ийн дагуу төслийн сүүлийн үе	Гүйцэтгэгчийн Байгаль орчны ажилтан	Дүүргийн захиргаа	Хавсралт 17-ын дагуу	

			шатуудад талбайгаас ажиллах хүч, машин механизмыг татах, ажил дуусах үеэр Гүйцэтгэгч, Зөвлөх нар зөвлөлдсөний үндсэн дээр Нарийвчилсан нөхөн сөргөөх төлөвлөгөөг боловсруулна.				
	Нийгмийн	Замын хөдөлгөөний эрчим, хурд нэмэгдэх	- Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үүдэн замын хөдөлгөөний эрчим нэмэгдэх тохиолдолд зохистой хурд сааруулах арга хэмжээг (жишээлбэл, хурд сааруулагч, замын тэмдэг) суурилуулах. - Суурилуулсан бүх тэмдэг, замын хөдөлгөөний аюулгүй байдлын байгууламжийг хэвийн ажиллагааг хангах. - Эрсдэл өндөртэй бүсийн талаар орон нутгийн захиргаанд мэдээлж, уялдаа холбоотой ажиллах. - Боломжтой бол сургууль, орон сууцны бүсийн ойролцоо оргил цагийн үед ажил гүйцэтгэхээс зайлсхийх. Хавсралт 3-ын ХЗБТ-г мөрдөх.	Гүйцэтгэгчийн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын ажилтан	ТХН болон Орон нутгийн Замын цагдаагийн хэлтэс, Зөвлөхийн БОН-ийн мэргэжилтэн	Тооцоолно	
		Явган хүн, хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлын эрсдэл	- Ажил явж буй бүсэд хангалттай, тод харагдахуйц замын тэмдэг, хурдны хязгаарын тэмдэг, явган хүний гарц, гэрэлтүүлгийг хангах. - Ажилтнуудад анхны тусламж болон яаралтай тусламжийн сургалт зохион байгуулах.	Гүйцэтгэгчийн аюулгүй байдлын ажилтан	ТХН-ийн Аюулгүй байдлын баг, Зөвлөхийн БОН-ийн	Тооцоолно	

			- Яаралтай үед холбоо барих утас, ашиглахтоног төхөөрөмжийн жагсаалт бүхий Зам тээврийн ослын дараах хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх. - Замтай холбоотой бүх осол болон ослоос зайлсхийсэн тохиолдлыг ТХН-д 24 цагийн дотор мэдэгдэх. Бүлэг 11, Хавсралт 7-ын Яаралтай тусламжийн төлөвлөгөөг үзнэ үү.		мэргэжилтэн, Яаралтай тусламжийн алба (шаардлагатай бол), Орон нутгийн Байгаль орчны байцаагч (газар дээрх аудит)		
		Эмзэг бүсүүдэд үзүүлэх дуу чимээний нөлөөлөл	- Сургууль, эмнэлэг, орон сууц зэрэг эмзэг бүсийн ойролцоо дуу чимээний түвшинг хянах. - Нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх (жишээлбэл, их дуу чимээтэй ажлыг зөвхөн өдрийн цагаар гүйцэтгэх, дуу намсгагч ашиглах, дууны хаалт босгох). - Бүх үйл ажиллагааг Монгол Улсын MNS 4585:2016 стандарт болон Дэлхийн банкны БОНС-ын удирдамжид нийцүүлэн хэрэгжүүлэх. - Дуу чимээний бүртгэл хөтөлж, сар бүрийн тайлангийн хамт ТХН-д хүргүүлэх.	Гүйцэтгэгчийн байгаль орчны ажилтан	ТХН-ийн БОН-ийн, Зөвлөхийн БОН-ийн мэргэжилтэн, Орон нутгийн Байгаль орчны байцаагч (газар	Тооцоолно	

					дээрх аудит)		



Зураг 9. Кемтийн зохион байгуулалтын зураг

6. Хяналтын төлөвлөгөө

Гүйцэтгэгч нь стандартчилсан “Өдөр тутмын байгаль орчны хяналтын хуудас”-ыг ашиглан өдөр бүр байгаль орчны хяналтыг гүйцэтгэнэ. Энэхүү хяналтын хуудас нь тоосжилт, дуу чимээ, хог хаягдлыг ангилах, аюултай материалын зохистой ашиглалт, эвдрэл элэгдлийн хяналт, гадаргын усны хамгаалалтын хяналтыг багтаасан. Бөглөсөн маягтуудыг төслийн талбайд хадгалж, Байгаль орчны мэргэжилтэн, Зөвлөхөөр долоо хоног бүр шалгуулна.

► Хавсралт 16: Өдөр тутмын байгаль орчны хяналтын хуудас

*Хүснэгт 10. Байгаль орчны хяналтын төлөвлөгөө – Барилгын ажлын шат
(Барилгын ажлын шат: 2025 оны 7-р сар – 2026 оны 10-р сар)*

№	Хяналтын нэр	Хяналт хийх байршил ²	Аргачлал/ Үзүүлэлт	Байгаль орчны ГШҮ	Давтамж	Хариуцагч	Стандарт/ Удирдамж
1	Орчны агаарын чанар	Төслийн замын зурвас талбайн дагуу 7 цэг	SO ₂ , NO ₂ , TSP, PM ₁₀ , PM _{2.5} ; тоосжилтын ажиглалт	- PM ₁₀ & PM _{2.5} ≤ Монгол Улс, ДБ-ны хязгаараас хэтрэхгүй - Тоосжилттой холбоотой ≤ 3 орон нутгийн иргэдийн гомдол/ сар	Барилгын улиралд (4-р сарын 15-наас 10-р сарын 15 хүртэл) 2 долоо хоног тутам, нийт 42 удаа	Гүйцэтгэгч	MNS 4585:2016, MNS 5061:2001, ДБ-ны БОЭМАБ-ын удирдамж

² Хяналт хийх байршлын дэлгэрэнгүй мэдээллийг "Бүлэг 2.1. Одоогийн байгаль орчны нөхцөл байдал ба гүйцэтгэгчийн арга хэмжээ"-нд танилцуулсан. Өмнө нь тайлбарласан мэдээллийг олон удаа давтах, хүснэгтийн форматыг алдагдуулахаас зайлсхийн доор оруулаагүй болно.

2	Дуу чимээ	Дээрх 7 цэг	Дууны түвшин дБ(А)-аар	- Өдрийн цагт ≤ 65 dB(A), шөнийн цагт ≤ 55 dB(A) - Дуу чимээтэй холбоотой ≤ 2 гомдол/сар	Барилгын улиралд (4-р сарын 15-наас 10-р сарын 15 хүртэл) 2 долоо хоног тутам, нийт 42 удаа	Гүйцэтгэгч	MNS 0012-1-009:1985, ДБ-ны БОЭМАБ-ын удирдамж
3	Гадаргын усны чанар	Төслийн замын зурвас талбайн дагуу Сэлбэ голын 4 цэг	pH, EC, хатуулаг, Na, K, Ca, Mg, NH ₄ , Fe, F, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , PO ₄ , HCO ₃ , TDS, BOD, хүнд металлууд; тунгалагжилт	Бүх үзүүлэлт зөвшөөрөгдөх хэмжээнд байх; Тунгалагжилтын өөрчлөлт суурь хэмжээнээс $\leq 10\%$	Барилгын улиралд (4-р сарын 15-наас 10-р сарын 15 хүртэл) сар бүр, нийт 30 удаа	Гүйцэтгэгч	MNS 4943:2015, ДЭМБ-ын удирдамж
4	Усан орчны сээр нуруугүй амьтад	Дээрхтэй адил Сэлбэ голын 4 цэг: ПК0+080 баруун тал; ПК 0+500 баруун	Усан орчны сээр нуруугүй амьтдын тоо болон төрөл	Олон янз байдлын бууралт суурь түвшнээс $\leq 20\%$	3 сар тутам (улирал бүр), нийт 9 удаа	Гүйцэтгэгч	ДБ-ны БОЭМАБ-ын удирдамж

		тал; ПК 1+020 баруун тал; ПК 2+180 баруун тал	зүйлийн олон янз байдал				
5	Хөрсний чанар	Төслийн замын зурвас талбайн дагуу 6 цэг	pH, давсжилт, EC, CaCO ₃ , NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O, Mg ²⁺ , Ca ²⁺ , хүнд металлууд (Zn, Cr, Pb, Cu, Ni, As, Cd); бактериологи; ширхэгийн хэмжээ	- Хүнд металлын агууламж зөвшөөрөгдөх босго хэмжээнээс хэтрэхгүй; - Хөрсний үржил шимийн үзүүлэлт тогтвортой байх	Once per month (15 April–15 Oct), 36 times	Гүйцэтгэгч	MNS 5850:2019, MNS 6341:2012, MNS 3297:2019
6	Хог хаягдлын менежмент	Ажилчдын кемп, замын ажлын бүсүүд	Өдөр тутмын үзлэг, ангилалтын бүртгэл, фото баримт	- $\geq 90\%$ хатуу хог хаягдал зөв ангилагдсан байх; - Хууль бус хаягдал зайлуулах ≤ 2 удаа/сар	2 долоо хоног тутам (4-р сарын 15-наас 10-р сарын 15), нийт 42 удаа	Гүйцэтгэгч	УХЗАА-ны Хог хаягдлын менежментийн талаар заавар, ДБ-ны БОЭМАБ, Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хууль, ЗГ-ын 2018 оны

							116 дугаар тогтоол
7	Нийгэм, эдийн засгийн холбогдолтой санал хүсэлт	Орон нутгийн хороод, захиргааны нэгжүүд	Иргэдийн санал асуулга, олон нийтийн уулзалт, санал-гомдлын бүртгэл		Жилд нэг удаа (10-р сар), нийт 3 удаа	Гүйцэтгэгч	ДБ-ны БОНС5, Олон нийтийн оролцооны тухай Монгол Улсын хуулиуд
8	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналт	Төслийн коридор дагуу	7 хоног бүрийн ослын бүртгэл, тохиолдлын үнэлгээ		Долоо хоног бүр	Гүйцэтгэгч	ДБ-ны БОНС4, ДБ-ны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын сайн туршлагын тэмдэглэл
9	ХЗБТ-ний хэрэгжилт	Орц гарц, тээвэрлэлийн замууд	Хурдны хяналт, ХЗБТ-нд заасан тэмдэг, тэмдэглэгээний хэрэгжилт		Долоо хоног бүр	Гүйцэтгэгч	ХЗБТ, ДБ-ны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тэмдэглэл, Монгол улсын Замын хөдөлгөөний дүрэм

10	ХАБЭА, асгаралт ба аюул	Өндөр эрсдэлтэй барилгын бүсүүд	ХХХ-ийн шалгалт, анхааруулах тэмдэг-тэмдэглэгээ, асгаралтын багцын бэлэн байдал		Тогтмол	Гүйцэтгэгч	ДБ-ны БОЭМАБ-н удирдамж, Монгол Улсын ХАБЭА-н тухай хууль
----	-------------------------	---------------------------------	---	--	---------	------------	---

Хүснэгт 11 Нийгэм, эдийн засаг, замын хөдөлгөөн, эрүүл мэнд, аюулгүй байдлын хяналтад зориулсан нэмэлт ГШҮ

Хяналтын чиглэл	Үзүүлэлт / Шалгуур	Зорилт / Хязгаар	Давтамж / Хугацаа	Үүрэг, хариуцлага	Лавлагаа / Стандарт
Нийгэм, эдийн засгийн санал гомдол	Барилгын үйл ажиллагаатай холбоотой гомдол, саналын тоо	орон нутгийн иргэдээс сард ≤ 3 гомдол	Сар бүр	Нийгмийн мэргэжилтэн / СГБМ-ийн гол хүлээн авагч	Дэлхийн банкны БОНС10, Төслийн СГБМ
	Гомдлыг шийдвэрлэх хугацаа	14 хоногийн дотор 100% шийдвэрлэгдэх	Сар бүр	Нийгмийн мэргэжилтэн / СГБМ-ийн гол хүлээн авагч	ДБ БОНС10
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналт	Зурвас талбайд гарсан осол, зөрчлийн тоо	Амиа алдсан тохиолдол бүртгэгдээгүй; жилд ≤ 2 хөнгөн осол	Сар бүр / Ослын дараа	ХАБЭА-н мэргэжилтэн / Замын цагдаа	Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм, ДБ-ны БОЭМАБ-ын Удирдамжууд
	Замын тэмдэг, тэмдэглэгээ, хурдны	100% дагаж мөрдсөн	7 хоног бүр	ХАБЭА-н мэргэжилтэн / Замын цагдаа	Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм, Төслийн ХЗБТ

	хязгаарыг мөрдүүлсэн байдал				
Хөдөлгөөн зохион байгуулах төлөвлөгөө (ХЗБТ)-ний хэрэгжилт	ХЗБТ-ний хэрэгжилт: тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулагч, чиглэл өөрчлөх, ажилчдын ХХХ	Барилгын ажил идэвхтэй өрнөж буй талбайд 100% хэрэгжүүлсэн	7 хоног бүр	ХАБЭА-н мэргэжилтэн, Төслийн менежерийн хяналт дор	ДБ-ны БОЭМАБ-ын Удирдамжууд, Төслийн ХЗБТ
	Тээврийн хэрэгсэл/техникийн зөвшөөрөгдсөн чиглэлээр зорчсон байдал	Зөвшөөрөлгүйг ээр чиглэлээс хазайсан хөдөлгөөн бүртгэгдээгүй	7 хоног бүр / Түүвэр шалгалт	ХАБЭА-н мэргэжилтэн / Замын цагдаа	Төслийн ХЗБТ
Эрүүл ахуй & Аюулгүй байдал (Талбайн ажилчид)	ХХХ-ийн хэрэглээ	Ажилчид 100% зөв ХХХ-ийг өмсөж байх	Өдөр бүр / Түүвэр шалгалт	ХАБЭА-н мэргэжилтэн	Монгол Улсын ХАБЭА-н тухай хууль, ДБ-ны БОЭМАБ-ын Удирдамжууд
	Ажлын байрны ослын тоо	Амиа алдсан тохиолдол бүртгэгдээгүй; улиралд ≤ 2 хөнгөн гэмтэл	Сар бүр / Ослын дараа	ХАБЭА-н мэргэжилтэн	Монгол Улсын ХАБЭА-н тухай хууль, ДБ-ны БОЭМАБ-ын Удирдамжууд
Асгарсан ба аюултай материалууд	Химийн бодис, түлш болон аюултай бодисын асгаралт, алдагдлын тоо	Томоохон асгаралтын тоо: 0; Сард ≤ 1 бага зэргийн асгаралтын тохиолдол	7 хоног бүр / Үйл явдалд суурилан	Байгаль орчны мэргэжилтэн, ХАБЭА-н мэргэжилтэн дэмжлэг үзүүлнэ	Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, ДБ-ны БОЭМАБ-ын Удирдамжууд

	Асгаралтын хариу арга хэмжээ болон цэвэрлэгээ	24 цагийн дотор 100% цэвэрлэгдсэн байх	Үйл явдалд суурилан	Байгаль орчны мэргэжилтэн / ЭМАББО-ны ажилтан	ДБ-ны БОЭМАБ-ын Удирдамжууд, Төслийн Стандарт үйл ажиллагааны журам
Аюулын талаар мэдэгдэх ба засч залруулах арга хэмжээ	Бүртгэгдсэн, засч залруулсан аюулын тоо	7 хоногийн дотор 100% шийдвэрлэгдэх	7 хоног бүр / Үйл явдалд суурилан	ХАБЭА-н мэргэжилтэн, Төслийн менежерийн хяналт дор	ДБ БОНС2, Төслийн ХАБЭА-н журам

7. Байгаль орчин, нийгмийн асуудлаар тайлагнах үйл явц, баримт бичгийн хадгалалт

7.1. Тайлагнах үүрэг ба хуваарь

Тогтмол, үнэн зөв тайлагнах нь БОНМТ-г амжилттай хэрэгжүүлэх үндэс суурь юм. Ингэснээр сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, хариуцлагын тогтолцоог бий болгох, Монгол Улсын хууль журам, Дэлхийн банкны БОНС-ын шаардлагыг биелүүлэх боломж бүрддэг.

Хүснэгт 12. Тайлагнах үүрэг, хариуцлага ба Тайлагнах хуваарь

а) Гол тайлагнах үүрэг, хариуцлага

Байгууллага	Үүрэг, хариуцлага
Гүйцэтгэгч	- Ажлын талбай болон кэмпүүдэд дор хаяж хоёр долоо хоног тутамд байгаль орчин, нийгмийн үзлэг шалгалт хийх. - Фото зураг, талбайн үзлэгийн дүгнэлт, зөрчил, засч залруулах арга хэмжээг тоймлосон Сар бүрийн Байгаль орчин, нийгмийн Явцын тайланг бэлтгэн, ТХН-д хүргүүлэх. - Байгаль орчны зөвшөөрөл, үзлэгийн дүгнэлт, сургалтын үйл ажиллагаа, гомдол, хог хаягдлын бүртгэл, усны хэрэглээний бүртгэлийг хөтлөн, хадгалах. - 11-р сарын 1-ний өдөрт багтаан БОНМТ-ний хэрэгжилтийн жилийн тайланг (монгол хэл дээр) Нийслэлийн Байгаль орчны газар (НБОГ) болон Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэх. - Жил бүрийн хог хаягдлын менежмент, усны хэрэглээний бүртгэлийг дүүргийн байгаль орчны мэргэжилтэнд өгөх. - Жил бүр хороодод шаардлагатай баримт бичгийг хүргүүлэх.
ТХН (Төсөл хэрэгжүүлэх нэгж)	- Гүйцэтгэгчээс ирүүлсэн сар болон жилийн тайланг хянах. - Жил бүрийн 1-р сарын 1, 7-р сарын 1-нд Дэлхийн банканд хагас жилийн БОНМТ-ний хэрэгжилтийн тайланг илгээх. Уг тайланд дараах мэдээллийг тусгах шаардлагатай: БОНМТ-ний хэрэгжилт, үр дүн; Хяналт-шинжилгээний өгөгдөл, лаборатороор баталгаажсан тайлангууд (агаар, дуу чимээ, ус гэх мэт); Сургалт, санал-гомдол, нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийн дүн. - Ирэх жилийн БОНМТ-г монгол хэл дээр 12-р сарын 31-ний өдөрт багтаан НБОГ-т хянуулан, батлуулахаар хүргүүлэх. - Талбайн үзлэг, сургалт, санал-гомдол гаргасан тохиолдлын талаарх тайлангийн бүртгэл, фото зургийг хадгалах.

НБОГ (Нийслэлийн Байгаль орчны газар)	- Гүйцэтгэгчээс ирүүлсэн БОНМТ-ний хэрэгжилтийн бүтэн жилийн тайланг хянах. - Ирэх жилийн БОНТ-г хянаж, батлах. - Шороон ордны нөхөн сэргээлт, байгаль орчны хууль журмын нийцлийн асуудлаар техникийн дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах.
Байгаль Орчны Судалгаа, Шинжилгээний Төв	- Гүйцэтгэгчийн хяналт-шинжилгээний хуваарийн дагуу агаар, дуу чимээ, ус, хөрсний чанарын мэргэжлийн шинжилгээ хийх. - Магадлан итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэх. - Баталгаажсан өгөгдөл, фото зураг бүхий Хяналтын тайланг жилд 2-3 удаа Гүйцэтгэгч, ТХН-д хүргүүлэх.
Дэлхийн банк	- ТХН-ээс БОНМТ-ний хэрэгжилтийн хагас жилийн тайлан , холбогдох хяналт-шинжилгээний өгөгдөл, дүгнэлтийг хүлээн авч, архивлах.

б) Тайлагнах хуваарь

Тайлангийн төрөл	Боловсруу лах	Хүлээн авах	Давтамж	Эцсийн хугацаа
Сар бүрийн Байгаль орчин, нийгмийн тайлан	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Сар бүр	Сар бүрийн төгсгөл
Хоёр долоо хоног тутмын талбайн үзлэгийн бүртгэл	Гүйцэтгэгч	Зөвлөх, ТХН	Хоёр долоо хоног тутам	Тасралтг үй
БОНМТ-ний хэрэгжилтийн бүтэн жилийн тайлан (монгол хэл дээр)	Гүйцэтгэгч	НБОГ, Дүүргийн Засаг даргын тамгын газар	Жил бүр	11-р сарын 01
Ирэх жилийн БОНТ (монгол хэл дээр)	Гүйцэтгэгч	НБОГ	Жил бүр	12-р сарын 31
Байгаль орчны хяналтын тайлан	Байгаль Орчны Судалгаа, Шинжилгэ эний Төв	Гүйцэтгэгч, Зөвлөх, ТХН	Жилд 2-3 удаа	Хуваари йн дагуу
БОНМТ-ний хэрэгжилтийн хагас жилийн тайлан	ТХН	Дэлхийн банк	Жилд 2 удаа	1-р сарын 1, 7-р сарын 1

7.2. Баримт бичиг хөтлөлт, архив

Г-БОНМТ-ний хэрэгжилтэд оролцогч бүх талууд холбогдох баримт бичгийг зохих ёсоор хадгалах үүрэгтэй. Байгууллага бүрээс томилогдсон ажилтан нь байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлтэй холбоотой баримт бичгийг найдвартай хадгалах, цаг тухайд нь шинэчлэх үүрэг хүлээнэ.

Хүснэгт 13. Баримт бичиг хадгалах үүрэг, хариуцлага

Байгууллага	Баримт бичиг хадгалах үүрэг, хариуцлага
Гүйцэтгэгч	- Үзлэгийн огноо, авч хэрэгжүүлсэн нөлөөллийг бууруулах арга хэмжээ, илрүүлсэн асуудлын бүртгэл хөтлөн, хадгалах. - Сар тутмын тайлан, талбайн нөхцөл байдлын гэрэл зураг, засч залруулах арга хэмжээний баримт бичгийг архивлах. - Байгаль орчинтой холбоотой зөвшөөрлийг талбай дээр хадгалах. - Сургалт, санал-гомдлын бүртгэл болон туслан гүйцэтгэгчдийн хууль журам, төлөвлөгөөг мөрдсөн нотолгоог хадгалах. - Зөвлөх, ТХН-ээс ирүүлсэн албан бичиг, зөвлөмжийг архивлах.
ТХН	- Гүйцэтгэгчийн бүх сар, жилийн тайлан, хяналт-шинжилгээний тайлан, сургалтын бүртгэлийг хадгалах. - Дэлхийн банк, НБОГ-д хүргүүлсэн тайлангийн хуулбарыг хадгалах. - Үзлэг, олон нийтийн оролцоо, санал-гомдлын шийдвэрлэлтийн фото зургийг архивлах. - Баримт бичгийн хувилбарууд, илгээсэн материалын бүртгэл хөтлөх.
НБОГ	- Жил бүрийн Г-БОНМТ-ын хэрэгжилтийн тайлан, батлагдсан ирэх жилийн БОМТ-г (монгол хэл дээр) архивлах. - Талбайн үзлэг, хяналт, сургалтын үйл ажиллагааны баримт бичиг, гэрэл зургийг хадгалах. - Санал-гомдлын бүртгэл, байгаль орчинтой холбоотой зөвшөөрлийг хадгалах.
Байгаль Орчны Судалгаа, Шинжилгээний Төв	- Бүх анхдагч хяналт-шинжилгээний өгөгдөл, лабораторийн шинжилгээний дүн, эцсийн тайланг хадгалах. - Дээж авсан байршил, талбайн ажлын гэрэл зургийг архивлах. - Гүйцэтгэгч, ТХН-д хүргүүлсэн бүх тайлангийн бүртгэл хөтлөх.
Дэлхийн банк	- ТХН-ээс ирүүлсэн Г-БОНМТ-ний хэрэгжилтийн хагас жилийн тайлан, дагалдах баримт бичгийн дижитал болон/эсвэл хэвлэмэл хувилбарыг хадгалах.

8. Сургалт хийх ба чадавхыг бэхжүүлэх төлөвлөгөө

Үр дүнтэй сургалт хийх, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа нь төсөлд оролцож буй бүх ажилтан (менежерүүд, техникийн ажилтнууд, операторууд, ажилчид, туслан гүйцэтгэгчид) нь байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА), хүний нөөцийн удирдлагын стандартуудыг ойлгож, мөрдөхөд чухал ач холбогдолтой. Гүйцэтгэгч нь БОНМТ, төслийн зураг төслийн шатанд тодорхойлсон бусад шаардлагуудыг хангахын тулд энэхүү бүлэгт заасан сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Сургалтын үйл ажиллагаа нь эрсдэлийн менежментийн чадавхыг бэхжүүлэх, холбогдох Монгол Улсын хууль тогтоомж, Дэлхийн банкны БОНС-ын шаардлагуудыг хангах, онцгой байдлын үеэр үр дүнтэй хариу арга хэмжээ авах, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах, байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэхэд шаардлагатай мэдлэгээр ажилтнуудыг хангахад төвлөрнө.

8.1 Сургалтын хөтөлбөрийн зорилго

Сургалт болон чадавх бэхжүүлэх төлөвлөгөөний гол зорилго

- БОНМТ болон тавигдах шаардлагыг нийт ажилчдад танилцуулах;
- Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг удирдах ажилтнуудын чадавхийг нэмэгдүүлэх;
- Холбогдох хууль эрх зүйн орчин, шилдэг туршлагын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх;
- Гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгчид тухайн талбайн нөлөөллийг бууруулах, хяналт тавих үүрэг хариуцлагын талаар ойлгож байгаа эсэхийг баталгаажуулах;
- Ажилчдыг онцгой байдлын үед (бодис асгарах, гал түймэр гарах, цахилгааны аюул гэх мэт) бэлтгэх;
- Аюулгүй зан үйл, хүндэтгэлтэй зан харилцаа, гомдлыг үр дүнтэйгээр шийдвэрлэх зэргийг дэмжих;
- Эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, нийгмийн ажилтнуудын үүргийг бэхжүүлэх.

8.2 Цар хүрээ, үүрэг хариуцлага

Гүйцэтгэгчийн ЭМАБХГ сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг харицна. Гол үүрэг хариуцлага нь:

- Дотоод болон гадны байгууллагын сургалт зохион байгуулах;
- Гуравдагч талын сургалтын үйлчилгээ үзүүлэгчтэй уялдаа холбоотой ажиллах;
- Холбогдох ажилтнуудын ирцийг хангах;

- Сургалтын бүртгэл хөтлөх (огноо, оролцогчид, байршил, зардал, агуулга зэрэг);
- Сургалтын үр нөлөөг үнэлэх, шаардлагатай тохиолдолд агуулгыг шинэчлэх;
- Хамтарсан сургалт, хяналтын чиглэлээр ТХН, Замын хөгжлийн газар (ЗХГ), хяналтын зөвлөхүүдтэй хамтран ажиллах.

8.3 Сургалтын Хөтөлбөрийн Хураангуй

Дараах хүснэгтэд эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, нийгэм, хүний нөөцийн чиглэлээр зохион байгуулагдах сургалтын дэлгэрэнгүй хуваарийг харуулав. Энэхүү төлөвлөгөөнд БОНМТ болон зураг төслийн үе шатанд өгөгдсөн зөвлөмжтэй уялдуулан дотоод чадавхийг бэхжүүлэх арга хэмжээ болон гадны байгууллагын сургалт авах хэрэгцээ байгаа эсэхийг нэгтгэсэн.

Хүснэгт 14. Ерөнхий гүйцэтгэгчийн Сургалтын Хуваарь: Байгаль орчин, Нийгэм, Эрүүл мэнд, Аюулгүй байдал, Хүний нөөцөд тавигдах шаардлага

Сургалт зохион байгуулах чиглэл	Сэдэв	Тайлбар	Зорилтот оролцогч ид	Хугацаа	Хариуцах нэгж
Аюулгүй ажиллагааны ерөнхий танилцуулга	БОНЭМА Б-ын талаарх чиглүүлэх сургалт	Төсөлд хамаарах эрсдэл, хууль тогтоомж, аюул, СГБМ, талбайд баримтлах дүрэм зэргийг хамарна.	Шинээр ажилд авсан бүх ажилчид	2025.III улирал (улирал тутам)	ЭМАБХГ, ХН
ХАБЭА	Онцгой байдал болон нүүлгэн шилжүүл элтийн бэлэн байдал	Гал, цахилгаан, химийн ослын хариу арга хэмжээ	Талбайн бүх ажилчид	2025.III улирал, 2026.II улирал	ЭМАБХГ, Онцгой байдлын агентлаг
	Анхны тусламжийн хариу арга хэмжээ	CPR, гэмтэлд үзүүлэх анхны тусламж	Бүх ажилчид	2025.III улирал	ЭМАБХГ, Кэмпиин эмч

	Тоног төхөөрөмж, машин механизмын аюулгүй байдал	Аюулгүй ажиллагаа, урьдчилж шалгах, хамгаалах хэрэгсэл, дохиол	Оператор, жолооч	2025.III улирал	ЭМАБХГ
Байгаль орчны менежмент	Бодис асгарах, хог хаягдлын менежмент	Бодис асгарахаас сэргийлэх, хаягдлыг ялгах, устгахах	Талбайн бүх ажилчид	2025.III улирал	Байгаль орчны мэргэжилтэн
СГБМ, олон нийтийн ойлголт, мэдлэг	СГБМ-ын процедур	Гомдол шийдвэрлэх, нууцлалыг хангах	Бүх ажилчид	2025.III улирал	Нийгмийн мэргэжилтэн
	Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл ахуй	КОВИД-19, ХДХВ, ариун цэвэр сахих	Бүх ажилллах хүч	2025.III улирал	Нийгмийн мэргэжилтэн, Эмч
	Соёлын өвийг хамгаалах	Гэнэт олдсон дурсгалын талаар баримтлах журам	Талбайн бүх ажилчид	2025.III улирал	Байгаль орчин, Нийгмийн мэргэжилтэн
Хүний нөөц	Ёс зүйн журмын танилцуулга	Ёс зүй, зан харилцаа, баримтлах дүрэм журам	Бүх ажилллах хүч	2025.III улирал	Хүний нөөцийн ажилтан
	Жендер, тэгшбайд ал	Эмзэг байдал, Дарамт шахалтаас урьдчилан сэргийлэх	Жолооч, харуул, логистик хариуцсан ажилтан	2025.III улирал	Хүний нөөцийн ажилтан

Кэмп, гал тогоо	Хүнс, кэмгийн эрүүл ахуй	Аюулгүй хоол хүнс, гал тогоонд баримтлах журам	Тогооч	2025.III улирал	ЭМАБХГ , Эмч
--------------------	-----------------------------------	--	--------	--------------------	-----------------

8.4 Хяналт-шинжилгээ, бүртгэл хөтлөлт

Сургалтын бүх үйл ажиллагааг гарын үсэг зурсан ирцийн хуудас, сургалтын агуулгын хураангуй, шаардлагатай бол гэрэл зургаар баталгаажуулсан нотлох баримтыг ашиглан баримтжуулна. Гүйцэтгэгч нь сургалтын тусгай бүртгэл хөтлөнө. Үүнд:

- Сургалт зохион байгуулсан огноо, сэдэв;
- Оролцогчийн нэр, албан тушаал, хүйс;
- Сургагч багш, зохион байгуулса нэгж;
- Тараах материал болон гол суралцсан агуулга;
- Оролцогчдын санал хүсэлт.

8.5 Гүйцэтгэгчийн дэлгэрэнгүй сургалтын төлөвлөгөө

Гүйцэтгэгчийн зохион байгуулах Сургалтын дэлгэрэнгүй төлөвлөгөөг Хавсралт 15-д оруулсан. Тухайн төлөвлөгөөг төслийн үе шатуудад нийцүүлэн боловсруулсан бөгөөд дараахь байдлаар хуваасан.

- **Барилга угсралтын өмнөх үе шатны сургалт:** Баримжаа олгох, БОНАБЭА-н талаарх мэдлэг, зан үйлийн журам, тухайн талбайд тусгайлан зориулсан эрсдэлийн сургалт.
- **Барилга угсралтын үе шатны сургалт:** Техник технолог, байгаль орчин, нийгэм, ХАБЭА зэрэг сэдвүүдийг хамарч, талбайн байнгын үйл ажиллагаанд тохируулан яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангана.

Бүх сургалтууд нь ДБ-ны БОНМС, дотоодын дүрэм журам, төслийн тусгай шаардлагуудыг дагаж мөрдөхөд чиглэнэ.

9. Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ)³

9.1. Төслийн үндэслэл

“Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр” төслийн нэг хэсэг болох “Сэлбэ голын авто замын дэд төсөл” нь дэд бүтцийг сайжруулах замаар түгжрэлийг бууруулж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, уур амьсгалд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх

³ Эх сурвалж: (1) БОНМТ – Сэлбэ голын авто зам, СТП зөвлөхүүд бэлтгэсэн; Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө, (2) ТХГ-аас өгсөн агуулгатай.

зорилготой юм. Тус дэд төслийн хүрээнд Улаанбаатар хотын төвд 2.7 км зам тавих бөгөөд Сүхбаатар дүүргийн 7, 11, 12, 13 дугаар хороог хамарна. БНХАУ-д бүртгэлтэй олон улсын авто замын барилгын компани болох Zhongfu Construction Engineering Co., Ltd 2025 оны 07 дугаар сараас 2026 оны 10 дугаар сар хүртэл уг ажлыг хийж гүйцэтгэнэ.

9.2. Талуудын оролцоог хангах төлөвлөгөөний зорилго

Энэхүү ТОХТ-нд төслийн мөчлөгийн хугацаанд оролцогч талуудтай ил тод, хүртээмжтэй, байнгын харилцаа холбоо тогтоох гүйцэтгэгчийн стратегийг тодорхойлсон.

- Холбогдох оролцогч талуудыг тодорхойлж, талуудын оролцооны стратегийг тохируулах;
- Мэдээллийг эрт, тасралтгүй байдлаар хуваалцахад дэмжлэг үзүүлэх;
- Үр дүнтэй СГБМ хэрэгжүүлэх;
- Нийгмийн эрсдэлийг удирдахад дэмжлэг үзүүлэх.

ТОХТ нь Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандарт БОНС10 болон Монгол Улсын хууль тогтоомжтой нийцэх шаардлагатай.

9.3. Хууль эрхзүй, бодлогын цар хүрээ

Тухайн төлөвлөгөө нь дараах бичиг баримттай нийцэж байх шаардлагатай:

- Дэлхийн банк БОНС10 – Талуудын оролцоог хангах төлөвлөгөө;
- Хотын хөгжлийн хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Авто замын тухай хууль.

9.4. Нийгмийн нөхцөл байдал, мэдрэмтгий хүлээн авагч

Сүүлийн үеийн судалгаанд (2018–2023) төслийн бүсийн нийт хүн ам 39,844 (2022) бөгөөд 53% нь эмэгтэйчүүд байна. Тус бүс нь хүн ам зүйн хувьд залуучууд ихтэй (18-аас доош насны 35%), орлогын түвшин багаас дунд зэрэг, ажилгүйдэл 5.7%-тай байна. VII хороо бүрэн хотжсон бол үлдсэн хороод нь дэд бүтэц хязгаарлагдмал, гэр хорооллоос бүрддэг.

Мэдрэмтгий хүлээн авагчид:

- Хучилтгүй замын дагуу оршин сууж байгаа иргэд (тоос шороо, чичиргээнд өртөх);
- Сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвүүд замаас 100м зайд байрладаг;

- Өрх толгойлсон эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өнчин хүүхдүүд
- Замын гарцнаас хамааралтай аж ахуй, нэгж;
- Явган хүний зам, гэрэлтүүлэг, тэмдэг, тэмдэглэгээгүй газруудаар явж буй явган зорчигчид.

Гол эрсдэлүүд нь агаар болон дуу чимээний бохирдлын их байх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын асуудал, түр хугацааны хязгаарлалттай нэвтрэх нөхцөлүүд орно. Орон нутгийн иргэдийн, ялангуяа хүүхэд, ахмад настнуудын аюулгүй байдалд онцгой анхаарах шаардлагатай.

9.5. Оролцогч талуудын бүлэг

Оролцогч талуудыг дараах байдлаар бүлэглэнэ:

- Шийдвэр гаргагч: Дэлхийн банк, ТХН, Засаг даргын Тамгын газар;
- Инженерийн болон техникийн түнш: Эрчим хүч, харилцаа холбоо, ариутгах татуурга, усны үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд;
- Төрийн байгууллага: Нийслэлийн газар, хороо, дүүргийн тамгын газар;
- Шууд нөлөөлд өртөх хүмүүс: Зам дагуу амьдарч буй оршин суугчид, сургууль, аж ахуй, нэгж, эрүүл мэндийн төвүүд;
- Эмзэг бүлэг: Өндөр настан, өрх толгойлсон эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүд;
- Онцгой байдлын үйлчилгээ: Цагдаа, түргэн тусламж, гал түймэр, онцгой байдлын алба хаагчид;
- Олон нийт: Зам хэрэглэгчид болон олон нийт.

9.6. Оролцооны арга зүй, үйл ажиллагаа

Олон сувгийн аргаар хүртээмжтэй харилцаа холбоо явуулах бололцоотой байдаг. Дараах үйл ажиллагаа багтсан байдаг:

- Нийтэд мэдээлэл хүргүүлэх: Хорооны байр, дэлгүүр, худгийн байранд ажил эхлэхээс 3-5 хоногийн өмнө байрлуулсан байна;
- Айл, аж, ахуй нэгжээр орох: шууд нөлөөлөлд өртсөн хүмүүст чиглэсэн зорилтот үйл ажиллагаа;
- SMS болон утсаар сэрэмжлүүлэг хүргүүлэх: Хуваарьт өөрчлөлт орох эсвэл яаралтай тусламжийн тасалдлын талаар цаг тухайд нь мэдэгдэх;
- Олон нийтэд мэдээлэл өгөх уулзалт: Барилгын ажлын явцад болон шаардлагатай үед нь зохион байгуулах;
- Хэвлэмэл материал: Тойрог уулзвар, үзүүлэх нөлөөллийг харуулсан хоёр хэл дээр боловсруулсан товхимол, газрын зураг;

- Дижитал платформ: Вэбсайт (www.usut.mn , www.ulaanbaatar.mn) болон сошиал медиа хуудсууд дээр (Тухайлбал: УХТАЗТТ, хорооны хуудас) мэдээлэл оруулах.

9.7. Оролцогч талуудын зураглалыг дараах байдлаар ангилж байна:

- Шийдвэр гаргагч: Дэлхийн банк, ТХН, Засаг даргын Тамгын газар;
- Инженерийн болон техникийн түнш: Эрчим хүч, харилцаа холбоо, ариутгах татуурга, усны үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд;
- Төрийн байгууллага: Нийслэлийн дүүргийн газар, хорооны ажилтан;
- Шууд нөлөөлд өртөх хүмүүс: Оршин суугчид, аж ахуй, нэгж, байгууллага;
- Эмзэг бүлэг: Өндөр настан, өрх толгойлсон эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүд;
- Онцгой байдлын үйлчилгээ: Цагдаа, түргэн тусламж, гал түймэр, онцгой байдлын алба хаагчид;
- Олон нийт: Зам хэрэглэгчид болон олон нийт.

9.8. Мэдээллийг цаг тухайд нь, хүртээмжтэй хүргэх боломжоор хангах оролцооны стратеги, харилцааны хэрэгсэл:

- Хэвлэмэл мэдэгдэл:Барилгын ажил эхлэхээс өмнө 3-5 хоногийн өмнө хороодын байр, худаг, нийтийн эзэмшлийн талбайд байрлуулах;
- Хаалганаас хаалганд хүрч ажиллах: Нөлөөлөлд өртсөн айл өрх, бизнес эрхлэгчидтэй биечлэн харилцах;
- Мессеж, утсаар мэдээлэл хүргүүлэх: Яаралтай тасалдал, өөрчлөлтийн тухай мэдэгдэх;
- Олон нийтийн хурал: Барилгын ажил эхлэхээс өмнө болон барилгын ажлын явцад асуулт хариултын хэсгийг оруулах;
- Товхимол, танилцуулга: Тойрог уулзвар, ажил явагдах хэсгийгт харуулсан хоёр хэлээр боловсруулсан материал боловсруулах;
- Онлайн платформ: Төслийн вэбсайт болон нийгмийн сүлжээний суваг ашиглах.

9.9. Талуудын оролцооны хуваарь

Хүснэгт 15. Оролцооны хуваарь

Оролцогч талууд	Арга	Хугацаа	Хариуцах
Оршин суугчид	Уулзалт, өрхөөр очих, тараах материал тараах	Барилгын ажлын өмнө болон явцад	Нийгмийн мэргэжилтэн

Аж ахуй, нэгж	Тараах материал, цахимаар мэдээллэх	Барилгын ажлын өмнө болон явцад	Нийгмийн мэргэжилтэн
Эмзэг бүлэг	Хороо, нийгмийн ажилтантай хамтран ажиллах	Барилгын ажлын өмнө болон явцад	Нийгмийн мэргэжилтэн
Төрийн байгууллагууд	Албан бичиг, цахим шуудан илгээх	Шаардлагатай тохиолдолд	Төслийн мэргэжилтэн
Иргэний нийгмийн байгууллагууд/ Хэвлэл мэдээлэл	Мэдээлэл өгөх, дижитал мэдээллийн товхимол	Зарим тохиолдолд	Нийгмийн мэргэжилтэн
Онгой нөхцөлд үзүүлэх үйлчилгээ	Аюулгүй ажиллагааны зааварчилгаа, албан ёсны мэдэгдэл	Тухайн үйл ажиллагаанаас өмнө	ХАБЭА хариуцсан ажилтан

9.10. Санал, гомдол барагдуулах механизм (СГБМ)

СГБМ нь олон нийтийн итгэлийг хүлээх амин чухал хэрэгсэл бөгөөд оролцогч талуудад санал, хүсэлтээ нууцаар илэрхийлж, цаг тухайд нь шийдвэр гаргуулах боломжийг олгодог.

Санал, хүсэлт илэрхийлэх суваг:

Лавлах утас (24/7): 91999692, Нийгмийн мэргэжилтэн

Facebook Chatbot: Нэмэх бололцоотой.

Санал, гомдлын хайрцаг: Хороон дээр долоо хоног бүр санал, гомдол цуглуулна.

Талбайн нийгмийн мэргэжилтэн: Биечлэн тусламж авах боломжтой.

Имэйл, онлайн платформ: ТХН болон төслийн талбайгаар дамжуулан

Утасны дугаар: 11-11, 1800-1200

Хүснэгт 16. Шийдвэрлэх хугацаа

Үе шат	Хариуцах	Үйл ажиллагаа	Хугацаа
Анхлан хянах	Гүйцэтгэгч / Хорооны удирдлага	Хүлээн авах, бүртгэх, бага хэмжээний асуудал бол шийдвэрлэх	Ажлын 2 хоногийн дотор
Дараачийн шатанд хүлээн авах байгууллага	Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)	Шалгах, засч залруулах арга хэмжээг санал болгох	Ажлын 10 хоногийн дотор
Эцсийн шийдвэр	Засаг даргийн тамгийн газар	Дээд түвшний хяналт шалгалт	Ажлын 30 хоногийн дотор

Хууль эрх зүйн арга хэмжээ	Шүүхийн байгууллага	Дээрх сувгуудаар шийдэгдээгүй бол	Хуулийн хугацаанд үндэслэн
----------------------------	---------------------	-----------------------------------	----------------------------

9.11. Гүйцэтгэгчийн хүлээх хариуцлага

Гүйцэтгэгч: ТОХТ боловсруулах, СГБМ-ыг хариуцах, талуудыг татан оролцуулах;

Хороо: Мэдээлэл түгээх, өргөдөл гомдол гаргахад туслах;

ТХН: ТОХТ/СГБМ-д хяналт тавих, чиг хандлагад дүн шинжилгээ хийх;

Нийслэлийн удирдлага: Ирсэн гомдлыг шийдвэрлэх.

9.12. ТОХТ-нд хяналт-шинжилгээ хийх

ТОХТ-ний талаарх тараах материалыг дараах сувгуудаар хүргэнэ:

- **Цахим хуудас:** www.usut.mn, www.ulaanbaatar.mn ;
- **Facebook:** <https://www.facebook.com/share/p/1GSbMGLAJK/?mibextid=wwXIfr>
- Нөлөөлөлд өртсөн хороодын нийтийн удирдлага;
- Иргэдийн хурал.

ТОХТ-ний гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийх:

- Оролцогч талуудын харилцаа;
- Санал, гомдолд дүн шинжилгээ хийх, хариу өгч өгөх хугацаа;
- Санал, гомдолд нийцүүлэн хэрэгжүүлэх аргаа өөрчлөх

Хяналт-шинжилгээ нь оролцогч талуудын санал хүсэлт, гомдлын чиг хандлага, шийдвэрлэсэн хугацааг хамруулна. Үр дүн нь мэдээлэл харилцааны арга барилд шаардлагатай өөрчлөлт оруулахад ашиглагдана.

Гүйцэтгэгчийн холбоо барих мэдээлэл

Гүйцэтгэгчийн нэр: Жонфу Констракшн Инженеринг ХХК

Хаяг:

Утас: 91999692, Нийгмийн мэргэжилтэн

Имэйл: zhongfucons@gmail.com

Энэхүү Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ) нь байнга шинэчлэгдэх баримт бичиг бөгөөд оролцогч талууд, Хяналтын Зөвлөх болон ТХН-ийн зөвлөлдсөний дагуу шинэчлэгдэнэ.

10. Санал, гомдол барагдуулах механизм (Олон нийтийн ба Ажилчдын)⁴

Санал, гомдол барагдуулах механизм (СГБМ) нь оролцогч талууд, тухайлбал нөлөөлөлд өртсөн иргэд, ойр хавийн оршин суугчид болон бусад сонирхогч талуудад төсөлтэй холбоотой асуудлын талаар санал, гомдол гаргах хүртээмжтэй, хариу өгөхүйц арга замыг хангах зорилготой юм. СГБМ нь Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ)-ний шаардлагын дагуу ил тод байдлыг нэмэгдүүлж, асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэх, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэнэ.

Зорилго

- Гомдол гаргах, шийдвэрлэх нээлттэй, хүртээмжтэй, ил тод үйл явцаар хангах;
- Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг эрт илрүүлж, цаг алдалгүй шийдвэрлэх;
- Хариуцлагыг бэхжүүлж, оролцогч талууд болон төслийг хэрэгжүүлэгчдийн харилцааг сайжруулах.

Хүснэгт 17. Гол зарчим

Зарчим	Тайлбар
Нээлттэй & энгийн байдал	Ойлгоход хялбар, олон хэл дээр ашиглах боломжтой, хэрэглэгчдэд ээлтэй, олон төрлийн хандах сувгуудтай систем.
Үл ялгаварлан гадуурхах	Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, өндөр настан, залуус, хөгжлийн бэрхшээлтэй болон бусад эмзэг бүлгийн иргэдийг багтаасан тэгш хүртээмжийг хангах.
Мэргэжлийн түвшинд зохицуулах	Гомдол хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх чиг үүрэг бүхий сургагдсан ажилтнууд.
Ил тод байх	Бүх гомдол болон шийдвэрлэсэн арга хэмжээг системтэйгээр баримтжуулж, тайлагнана.
Суралцах & Сайжруулах	СГБМ-ийн мэдээллийг төслийн удирдлага болон талуудын оролцоог тасралтгүй сайжруулахад ашиглана.

Гомдлын төрлүүд

Нийтлэг гомдлын төрлүүд:

- Барилгын үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилт болон агаарын бохирдол;
- Тоног төхөөрөмжийн дуу чимээ, доргилт;
- Замын хөдөлгөөний саатал эсвэл зам хаасан;
- Үл хөдлөх хөрөнгө рүү нэвтрэх орц, явган хүний гарц хаасан;

⁴ Эх сурвалж: ТХН-ийн бэлтгэсэн СГБМ.

- Гүйцэтгэгчийн ажилтнуудын зохисгүй үйлдэл, харьцаа;
- Төслийн үр өгөөж ба үйлчилгээг хүртээгүй.

Хүснэгт 18. Гомдол гаргах сувгууд

Оролцогч талууд дараах механизмаар гомдол гаргаж болно:

Суваг	Тайлбар
24/7 холбогдох утас, чатбот	Гүйцэтгэгч ажиллуулна; дуудлага, мессеж хэлбэрээр гомдлыг шуурхай хүлээн авна. Холбоо барих утас: 91999692, Нийгмийн мэргэжилтэн
Талбайн Нийгмийн мэргэжилтэн	Гомдол гаргагчдад биечлэн туслаж, гомдлын маягт бөглөхөд дэмжлэг үзүүлнэ.
Санал, гомдлын хайрцаг (Хороонд байршуулсан)	Хорооны байранд байрлуулна; долоо хоног бүрийн Пүрэв гарагийн 09:00 цагт цуглуулна.
ТХН-ийн онлайн платформууд	Албан ёсны вэбсайт эсвэл цахим шуудангаар өргөдөл, гомдол хүлээн авна.
НЗДТГ-ын утас	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын олон нийттэй харилцах хэлтэс нь нийтийн гомдлыг хүлээн авах хоёр лавлах утсыг тогтмол ажиллуулдаг.

Хавсралт 6-аас гомдол гаргах стандарт маягтыг үзнэ үү.


Хүснэгт 19. Гомдлыг шийдвэрлэх үйл явц

Үе шат	Хариуцагч байгууллага	Үйл ажиллагаа	Хугацаа
1	Гүйцэтгэгч/ Хороон захиргаа	Гомдлыг хүлээн авч бүртгэнэ; боломжтой бол орон нутагт шийдвэрлэнэ; шийдэгдээгүй тохиолдолд СГБМ-ыг дагаж мөрдөнө.	Ажлын 2 хоногийн дотор
2	Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)	Шийдэгдээгүй гомдлыг шалгаж, засч залруулах арга хэмжээ авахыг даалгана.	Ажлын 10 хоногийн дотор
3	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Нарийн төвөгтэй эсвэл шийдэгдээгүй асуудлыг авч үзэх; шаардлагатай тохиолдолд олон талт уулзалтыг зохион байгуулах.	Ажлын 30 хоногийн дотор

4	Шүүх	Бусад механизм үр дүн өгөөгүй тохиолдолд хуулийн дагуу шийдвэрлэх.	Хуулийн хугацаанд үндэслэн
---	------	--	----------------------------

Хүснэгт 20. Үүрэг, хариуцлага

Байгууллага	Үүрэг
Гүйцэтгэгч	Холбоо барих утас, чатботыг ажиллуулах; Нийгмийн мэргэжилтэн томилох; Санал, гомдлыг цуглуулах; Талбай дээр асуудлыг шийдвэрлэх; СГБМ-ийн тайлан бэлтгэх
Хороон захиргаа	Гомдлыг биечлэн хүлээн авахад туслах; оршин суугчдад гомдлын маягт бөглөхөд дэмжлэг үзүүлэх; гомдлыг ТХН-д уламжлах.
Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)	СГБМ-ийн хэрэгжилтэд хяналт тавих; Өгөгдлийг бүртгэх; Хүлээн авсан гомдлыг шалгах; Засч залруулах арга хэмжээний талаар шийдвэр гаргах; Чиг хандлага буй эсэхийг хянах.
Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Шийдэгдээгүй асуудлыг дахин авч үзэх; өндөр түвшний талуудын уулзалтыг зохион байгуулах.
Шүүх	Хамгийн сүүлчийн арга хэлбэр болгон хуулийн дагуу шийдвэр гаргах.



Зураг 10. СГБМ

Хяналт тавих, Тайлагнах

ТХН нь СГБМ-ийн ажиллагаа, үр нөлөөг хянаана. Гүйцэтгэгч нь ТХН-д сар бүр СГБМ-ын тайланг хүргүүлэх үүрэгтэй.

Сар бүрийн тайланд доорх мэдээллийг заавал тусгана:

- Хүлээн авсан гомдлын тоо болон ангилал;
- Шийдвэрлэгдсэн байдал болон шийдвэрлэсэн хугацаа;
- Хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ;
- Хандлага, дахин давтагдаж буй асуудлууд болон сургамж.

Хүснэгт 21. Ажилчдын гомдол шийдвэрлэх механизм

Энэхүү үйл явц нь зөвхөн ажилтнуудад хамаарах ба Гүйцэтгэгчийн дотоод гомдол шийдвэрлэх системийн дагуу хэрэгждэг.

Алхам алхмаар хэрэгжүүлэх үйл явц

<i>Хэрэгжүүлэгч</i>	<i>Арга хэмжээ</i>
<i>Ажил олгогч</i>	Гомдол, санал эсвэл хүсэлтийг ажлын талбайд байрлуулсан тусгай гомдлын хайрцгаар дамжуулан гаргана.
<i>Нийгмийн мэргэжилтэн</i>	Гомдлын хайрцагнаас 14 хоног тутамд мэдээллийг авч шалган, бүртгэлд бүртгэнэ.
<i>Хүний нөөцийн менежерт мэдэгдэх</i>	Гомдол, санал, хүсэлтийг Хүний нөөцийн менежерт шилжүүлнэ.
<i>Хүний нөөцийн менежер</i>	Асуудлыг авч үзээд шаардлагатай бол удирдлагын багт шилжүүлэн шийдвэрлүүлнэ.
<i>Шийдвэрийн мэдэгдэл</i>	Хүний нөөцийн менежер тухайн ажилтанд гарсан үр дүн эсвэл шийдвэрийн талаар мэдээлнэ.

11. Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө (ОБҮАХАХТ)

11.1. Оршил

Энэхүү **Онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах төлөвлөгөөнд (ОБҮАХАХТ)** барилгын ажлын явцад үүсэх онцгой байдлын нөхцөл байдлыг зохицуулах ерөнхий стратеги, үүрэг хариуцлага, протокол зэргийг тусгасан. Онцгой байдлын үед **(Тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, нүүрсустөрөгч асгарах гэх мэт)** авах хариу арга хэмжээний нарийвчилсан задаргааг **Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөнд (ОБҮАХАХТ)** тусгасан болно – **Хавсралт 7-г үзнэ үү.** ОБҮАХАХТ-нд тухайн нөхцөл байдлын тусгай журам, хариуцах талууд, тухайн цаг хугацаанд нь авах хариу арга хэмжээ, Дэлхийн Банкны БОНС4-ын шаардлага (Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал) болон дотоодын хууль тогтоомжид нийцсэн арга хэмжээг тусгасан байдаг. **Анхны тусламж, эмнэлгийн яаралтай тусламжийн төлөвлөгөө:** Энэхүү төлөвлөгөөнд эмнэлгийн яаралтай тусламжийг газар дээр нь үзүүлэх, гэмтсэн ажилчдыг тогтворжуулах, эмнэлгийн байгууллагад хүргэх, анхны тусламжийн багийн үүрэг хариуцлагыг тодорхойлсон байдаг. Үүнд: мэргэшсэн ажилтнуудын жагсаалт, анхны тусламжийн хэрэгсэл, эмнэлгийн байршил, яаралтай тусламжийн үед холбоо барих хүмүүсийн жагсаалт зэргийг багтаасан байна. **(Хавсралт 7.1-ийг үзнэ үү.)**

Шинээр үүссэн эрсдэл, осол гэмтэл, зохицуулах шаардлага, сургамж, бодит хариу арга хэмжээний үр дүнд үндэслэн шаардлагатай тохиолдолд тухайн бичиг баримтыг шинэчилж байна.

11.2. Онцгой байдлын бэлэн байдал

Төслийн хүрээнд аюулын системтэй үнэлгээ хийх, онцгой нөхцөл байдлын төлөвлөгөө гаргах, байнгын хяналт шалгалт хийх, тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх, байнгын сургалт явуулах замаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахад нэн тэргүүнд анхаарна. Онцгой байдлын бэлэн байдлын арга хэмжээнд дараахь зүйлс орно:

Аюул, эрсдлийн үнэлгээ: Болзошгүй аюулыг тодорхойлох, шаардлагатай нөлөөллийг бууруулах зорилгоор тухайн талбайд онцгой байдлын эрсдэлийн үнэлгээ (химийн, гал түймэр, үер, осол гэх мэт) хийнэ.

Инженерийн болон захиргааны хяналт: Хамгаалах сав, дохиолол, унтраах систем, гал унтраагч, бодис асгарах үед хэрэглэх багц, зориулалтын цуглуулах цэг зэргийг хянана.

Талбайн стандарт практикт дараахь зүйлс багтана:



Бараа материалын хяналт: Бүх аюултай материалыг хянаж, шалгах боломжтой бараа материалын бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ.

Хадгалалт: Материалын аюулгүй байдлын мэдээллийн хуудас (MSDS)-ийн дагуу хадгалж, химийн найрлагаар нь ангилна.

Устгах: Бохирдсон болон аюултай материалыг устгахдаа Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын шилдэг туршлагыг баримтална.

Өдөр тутам хийгдэх яриа: Ажил эхлэхийн өмнөх хийгдэх ярианд нь онцгой байдлын бэлэн байдал, аюулгүй ажиллагааны соёл, бодис асгарах/гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар хамарна.

Ажилчдад зориулсан яаралтай тусламжийн карт:

Ажилчин бүр яаралтай тусламжийн хувийн карттай байна. Үүнд:

- Яаралтай үед холбоо барих хүн (талбайн ОБУАХАХТ, орон нутгийн үйлчилгээ, цагдаа, НЗДТГ-ын Онцгой байдлын газар)
- Онцгой байдлын үед авах үндсэн арга хэмжээ
- Нүүлгэн шилжүүлэх журам болон цугларах цэгийн байршил

Эрх баригчидтай зохицуулалт хийх:

Онцгой байдлын үед авах бүх арга хэмжээг ОБЕГ, НЗДТГ-ын Онцгой байдлын газар болон бусад холбогдох орон нутгийн онцгой байдлын албын үйл ажиллагаатай уялдуулж, тогтмол хянана.

Онцгой байдлын сургуулилт:

Онцгой байдлын сургуулилтыг (гал түймэр, бодис асгарах, нүүлгэн шилжүүлэлт, аюулгүй ажиллагааны аюул) улирал тутам, иж бүрэн нүүлгэн шилжүүлэх сургуулилтыг жил бүр ирц, үр дүнгийн баримт бичиг үйлдэж хийнэ.

11.3. Үүрэг, хариуцлага

ОБУАХАХТ хэрэгжүүлэх ажилтан, тэдний үүрэг, хариуцлага:

Тухайн газарт тохиолдсон онцгой байдлын үед хариу арга хэмжээ авахын тулд Онцгой байдлын баг (ОБУХАХАБ) байгуулж, сургана. Тухайн багтай холбоо барих хаягийг ажлын талбай, аюул бүхий агуулахын ойролцоо, яаралтай тусламжийн самбар дээр байрлуулна.

ОБУАХАХТ-ийн гол боловсон хүчин ба үүрэг хариуцлага:

Төслийн менежер:

- ОБУАХАХТ хэрэгжүүлэх хангалттай нөөцөөр хангана.
- Онцгой байдлын үед хяналтын зөвлөх баг болон гадны байгууллагад мэдэгдэнэ.
- Онцгой байдал хариуцсан төрийн байгууллагуудтай харилцах ажлыг удирдан явуулна.

Аюулгүй ажиллагаа хариусан инженер:

- Барилгын ажлын бүх үе шатанд ОБУАХАХТ-ний үйл ажиллагааг зохицуулах
- Бий болж буй эрсдэлд тулгуурлан онцгой байдлын явцыг хянаж, шинэчлэх

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн (ХАБЭА):

- ОБУАХАХТ боловсруулах, хөтлөх, улирал тутам сургуулилт хийх
- Бодис асгарсан тохиолдолд хариу арга хэмжээ авах шаардлагатай багаж хэрэгсэл, гал унтраах хэрэгслийг бэлэн байлгах
- Зөрчлийг хянан шалгаж, залруулах арга хэмжээ авах

Байгаль орчны мэргэжилтэн (БОМ):

- Тухайн талбайтай холбоотой байгаль орчны онцгой байдлын (бодис асгарах, хог хаягдал) асуудлыг зохицуулах
- Бодис асгарахаас хамгаалах материал байгаа, шошготой, хүртээмжтэй байгаа эсэхийг шалгаарай
- Хог хаягдлын менежментийн системтэй уялдаа холбоотой ажиллах

Нийгмийн мэргэжилтэн (НМ):

- Олон нийтэд тулгарах эрсдэл, эрүүл мэндийн асуудлуудыг ОБУАХАХТ -д тусгасан эсэхийг хянах
- ОБУАХАХТ-ний сургалтанд оролцох, олон нийтэд онцгой байдлын үеийн талаар мэдлэг, мэдээлэл өгөх

Бүх ажилчин болон туслан гүйцэтгэгч:

- Сургалтанд хамрагдах, аливаа осол, гэмтлийг мэдээлэх
- Бодис асгарах/гал түймрийн үед авах хариу арга хэмжээг дагаж мөрдөх
- Нүүлгэн шилжүүлэх зам болон цугларах цэгийг мэддэг байх
- Туслан гүйцэтгэгчид гэрээгээр тавьсан шаардлагын дагуу ОБУАХАХТ-ийн бүх үйл ажиллагааг дагаж мөрдөх.

11.4. Үүсэж болох онцгой байдлын нөхцөл

Төслийн талбай, тээврийн коридорт дараах болзошгүй онцгой байдлын нөхцлүүд тодорхойлогдсон байна:

- Гал түймэр эсвэл дэлбэрэлт
- Химийн бодис асгарах эсвэл түлш алдагдах
- Хөдөлмөрийн осол, гэмтэл эсвэл нас баралт
- Байгалийн гамшиг (үер, газар хөдлөлт, аянга)
- Аюултай ачаатай холбоотой зам тээврийн осол
- Олон нийтийн эрүүл мэндийн онцгой байдал (жишээ нь, халдварт өвчний дэгдэлт)
- Аюулгүй байдлын заналхийлэл
- Гэнэтийн олдвор (археологийн/соёлын олдвор)

Тухайн нөхцөл бүрт тохирсон хариу арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, хариу арга хэмжээг зохицуулагчийг тодорхойлсон байна.

11.5. Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний явц

Анхны тусламж, эмнэлгийн хариу арга хэмжээ:

- Бүх ажилтнууд анхны тусламж үзүүлэх сургалтад хамрагдана
- Нэг ажлын хэсэгт гэрчилгээтэй анхны тусламжийн нэг ажилтан
- Анхны тусламжийн багц нь бүх ажлын байр, тээврийн хэрэгсэлд байна.

Бодис асгарах, гал гарсан үед хариу арга хэмжээ авах:

- Бага хэмжээгээр бодис асгарах: шингээгч болон ХХХ ашиглан хянах
- Их хэмжээгээр бодис асгарах: бодис асгарахаас хамгаалах хэрэгсэл ашиглах, ОБУАХАБ болон эрх бүхий байгууллагад мэдэгдэх
- Аюул бүхий агуулах бүх цэгт гал унтраах хэрэгслийг хадгалах
- Гал унтраах сургалтыг улирал тутам зохион байгуулах, сургуулилтад хамруулах

Нүүлгэн шилжүүлэх журам:

- Нүүлгэн шилжүүлэх газрын зураг, цугларах цэгийг үзүүлэх
- Ажилчдыг зориулалтын цэгт цуглуулах
- Удирдах ажилтнуудын дуудлага, хариуцлагын шалгалт
- Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг багтаасан яаралтай тусламжийн сургуулилт

Орон нутгийн аюулгүй байдлын онцгой байдал:

- Барилгын ажлын багийн ахлагч удирдаж талбайу үйл ажиллагааг зогсоох буюу нүүлгэн шилжүүлэх
- Хууль сахиулах байгууллагатай уялдаа холбоотой ажиллах
- Шаардлагатай гэж үзвэл зайлшгүй биш ажилчдыг түр нүүлгэн шилжүүлэх

Яаралтай тусламж:

- "Бүх зүйл тодорхой" гэж зарлах хүртэл ОБУАХАБ хариуцна.
- Зөвлөхөөс зөвшөөрөл авсны дараа л үйл ажиллагаагаа үргэлжлүүлж болно.

11.6. Ослын шалгалт, баримтжуулалт

Стандарт тайлангийн форматыг ашиглан бүх тохиолдлыг шууд бүртгэдэг.

Шалгалтын явцад дараах зүйлсийг тодорхойлно:

- Үндсэн шалтгаанууд
- ОБУАХАХТ-ний үр дүнтэй байдал
- Сургалт, тоног төхөөрөмжийн дутагдал

Тайланг Зөвлөх болон холбогдох байгууллагуудтай хуваалцах болно.

11.7. Сургалт

Сургалтад бүх боловсон хүчний хамрагдах бөгөөд дараах сэдвийг багтаана:

- Онцгой байдлын төрөл, аюулыг тодорхойлох
- Хариу арга хэмжээ авах журам, нүүлгэн шилжүүлэх сургуулилт
- ХХХ-ны хэрэглээ, арчилгаа
- Асгарсан бодисыг цэвэрлэх, гал унтраах
- Соёлын өвийн гэнэтийн олдворын журам
- Харилцааны протокол ба тайлан
- СГБМ-ийн журам

Дараах давтан сургалт явагдана:

- ОБУАХАТ-ний сургалт улирал тутам
- Бүх ажилтнуудад жил бүр
- Ослын дараа шууд

Сургалтын бүртгэл, ирцийн хуудас, сэдэв зэргийг хөтөлж, сар бүр хүргүүлнэ.

11.8. Хяналт тавих, Тайлагнах

Хяналтын үйл ажиллагаанд дараах ажил багтана:

- Асгарсан бодис/галын багц, тэмдэглэгээ, дохиоллын системд сар бүр үзлэг хийнэ
- Сургалтын оролцоо, дасгалын тайланг хянах
- Аюулгүй байдал, ослын хариу арга хэмжээ авахтай холбоотой ажилчид болон олон нийтийн гомдол

Үзүүлэлт, амжилтын шалгуур:

- Их хэмжээний асгаралт, гал түймэртэй холбоотой ослыг тэглэх
- Онцгой байдлын сургуулилтыг хуваарийн дагуу 100% хийсэн
- ОБУАХАХТ-ний шинэчлэлтийг хагас жил тутамд эсвэл тохиолдлын дараах байдлаар хийдэг
- Өргөдөл гомдлын 95%-ийг 30 хоногийн дотор шийдвэрлэсэн

Тайланд тавигдах шаардлага:

- Хяналтын зөвлөх багт сар бүр ОБУАХАХТ-ний тайланг хүргүүлэх
- Бүх сургалт, сургуулалт, ослын баримт бичиг
- Аливаа томоохон өөрчлөлт, ослын дараа шинэчлэгдсэн ОБУАХАХТ-г илгээнэ

11.9. ОБУАХАХТ-ний хэрэгжилт, хяналтын хуваарь

Хүснэгт 22. ОБУАХАХТ-ний хэрэгжилт, хяналтын хуваарь

Огноо/ Давтамж	Үйл ажиллагаа	Хариуцсан этгээд	Тайлбар
Барилгын ажил эхлэхийн өмнө	Аюул болон эрсдэлийн албан ёсны үнэлгээ хийх, үр дүнг баримтжуулах	Гүйцэтгэгч	ОБУАХАХТ-г нарийвчлан боловсруулах суурь мэдээлэл
Барилгын ажил эхлэхийн өмнө	Онцгой байдлын хариу арга хэмжээний карт боловсруулж, бүх ажилчдад тараах	Гүйцэтгэгч	Онцгой байдлын харилцах холбогдох утас, мөрдөх журмыг багтаана
Барилгын ажил эхлэхийн өмнө	Онцгой байдлын хариу арга хэмжээний баг (ОБХАХБ) байгуулж, үүрэг хариуцлагыг хуваарилах	Гүйцэтгэгч	Гишүүдийг сургаж, холбоо барих мэдээллийг талбай дээр байрлуулах

Барилгын ажил эхлэхийн өмнө	ОБУАХАТ-г Монгол Улсын Онцгой байдлын байгууллагууд (ОБЕГ, Нийслэлийн Онцгой байдлын газар)-ын санал, зөвлөмжтэй уялдуулах зөвлөлдөх	Гүйцэтгэгч	Харилцаа холбооны протоколыг баталгаажуулах
Сар бүр (1 дүгээр сараас эхлэн)	Яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, асгаралтын багц, галын хорын үзлэг хийх	Гүйцэтгэгч	Нөхцөл айдлыг баримтжуулж, тайлагнах
Сар бүр	Гомдлыг утас, чатбот, талбайн нийгмийн ажилтан болон хорооны хайрцгаар хүлээн авч, бүртгэх	Гүйцэтгэгч	Сар бүрийн СГБМ-ийн тайланг бэлтгэж, ТХН-д хүргүүлэх
Улирал тутам (3 сар тутамд)	Гал түймэр, асгаралт, нүүлгэн шилжүүлэлт, аюулгүй байдлын заналхийллийн сургуулилалт зохион байгуулах	Гүйцэтгэгч	Олон нийттэй харилцах сувгийн туршилтыг багтаана
Улирал тутам	Сургамж, зохицуулалтын өөрчлөлтөөс шалтгаалан ОБУАХАТ-г шинэчлэх	Гүйцэтгэгч	Хяналтын зөвлөхөд шинэчлэлтийг хүргүүлэх
Улирал тутам	Онцгой байдлын багийн гишүүдэд мэдлэг сэргээх сургалт зохион байгуулах	Гүйцэтгэгч	Сургалтын ирцийн бүртгэл хөтлөх
Жил бүр	Бүх ажилтныг хамарсан нүүлгэн шилжүүлэх сургуулилалт явуулах	Гүйцэтгэгч	Сургалтын ирцийг бүртгэх
Ослын дараа нэн даруй	Ослыг мэдээлэх, мөрдөн шалгах, баримтжуулах, арга хэмжээ авах	Гүйцэтгэгч	Үр дүнг холбогдох байгууллагад танилцуулах
Тасралтгүй (өдөр тутам / долоо хоног бүр)	Өдөр тутмын ХАБЭА, аюулгүй ажиллагааны товч мэдээлэл өгөх	Гүйцэтгэгч	Аюулгүй байдлын соёлыг бэхжүүлэх
6 сар тутам	СГБМ-ийн үр нөлөө, шийдвэрлэсэн хугацааг үнэлж, шаардлагатай бол журмыг өөрчлөх	ТХН/ Гүйцэтгэгч	Илэрсэн дүнг ТХН-ийн сар тутмын тайланд тусгах
Тасралтгүй	ОБУАХАТ-ний журмыг туслан гүйцэтгэгчдээр мөрдүүлэх	Зөвлөх, ТХН	Гэрээний нөхцлөөр дамжуулан мөрдүүлэх

СГБМ-ийн хураангуй (Олон нийтийн ба Ажилтнуудын):

ОБУАХАХТ нь ажилчид, нөлөөлөлд өртсөн төслийн бүсийн иргэдийн гомдол шийдвэрлэх механизмыг багтаасан. Ажилчид нь гомдлоо гүйцэтгэгчийн нийгмийн ажилтан, Хүний нөөцийн менежерийн хариуцсан дотоод гомдол хүлээн авах хайрцгаар дамжуулан гаргаж болно. Төслийн бүсийн иргэд нь гомдлоо утас, чатбот, талбайн ажилтан эсвэл хороон захиргаагаар дамжуулан гаргах боломжтой. Бүх гомдлыг бүртгэж, шийдвэрлэж, сар бүр ТХН-д тайлагнана. Гомдлын маягтыг **Хавсралт 6-д** үзүүлэв.

11.10. СГБМ-ийн үйл явц, шийдвэрлэх хуваарь

СГБМ-ийн үйл явц нь дараах алхмуудыг багтаана:

1. Хүлээн авах ба бүртгэх

- a. Гомдлыг утас, чатбот, биечлэн, имэйл, эсвэл хорооны гомдлын хайрцгаар дамжуулан гаргаж болно.
- b. Гүйцэтгэгч эсвэл хорооны захиргаа гомдлыг бүртгэж, СГБМ-ийн мэдээллийн санд оруулна.
- c. Хугацаа: Ажлын 2 хоногт

2. Урьдчилсан үнэлгээ ба дотооддоо шийдвэрлэх

- a. Боломжтой тохиолдолд гүйцэтгэгч газар дээр нь гомдлыг шийдвэрлэнэ.
- b. Хэрэв шийдвэрлэж чадахгүй бол ТХН-д шилжүүлнэ.

3. ТХН-ийн шалгалт

- a. ТХН нь гомдлыг шалгаж, засч залруулах арга хэмжээ авахыг зааварлана.
- b. Хугацаа: Ажлын 10 хоногт

4. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлэх

- a. Нарийн төвөгтэй эсвэл шийдэгдээгүй гомдлыг олон талт оролцоотойгоор шийдвэрлүүлэхээр шилжүүлж болно.
- b. Хугацаа: Ажлын 30 хоногт

5. Хуулийн байгууллагаар шийдүүлэх (шаардлагатай тохиолдолд)

- a. Хэрэв шийдвэрлэж чадахгүй бол гомдол гаргагч шүүхэд хандаж болно.

Үүрэг ба Хариуцлага:

- **Гүйцэтгэгч:** Гомдол хүлээн авах сувгуудыг ажиллуулах; талбай дээр шийдвэрлэх; сар бүр тайлагнах.
- **Хорооны захиргаа:** Иргэдийн гомдлыг хүлээн авахад туслах; ТХН-д дамжуулах.
- **ТХН:** СГБМ-ийг бүхэлд нь удирдах; шийдвэрлэлт болон мэдээллийн бүртгэлийг хангах.
- **Нийслэлийн Засаг даргын Тамгын газар:** Шийдэгдээгүй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх.
- **Шүүхийн байгууллага:** Эцсийн хууль эрх зүйн шийдвэр гаргах.

Бүх үе шат баримтжуулах ёстой. Сар бүрийн тайланд гомдлын тоо, ангилал, шийдвэрлэх хугацаа, авсан арга хэмжээ болон давтагдах хандлагыг тусгаж, тогтмол сайжруулалтад ашиглана.

Хавсралт 7.2: Гүйцэтгэгчийн дотоод онцгой нөхцөлд ажиллах журам

Хавсралт 7.2-д Гүйцэтгэгчийн дотоод онцгой нөхцөлд авах хариу арга хэмжээний баримт бичиг болох “Онцгой нөхцөлд ажиллах журам”-ыг оруулав. Уг хавсралт нь гал, химийн бодисын алдагдал, тэсрэлт болон бусад ноцтой ослын үед баримтлах дотоод журам, үүрэг хариуцлага, хэрэгсэл, нүүлгэн шилжүүлэх протокол, талбайн зохион байгуулалтын дэлгэрэнгүй зааврыг агуулна. Тус баримт бичиг нь Монгол Улсын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагатай нийцсэн ч Гүйцэтгэгч нь энэхүү төлөвлөгөөний үндсэн хэсэгт заасан ОБУАХАХТ-ний өргөн хүрээний журмыг хэрэгжүүлж, Дэлхийн банкны Байгаль орчин, Нийгмийн Стандарт (БОНС2, БОНС4) болон төслийн БОНМТ-ний шаардлагад нийцүүлэх үүрэгтэй. Хавсралт 7.2 нь талбайн лавлагаа байдлаар ашиглагдах бөгөөд ОБУАХАХТ-гд заасан үүрэг хариуцлагыг орлохгүй.

11.11. КОВИД-19-ийн хариу арга хэмжээний төлөвлөгөө

11.11.1 Зорилго

Энэ нь төслийн ажилчид, төслийн бүсийн иргэдийн дунд КОВИД-19-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, халдварыг хянах, хариу арга хэмжээ авах, эрүүл мэндийн эрсдэл, үйл ажиллагааны саад бэрхшээлийг багасгах зорилготой юм.

11.11.2 Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

- Ариун цэвэр: гар угаах цэг, гар ариутгагчийг талбай болон оффисуудад байрлуулах.
- Хаалттай орчинд ба хүн хоорондын зай барих боломжгүй газруудад маск заавал хэрэглэх.
- Ажилчид, зочдод өдөр бүр эрүүл мэндийн үзлэг хийж, биеийн халуун хэмжих.
- Ажлын ба завсарлагааны үеэр хүн хоорондын зай барих журмыг мөрдүүлэх.
- Талбайд зөвхөн шаардлагатай ажилтнуудыг нэвтрүүлэх.

11.11.3 Хариу арга хэмжээний журам

- КОВИД-19 сэжигтэй эсвэл батлагдсан тохиолдлын протокол, тусгаарлалт, эмнэлэгт шилжүүлэх, холбогдох хүмүүстэй холбоо тогтоох.
- Шинж тэмдэг илэрсэн, ойрын хавьтал болсон талаар мэдээлэх сувгууд.
- Нөлөөллийн хэсэгт түр хугацаагаар ажлыг зогсоох эсвэл өөрчлөх.

11.11.4 Сургалт явуулах, мэдээлэл түгээх

- КОВИД-19 аюулгүй байдлын талаарх тогтмол багийн уулзалт хийх, мэдээлэх.
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, шинж тэмдгийн тухай самбар, тэмдэглэгээ.

11.11.5 Эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах

- Шинжилгээ, вакцинжуулалт, бүртгэгдсэн тохиолдлын менежментийн хүрээнд төслийн бүсийн эрүүл мэндийн газартай хамтран ажиллах.

11.11.6 Хяналт тавих, тайлагнах

- КОВИД-19-тэй холбоотой үйл явдал, авсан арга хэмжээг бүртгэн тайлагнах.
- Засгийн газрын заавар, тахлын нөхцөл байдлын дагуу төлөвлөгөөг шинэчлэх.

12. Замын хөдөлгөөн, явган хүний аюулгүй байдлын менежмент

Сэлбэ голын авто замын дэд төслийн барилгын ажлын үеэр замын хөдөлгөөн, явган хүний аюулгүй байдал нь онцгойлон анхаарах асуудал байна. Барилгын ажил нь түр хугацааны замын түгжрэл, хөдөлгөөний саатал үүсгэн, ажилчид болон төслийн бүсийн иргэдэд аюулгүй байдлын эрсдэл учруулж болно. Гүйцэтгэгч нь Монгол Улсын хууль журам, Дэлхийн банкны Байгаль орчин, Нийгмийн Стандарт (ялангуяа БОНС4), холбогдох олон улсын заавар, зөвлөмжийн дагуу эдгээр нөлөөллийг бууруулахын тулд Замын хөдөлгөөн, явган хүний аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэгтэй. **Иж бүрэн Хөдөлгөөн зохион байгуулалтын төлөвлөгөө (ХЗБТ)-г Хавсралт 3-г оруулав.**

Гол аюулгүй байдлын арга хэмжээнүүд нь:

- Барилгын ажлыг эхлүүлэхийн өмнө талбайн **Түр Хөдөлгөөн Зохион Байгуулалтын Төлөвлөгөө (ТХЗБТ)** боловсруулах, хэрэгжүүлэх;
- Гүйцэтгэгчээс хөдөлгөөн зохицуулагчийг тусгайлан томилох;
- Ажлын бүсийг тодорхой тэмдэг, тэмдэглэгээ, хаалт, гэрэлтүүлгээр хангах;
- Явган зорчигч, унадаг дугуй, тээврийн хэрэгслийн аюулгүй нэвтрэх замыг байгуулах;
- Ажилчид, хөдөлгөөн зохицуулагчид хувийн хамгаалах хэрэгсэл (XXX)-ийг хэрэглэх;
- Оргил цагийн үеэр ачааллаас зайлсхийхийн тулд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хуваариар зохицуулах;
- Зам хаах, чиглэл өөрчлөх талаар төслийн бүсийн захиргаа, иргэдтэй зөвлөлдөх;
- Түргэн тусламжийн автомашин, нэн шаардлагатай үйлчилгээний нэвтрэх замыг хамгаалах;
- Тодорхой тайлагнах, хариу арга хэмжээний журмын дагуу зам тээврийн ослыг хянах.

Гүйцэтгэгчийн ТХЗБТ нь талбайн замын хөдөлгөөний урсгалын стратеги, эгнээ хаах болон чиглэл өөрчлөх газрын зураг, тэмдэг, тэмдэглэгээний стандарт, осолд хариу арга хэмжээ авах болон олон нийтэд мэдээлэх журмыг агуулна. Энэ төлөвлөгөөг зам барилгын ажил эхлэхээс өмнө Нийслэлийн Зам хөгжлийн газар, Замын цагдаагийн газар,


Нийтийн тээврийн бодлогын газар, Замын хөдөлгөөний удирдлагын төв, Захиалагчийн төлөөлөгч, Хяналтын зөвлөх, ТХН болон бусад холбогдох талууд хянаж, батална.

Сэлбэ голын авто зам нь байршлын хувьд баруун талаараа голын сав газар, үерийн хамгаалалтын далан, зүүн талаараа орон сууцны бүс, олон тооны айл өрх, хашаа байшин, барилга байгууламж бүхий нэлээд хүндрэлтэй байршилд байрлах тул байна. Одоо байгаа далангийн дагуух шороон зам нь үерийн хамгаалалтын зориулалттай бөгөөд олон нийтийн хөдөлгөөнд ашиглах зориулалтгүй ч ойр хавийн оршин суугчид хэрэглэж байна. Сэлбэ голын авто замын трассын дагуу байрлах тул одоогоор голыг ямар ч хэсгээр гатлах боломжгүй байна. Тиймээс зам барилгын ажлын явцад бусад замтай огтлолцох цэг харьцангуй цөөн бөгөөд зөвхөн зайлшгүй шаардлагатай газарт түр зам, уулзварууд гаргана.

Гүйцэтгэгч нь авто замын барилгын ажлын дараах хоёр хэсэг хуваан гүйцэтгэхээр төлөвлөсөн:

- Хэсэг-1. Зай. 0+000 ~1+860 хоорондох хэсэг – Өмнөд хэсэг,
- Хэсэг-2. Зай. 1+860 ~2+667.386 хоорондох хэсэг – Хойд хэсэг.

Гүйцэтгэгчийн түр кэмпийг Зай. 2+340-ийн зүүн талд байрлуулахаар төлөвлөсөн.



Зураг 11. Барилгын ажлын хэсгүүд – ТХЗБТ-ний хэсгүүд

Хүснэгт 23. Сэлбэ голын авто замын төслийн зам хаах хураангуй төлөвлөгөө

No	Байршил	Урт, м	Дэд хэсгийн ажлыг гүйцэтгэх хугацаа /өдөр/	Зам хаах огноо	Зам хаах хугацаа /хоног/	Зам хаах үеэр хийгдэх ажил	Тайлбар
1	0+000~0+280	280	7	7/10/2026	2	Суурь, хучилт, тулц ханын ажлыг гүйцэтгэнэ.	Түр зам тавих боломжгүй хэсэг.
2	0+280~0+340	60	5	7/13/2026	2	Уулзварын хэсэгт газар шорооны ажил, суурь болон хучилтын ажлыг хийнэ.	Гол замтай огтлолцсон дөрвөн замын уулзвар – түр зам барих боломжгүй хэсэг.
3	0+340~1+860	1520	30	8/15/2025	5	Замын трассын дагуух цахилгааны болон усны шугамыг хамгаалах, шилжүүлэх ажил хийнэ.	
4	0+925	30	3	8/27/2025	1	Хөндлөн өнгөрч буй агаарын цахилгааны шугамыг хамгаална.	
5	1+580~2+160	30	18	8/25/2025	2	Өндөр хүчдэлийн шугамын хамгаалалтын ажил хийнэ.	
6	0+360, 1+550, 1+910	90	18	8/15/2025	3	Бороо, гадаргын ус зайлуулах шугам (хөндлөн шугам).	
7	1+395, 1+575, 1+780; 1+790, 1+880~1+970, 2+250	-	28	8/10/2025	6	Замын хөндлөн шуудууны ухмалын ажил.	Агаарын цахилгааны шугамтай


							ОГТЛОЛЦСОН ХЭСЭГ
8	1+485, 2+340, 2+420	-	46	8/15/2025	6	Ус зайлуулах хоолой суурилуулахын тулд замыг бүрэн хаана.	

Тайлбар: Хугацаа нь батлагдсан ажлын төлөвлөгөө болон бусад шалтгаанаас хамаарч өөрчлөгдөж болзошгүй. Зам хаах бодит өдөр, цаг нь зөвхөн барилгын төлөвлөгөө, хуваарийг талууд баталсны дараа тодорхой болно.

Зам хаахаас өмнө Захиалагч, холбогдох байгууллагуудаас зөвшөөрөл авч, төслийн бүсийн иргэдэд урьдчилан мэдээлэл өгнө.

**Хэсэг 2: Хойд хэсгийн Хөдөлгөөн зохион байгуулалтын төлөвлөгөө – Урт 807 м,
Зай. 1+860 – 2+667 (807)**

Зай. 1+860 ~ 2+667.386 хоорондын хэсгийн барилгын ажлыг эхэлж гүйцэтгэхээр төлөвлөсөн. Энэ хэсгийн ихэнх газрын чөлөөлөлт хийгдсэн тул явган зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн харьцангуй бага байна. Трассын дагуу зөвхөн түр зам ашиглах бөгөөд бусад иргэдийн хөдөлгөөнийг саадгүй зохион байгуулах бүрэн боломжтой. Зам хаах бодит өдөр, цаг нь зөвхөн барилгын ажлын төлөвлөгөө, хуваарийг талууд баталсны дараа тодорхой болно. Энэхүү тайлангийн дараагийн бүлгүүдэд хэсэг тус бүрийн хөдөлгөөн зохион байгуулалтын төлөвлөгөөний зураг багтсан болно.



Зураг 12. ТХЗБТ-ний жишээ зураг

Хэсэг 1: Өмнөд хэсгийн Хөдөлгөөн зохион байгуулалтын төлөвлөгөө - Урт 1860 м, Зай. 0+000-1+860 (1860 м)


Зай. 0+000 ~ 0+300 хооронд түр зам байгуулах боломжгүй тул одоо байгаа асфальтбетон замыг нэг урсгалтайгаар ашиглах боломжтой. Хучилтын ажил хийх, замыг бүрэн хаах шаардлагатай тохиолдолд, зам хаах зөвшөөрлийг холбогдох байгууллагуудаас авсны дараа иргэдэд урьдчилан мэдэгдэж, хэсэгчлэн хааж нээх зохицуулалт хийгдэнэ. Зай. 0+300 ~ 0+330 хэсэг нь одоо ашиглагдаж буй “Их тойруу” замтай нэг түвшинд огтлолцоно. Энэ цэг дээр дөрвөн замын уулзвар байгуулна. Одоо байгаа замтай нэг түвшинд холбогдож байгаа тул Их тойруугийн замын хөдөлгөөнд саад учруулахгүй. Зай. 0+330 ~ 0+640 хэсэгт шинээр баригдсан нэг урсгалтай замыг барилгын ажил болон тухайн бүсийн иргэдийн зорчих хөдөлгөөнд ашиглахаар төлөвлөсөн. Зай. 0+640 ~ 2+667.34 хоорондох хэсэгт төлөвлөсөн замын дагуу түр зам байгуулах бүрэн боломжтой. Харин эцсийн уулзвар болох Зай. 2+667.34 цэгт зам нь одоо байгаа Дарь-Эх ~ 7-н буудлын замтай нэг түвшинд огтлолцох тул зөвхөн өргөтгөлийн ажил хийгдэнэ. Энэ хэсэгт дамжин өнгөрөх хөдөлгөөн байхгүй. Зай. 0+910 ~ 1+100, Зай. 1+160 ~ 1+360, Зай. 1+660 ~ 1+820, Зай. 1+900 ~ 2+030 хооронд төлөвлөгдсөн туслах замуудыг эхний үе шатанд барьж ашиглалтад оруулж болно. Учир нь эдгээр туслах замын газар чөлөөлөлт бүрэн хийгдсэн бөгөөд зураг төсөлд тусгагдсан тул замыг барьж, хөдөлгөөнийг нэвтрүүлэх бүрэн боломжтой.

13. Хог хаягдал, Аюултай материалын менежмент

13.1. Оршил

13.1.1. Зорилго

Энэхүү Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө (ХХМТ) нь Сэлбэ голын авто замын дэд төслийн барилгын ажлын үеэр үүсэх бүх төрлийн хог хаягдлыг зөв зохистой зохицуулах зорилготой. Энэ нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн шаардлага, Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн стандартад (БОНС) болон Дэлхийн банкны Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамжид (БОЭМАБ-ын удирдамж)-ийн нийцсэн болно.



ХХМТ нь Гүйцэтгэгчийн Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний (Г-БОНМТ) нэг дэд төлөвлөгөө бөгөөд барилгын ажлын явцад хог хаягдал үүсэх, устгахтай холбоотой байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад чиглэнэ.

13.1.2. Хамрах хүрээ

Энэхүү төлөвлөгөө нь Сэлбэ голын авто замын дэд төслийн барилгын ажлыг гүйцэтгэх явцад хог хаягдал үүсэх, үүссэн хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаанд оролцож буй Гүйцэтгэгч, бүх туслан гүйцэтгэгчид хамаарна.

13.2. Хууль эрх зүй, бодлогын хүрээ

13.2.1. Олон улсын стандартууд

- **Дэлхийн банкны БОНС3:** Нөөцийг үр ашигтай ашиглах ба бохирдлоос урьдчилан сэргийлэх, менежмент – Хог хаягдлыг хамгийн бага түвшинд ялгаруулах, дахин ашиглах, дахин боловсруулах болон аюултай ба аюулгүй хог хаягдлыг аюулгүйгээр устгах шаардлагыг тодорхойлдог.
- **Дэлхийн банкны БОНС4:** Нийгмийн эрүүл мэнд ба аюулгүй байдал – Орон нутгийн иргэдийг аюултай материалд өртөх эрсдлийг бууруулах, онцгой байдлын бэлтгэлийг хангахыг шаарддаг.
- **Дэлхийн банкны БОЭМАБ-ын Удирдамж (Бүлэг 1.6 Хог хаягдлын менежмент):** Аюултай болон аюулгүй хог хаягдлыг зохицуулах, хог хаягдлын шатлал, тээвэрлэлтийн аюулгүй байдлын талаар нарийвчилсан зааварчилгааг агуулдаг.

13.2.2. Монгол Улсын хууль эрх зүйн хүрээ

- **Хог хаягдлын тухай хууль (2017 он, 2022 онд нэмэлт, өөрчлөлт орсон):** Хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах болон устгах үйл ажиллагааг зохицуулдаг. Хог хаягдлын өмчлөл, гэрээний үүргийг онцлон тодорхойлдог.

- **Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль (2022):** Аюултай хог хаягдал, хорт бодисын хэрэглээ, хадгалалт, тээвэрлэлт болон ашиглалтыг зохицуулдаг.
- **Эрүүл ахуйн тухай хууль (2022):** Байгаль орчны нөлөөллийн хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийг хамааруулан зохицуулдаг.
- Хог хаягдлыг устгах, хогийн цэгийн ажиллагаа, хог хаягдлын ангилалтай холбоотой холбогдох Засгийн газрын тогтоол, сайдын тушаалууд.

13.2.3. Гүйцэтгэгчийн үүрэг, хариуцлага

Гүйцэтгэгч нь дээр дурдсан бүх хууль тогтоомж, стандартуудыг бүрэн мөрдөх үүрэгтэй. Төслийн хэрэгжилтийн явцад хууль эрх зүйн орчинд өөрчлөлт орсон тохиолдолд тухайн шинэчлэлийг ХХМТ-нд тусган, яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай.

13.3. Байгууллагын бүтэц ба үүрэг, хариуцлага

Хүснэгт 24. Гол үүрэг, хариуцлага

Үүрэг	Хариуцлага
Төслийн менежер	Хог хаягдлын менежментийн бүх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах; нөөцийн хуваарилалтыг хангах; Байгаль орчны мэргэжилтэн, Нийгмийн мэргэжилтэн, ХАБЭА-н мэргэжилтэний ажлыг хянах.
Байгаль орчны мэргэжилтэн	ХХМТ боловсруулах, шинэчлэх, хэрэгжүүлэх; өдөр тутмын үзлэг шалгалт хийх; ажилчдад сургалт явуулах; холбогдох баримт бичгийг хөтлөх.
Нийгмийн мэргэжилтэн	Хог хаягдлын талаарх оролцогч талуудын гомдлыг шийдвэрлэх; харилцаа холбоо болон сургалтыг зохион байгуулах.
ХАБЭА-н мэргэжилтэн	Хог хаягдалтай харьцах үеийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах; кэмпиин аюулгүй байдлыг зохицуулах; аюулгүй байдлын бүртгэл хөтлөх.
Нийт ажилчид	Хог хаягдлыг ангилан ялгах, хадгалах, боловсруулах журам мөрдөх; сургалтад идэвхтэй хамрагдах; осол, зөрчлийг мэдээлэх.

13.4. Хог хаягдлын менежментийн зарчим, шатлал

ХХМТ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хог хаягдлын шатлалыг баримтална. Үүнд:

1. **Бууруулах** – Эх үүсвэр дээр хог хаягдлыг хамгийн бага хэмжээнд үүсгэх.
2. **Дахин ашиглах** – Боломжтой тохиолдолд материалыг олон удаа ашиглах.
3. **Дахин боловсруулах** – Дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж, боловсруулах үйлдвэрт илгээх.
4. **Устгах** – Үлдэгдэл хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй аргаар зайлуулах.

Энэхүү шатлал нь Монгол Улсын “Хог хаягдлын тухай хууль”, Дэлхийн банкны БОНСЗ болон БОЭМАБ-н удирдамжтай нийцэж байна.

13.5. Хог хаягдлын төрөл, ангилал, хадгалалт, устгал

Доорх ангилал нь Дэлхийн банкны БОНСЗ, Монгол Улсын “Хог хаягдлын тухай хууль”-д нийцсэн болно:

Хүснэгт 25. Хог хаягдлын ангилал

Хог хаягдлын төрөл	Тодорхойлолт/Жишээ	Эх үүсвэр
Органик бус хог хаягдал	Бетон, металл хаягдал	Барилгын материалын үлдэгдэл
Аюулгүй хог хаягдал	Хүнсний хаягдал, шил, картон, хуванцар, хөнгөн цагаан лааз, дугуй	Түр кэмп, тээврийн хэрэгслийн засвар
Аюултай хог хаягдал	Зай, тос, тосолгооны материал, бохирдсон хөрс, флюоресцент чийдэн, эмнэлгийн хаягдал	Тээврийн хэрэгслийн засвар, талбайн үйл ажиллагаа, түр эмнэлэг

Хүснэгт 26. Барилгын хог хаягдлын төрөл, зайлуулах арга

Хог	Төрөл	Эх үүсвэр	Зайлуулах арга
Бетоны хаягдал	Органик бус	Барилгын ажил	Дахин боловсруулах үйлдвэр эсвэл органик бус хог хаягдлын цэгт илгээх
Металл хаягдал	Органик бус	Таслах/арматур/хэвний ажил	Цуглуулж, металл дахин боловсруулах үйлдвэрт илгээх
Хоолны хаягдал	Аюулгүй	Ажилчдын кэмп	Хотын харьяаны хатуу хог хаягдлын цэгт ангилан, илгээх
Картон, цаас	Аюулгүй	Кэмп/ Сав баглаа боодол	Цуглуулж, тусгай зөвшөөрөл бүхий дахин боловсруулах үйлдвэрт дахин боловсруулах
Пластик, хөнгөн цагаан лааз	Аюулгүй	Кэмп, оффис	Боломжтой бол дахин боловсруулах, эс бөгөөс эрх бүхий хотын харьяаны хог хаягдал цуглуулагч байгууллагаар дамжуулан зайлуулах
Хаягдал тос, тосолгооны бодис	Аюултай	Тоног төхөөрөмжийн засвар	Түр хадгалж, тусгай зөвшөөрөл бүхий аюултай хог хаягдлыг устгагч байгууллагаар устгуулах

Батерей, аккумулятор	Аюултай	Тээврийн хэрэгсэл, багаж хэрэгсэл	Хаягдал батерей цуглуулах хайрцагт хадгалж, тусгай зөвшөөрөл бүхий устгах үйлдвэрт хүлээлгэн өгөх
Бохирдсон хөрс	Аюултай	Ухмал	Тусгаарлах, иусгай зөвшөөрөл бүхий боловсруулах/устгах байгууллагаар шалгуулах, зайлуулах
Эмнэлгийн хог	Аюултай	Анхны тусламжийн цэг	Эмнэлгийн саванд битүүмжлэн, эмнэлгийн аюултай хог хаягдлыг устгах нэгж рүү илгээх

13.5.1. Талбайн хог хаягдлын ангилалт, хадгалалт

Гүйцэтгэгч нь дараах талбайн ангилалт, түр хадгалалтын үйл явцыг мөрдөнө:

- **Түр хог хаягдал хадгалах цэг нь:**
 - Тодорхой хашаа, тэмдэг, тэмдэглэгээтэй байх
 - Дараах хог хаягдалд зориулсан тусдаа хогийн сав, контейнерыг суурилуулах:
 - Дахин боловсруулах боломжтой хог (мод, хуванцар, металл)
 - Дахин боловсруулах боломжгүй хог
 - Барилгын хог хаягдал
 - Аюултай хог
 - Ус нэвтрүүлдэггүй суурь, шингэн хог хаягдлын хоёрдогч хадгалах сав, цаг агаарын нөлөөнөөс хамгаалах саравч байх
- Ажилтнуудын ойлгомжтой байлгах үүднээс хогийн сав, контейнерт **дүрст мэдээллийн арга хэрэгсэл** (жишээлбэл, зураг) ашиглах
- **Аюултай хогийг** битүүмжилсэн, шошготой саванд хадгалах; анхааруулгын тэмдэг; Материалын аюулгүй байдлын мэдээллийн хуудас авах боломж; алдагдал/урсгалыг хадгалах цэг.

Хориотой үйлдлүүд:

- Барилгын хог хаягдлыг ердийн хог хаягдалтай холих
- Аюултай хог хаягдлын бусад хог хаягдалтай холих
- Төслийг хэрэгжүүлж дууссаны дараа түр хог хаях цэгийг цэвэрлэлгүй үлдээх
- Зөвшөөрөлгүйгээр ил задгай хог хаях эсвэл шатаах

13.5.2. Шингэлтээс урьдчилан сэргийлэх, Яаралтай цэвэрлэх журам

Хог хаягдалтай холбоотой шингэлтийн байгаль орчин, эрүүл мэндийн эрсдэлийг бууруулахын тулд:

- **Шингэлтийн багц** (шингээгч материал, ХХХ, контейнер)-ыг дараах газруудад байршуулна:
 - Түр хадгалах цэгүүд
 - Түлш, тос хадгалах газрууд
 - Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний газрууд
- Аюултай хог хаягдлын бүсийн ойролцоо **Эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэл ба галт унтраагч** байрлуулах
- **Хариу арга хэмжээний протокол:**
 - Шингэлтийн эх үүсвэрийг шууд зогсоох
 - Шингэлтийн багцыг ашиглан тархалтыг хязгаарлах
 - Байгаль орчны мэргэжилтэнд мэдээлэх
 - ОБУАХАХТ-ний дагуу тохиолдлыг бүртгэн, тайлагнах
 - Зөвшөөрөгдсөн материал ашиглан талбайг цэвэрлэх
- Шингэлтэд хариу арга хэмжээ авах **сургалтыг** бүх эхлүүлэх сургалт болон давтан сургалтад оруулах
- Бүх тохиолдлыг **Хог хаягдал зайлуулах маягт ба Тохиолдлын бүртгэлд** бүртгэж, ОБУАХАХТ-ний дагуу шийдвэрлэх.

13.6. Хог хаягдалтай харьцах, хадгалах, тээвэрлэх журам

- Түр хадгалах цэгийг тодорхой тэмдэглэж, хашаалж, хогийг төрлөөр нь ангилсан байх ёстой.
- Аюултай хогийг битүүмжилсэн саванд хадгалах бөгөөд шингэлтээс сэргийлэх хоёрдогч хадгалах савтай байх.
- Талбайд хог ангилах дүрмийг хатуу сахиж, дахин боловсруулах боломжтой хог, дахин боловсруулах боломжгүй хог, аюултай хог, барилгын хогийг тусдаа саванд хадгалах.
- Шингэлтийн багц, гал унтраагч, анхны тусламжийн багцыг хадгалах газруудын ойролцоо байрлуулах.
- Бүх хог тээвэрлэх ажлыг Монгол Улсын болон олон улсын дүрэм журмын дагуу тусгай зөвшөөрөл бүхий хог хаягдлын менежментийн компаниуд хийх.
- Ил шатаах, аюултай болон аюулгүй хогийг хольж хаях, хууль бус хаягдал хаяхыг хатуу хориглоно.

13.7. Хориотой үйлдлүүд

- Барилгын хог хаягдлыг ердийн хог эсвэл дахин боловсруулах хог хаягдалтай холихгүй
- Аюултай эсвэл барилгын хог хаягдлыг зориулалтын бус цэгт хаяхгүй
- Ажил дууссаны дараа түр хог хаях цэгийг цэвэрлэж, Байгаль орчны мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.

- Хог хаягдлын менежментийн журмыг санаатай эсвэл давтан зөрчих нь дотоод журамд заасан торгууль, арга хэмжээг авахад хүргэж болно.

13.8. Сургалт явуулах ба Мэдээлэл олгох

- Бүх ажилчид хог хаягдлын менежментийн зарчим, хог хаягдал ангилах, харьцах, аюултай нөхцөлд ажиллах журмын талаар танилцуулах болон давтан сургалтад хамрагдана.
- Сургалтын бүртгэл, ирцийн хүснэгт, сургалтын материалуудыг хадгалж, аудитад бэлэн байлгана. боломжтой байна.

13.9. Хянах, тайлагнах

13.9.1 Хяналт

Байгаль орчны мэргэжилтэн нь хог хаягдлын менежментийн гүйцэтгэлийг тогтмол хянаж ажиллана. Үүнд:

- Үүссэн, ангилагдсан, дахин боловсруулсан, устгасан хогийн тоо хэмжээ.
- Хог хаягдал хадгалах, харьцах журамд нийцсэн эсэхэд хяналт тавих.
- Хог хаягдалтай холбоотой зөрчил, асгарсан тохиолдлыг шалгаж, тайлагнах.
- Хог хаягдлын менежменттэй холбоотой гомдол, саналыг хянах.

Хүснэгт 27. Үзүүлэлт ба амжилтын шалгуур

Үзүүлэлт	Амжилтын шалгуур	
Талбайн ХХМТ-г боловсруулж, батлуулах	ХХМТ-г батална	Зөвлөх
Эх үүсвэр дээр ангилсан хог хаягдлын %	$\geq 90\%$	
Хог хаягдлын алдагдал эсвэл төслийн бүсийн иргэдийн гомдлын тоо	0	
Аюултай хог хаягдалтай харьцах, зайлуулах журмын дагуу нийцэл	Бүрэн нийцэх	

13.9.3 Тайлагнах

- Сар бүрийн тайланг Зөвлөхөд хүргүүлнэ. Тайланд дараах мэдээллийг багтаана:
 - Үүссэн, дахин боловсруулсан болон устгасан хог хаягдлын тоо хэмжээ, төрөл.
 - Зохион байгуулсан сургалт, ирц
 - Аливаа алдагдал, зөрчил, засч залруулах арга хэмжээ
 - Санал, гомдлын жагсаалт, шийдвэрлэсэн байдал.

- Хог хаягдлыг зайлуулсан маягт, хог хаягдлын бүртгэлийг талбайд хадгалж, аудитад зориулан архивлах.

13.9.4. Хог хаягдлын бүртгэл

- Ахлах хэлтсийн ажилтнууд бүх барилгын болон аюултай хог хаягдал үүссэн тохиолдлыг зориулалтын маягтад бүртгэж, Байгаль орчны мэргэжилтэнд тогтмол хүргүүлнэ.
- Байгаль орчны мэргэжилтэн нь хог хаягдлын мэдээллийг сар, жилийн тайланд нэгтгэн оруулна.

13.9.5. Онцгой байдлын хариу арга хэмжээ

- Хог хаягдлын асгаралт, аюултай хогийн ялгаралтын онцгой байдлын хариу арга хэмжээний журам боловсруулж, бүх ажилтанд мэдээлнэ.
- Асгаралтын багц, онцгой байдлын хариу арга хэмжээний хэрэгслийг ямагт бэлэн байлгана.
- Хог хаягдлын асгаралтын тохиолдлыг бүртгэн, төслийн ОБУАХАТ-нд заасан арга хэмжээг шуурхай авна.

13.9.6. Бусад мэдээлэл

Хавсралт 8-аас Хог хаягдлын устгал, бүртгэлийн маягт гэх мэт бусад мэдээллийг үзэж болно.

14. Г-БОНМТ-г хэрэгжүүлэх төсөв

Анхаарна уу: Эдгээр нь гүйцэтгэгчийн санал болгож буй Ажлын тоо хэмжээнд багтсан БОНМТ-г хэрэгжүүлэх зардлууд бөгөөд гэрээний нэг хэсэг юм.

Хүснэгт 28. БОНМТ-г хэрэгжүүлэх төсөв

Тодорхойлолт	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Нийт дүн
Сургалтын өртөг				
Жил бүр хэрэгжүүлэх ESMP-ийн бүх шаардлагатай сургалтууд (ХМТ, ОБУАХАТ, ХХМТ, ТХЗБТ гэх мэт)	3	удаа	XXX	XXX
Олон нийттэй зөвлөлдөх, Талуудын оролцооны төлөвлөгөөг хэрэгжүүлэх өртөг				
Оролцогч талуудтай харилцах үйл ажиллагаа болон орон нутгийн сургалт (барилгын улиралд 2 удаа)	6	удаа	XXX	XXX
Байгаль орчны хяналтын өртөг				

Агаарын чанарын үзүүлэлт: SO ₂ , NO ₂ , TSP, PM ₁₀ , PM _{2.5} концентраци Нүдээр ажиглах (тоос шороо) (барилгын улиралд 2 долоо хоног тутам буюу 4-р сарын 15- наас 10-р сарын 15 хүртэл)	42	удаа	XXX	XXX
Дууны чимээний хэмжилт (барилгын улиралд 2 долоо хоног тутам буюу 4-р сарын 15- наас 10-р сарын 15 хүртэл)	42	удаа	XXX	XXX
Гадаргын усны чанар: (pH, EC, хатуулаг, Na, K, Ca, Mg, NH ₄ , Fe, F, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , PO ₄ , HCO ₃ , TDS, BOD, хүнд металлууд), үзүүлэлт: MNS 4943:2015 Нүдээр ажиглах (усны мутаршил) (барилгын улиралд сар бүр буюу 4-р сарын 15-наас 10-р сарын 15 хүртэл)	30	удаа	XXX	XXX
Усны олон ясгүй амьтдыг хянах (3 сард нэг удаа)	9	удаа	XXX	XXX
Хөрсний чанар: Химийн үзүүлэлтүүд (pH, давсжилт, EC, Ca CO ₃ , NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O, Mg ²⁺ , Ca ²⁺ , ширхэгийн хэмжээ) Хүнд металлууд (заавал: Zn, Cr, Pb, Cu, Ni, As, Cd) Бактериологийн үзүүлэлт Нүдээр ажиглах (хөрсний бохирдол) (барилгын улиралд сар бүр буюу 4-р сарын 15-наас 10-р сарын 15 хүртэл)	36	удаа	XXX	XXX
Хог хаягдал болон аюултай материалын менежмент (барилгын улиралд 2 долоо хоног тутам буюу 4-р сарын 15- наас 10-р сарын 15 хүртэл)	42	удаа	XXX	XXX
ОБУАХАТ-ний танилцуулга (жилд нэг удаа)	2	удаа	XXX	XXX

Барилгын улиралд зориулагдсан асгарлын хамгаалалтын тоног төхөөрөмж	1	LS	XXX	XXX
Эрүүл мэнд, аюулгүй байдлын тэмдэг тэмдэглэгээ (барилгын бүх улиралд)	1	LS	XXX	XXX
Төслийн нөлөөлөлд өртсөн иргэд, орон нутгийн иргэдэд зориулсан мэдээлэл (жилийн нэг удаа)	3	удаа	XXX	XXX
Нийт өртөг				XXX

15. Г-БОНМТ-ний шинэчлэлт, өөрчлөлт

Зорилго:

Энэ бүлэгт төслийн өөрчлөлтөд нийцүүлэн, хууль эрх зүй, зээлдүүлэгчийн шаардлагыг хангахын тулд Гүйцэтгэгчийн Байгаль орчин, Нийгмийн Менежментийн Төлөвлөгөө (Г-БОНМТ)-г тогтмол хянах, шинэчлэх, батлах журам, гэрээний үүрэг, хариуцлагыг тодорхойлсон болно.

Хяналтын давтамж, шаардлага:

Түр 2–W2 ажлын гэрээний ерөнхий нөхцлийн дагуу:

- Гүйцэтгэгч нь гэрээний хугацаанд **Г-БОНМТ-ийг хамгийн багадаа зургаан (6) сар тутамд** нэг удаа хянана.
- Хяналтын гол зорилго нь төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах, хяналтын ажил, удирдлагын арга хэмжээ нь **тухайн ажлын шатанд тохирсон, үр дүнтэй** эсэхийг баталгаажуулахад оршино.
- Шаардлагатай бол шинэ эрсдэл, талбайн нөхцөл, хууль эрх зүйн өөрчлөлт, гүйцэтгэлийн санал дээр үндэслэн Г-БОНМТ-ийг **шинэчлэх** шаардлагатай.

Шинэчлэх нөхцөл (6 сар тутмын хяналтаас гадна):

- Төслийн зураг төсөл эсвэл цар хүрээ өөрчлөгдсөн.
- Төлөвлөгөөг зөрчсөн, аудитаар асуудал илэрсэн эсвэл ноцтой гомдол хүлээн авсан.
- Хууль эрх зүйн шаардлага эсвэл Дэлхийн банкны удирдамжид нэмэлт, өөрчлөлт орсон.
- Инженер, ТХН эсвэл Эрх бүхий хяналтын байгууллагын санал, зөвлөмж.

Батлах, мэдээлэл солилцох үйл явц:

1. Хүргүүлэх:

Г-БОНМТ-ийн бүх шинэчлэгдсэн хувилбарыг албан ёсоор Төслийн менежерээр хянуулж, батлуулахаар хүргүүлнэ.

2. Баримт бичиг хөтлөх:

Шинэчилсэн хувилбар нь дараах мэдээллийг багтаасан Засварын түүхийг багтаана:

- a. Шинэчилсэн огноо
- b. Өөрчилсөн бүлгүүд
- c. Өөрчлөлтийн хураангуй
- d. Шинэчилсэн шалтгаан

3. Түгээх:

Батлагдсаны дараа:

- a. Шинэчилсэн Г-БОНМТ-ийг бүх холбогдох ажилтан, туслан гүйцэтгэгчид тараана.
- b. Сургалт, талбайн мэдээллийг шинэчилнэ.

4. Баримт бичгийг хадгалах:

Г-БОНМТ-ийн өмнөх бүх хувилбарыг батлагдсан баримтын хамтаар аудит, шалгалтад зориулан талбайн БОН-ийн баримт бичгийн архивт хадгална.